

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛЫН ТӨСӨЛ

2021 оны ... сар өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам, маягт батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Улсын секторын байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Санхүүгийн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэ тушаалыг 2021 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/, Төрийн сангийн газар /М.Батхуяг/-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, 2009 оны 192 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Сангийн сайдын 2021 оны
дугаар сарын өдрийн
.....тушаалын 1 дүгээр
хавсралт

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГАД МӨРДӨХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ЖУРАМ

АГУУЛГА

Contents

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГАД МӨРДӨХ НЯГТЛАН БОДОХ.....	2
БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ЖУРАМ	2
1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	7
1. ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ	7
2. ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ	7
3. НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО	7
4. ТАЙЛАГНАГЧ БАЙГУУЛЛАГА	9
5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЭЛЕМЕНТҮҮД	10
А. ХӨРӨНГӨ	10
Б. ӨР ТӨЛБӨР	10
В. ОРЛОГО БА ЗАРДАЛ	11
Г. ӨМЧИЙН ХУВЬ ОРОЛЦОО БА ӨМЧЛӨЛИЙН ХУВААРИЛАЛТ	11
6. САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	11
7. ХЭМЖИЛТИЙН ЗОРИЛГО, СУУРЬ	13
2. САНХҮҮГИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА	15
1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ	15
2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ЗАРЧИМ, ЕРӨНХИЙ ШИНЖ ЧАНАР	16
3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	17
4. САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	18
5. ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	19
6. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	19
7. ТӨСӨВ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮНГИЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН	22
8. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮЕ ШАТ	22
9. АНХАН ШАТНЫ БАРИМТ БА БАРИМТ ЭРГЭЛТ, ФАЙЛЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ	22
10. ДАНСНЫ ЖАГСААЛТЫН ТӨРӨЛ, КОДЛОХ ЗАРЧИМ	22
3. АРИЛЖААНЫ БОЛОН АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО	23
1. АРИЛЖААНЫ БУС ОРЛОГЫН АНГИЛАЛ	23
2. АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	24
3. АРИЛЖААНЫ АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ХЭМЖИЛТ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	27
4. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	28
5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	29
4. ЗАРДАЛ	31
1. ЗАРЛАГЫН АНГИЛАЛ	31
2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	32
3. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	34
4. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	35
4.1 ЦАЛИНГИЙН БҮРТГЭЛ	39
1. АНГИЛАЛ	40
2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	40
3. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	41
5. МӨНГӨН ХӨРӨНГӨ	43

1. ХАМРАХ ХҮРЭЭ	44
2. АНГИЛАЛ.....	44
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	45
4. ТОДРУУЛГА	45
5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	45
 6. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ	 51
1. ХАМРАХ ХҮРЭЭ	51
2. АНГИЛАЛ.....	51
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ, ХЭМЖИЛТ	52
4. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	54
5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	54
6. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	55
 7. АВЛАГА.....	 58
1. ХАМРАХ ХҮРЭЭ	58
2. АНГИЛАЛ.....	58
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	58
4. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	59
5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	59
6. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	60
 8. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО	 61
1. ХАМРАХ ХҮРЭЭ	61
2. АНГИЛАЛ.....	62
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	62
4. ТОДРУУЛГА	62
5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	63
 9. БАРАА МАТЕРИАЛ	 64
1. ХАМРАХ ХҮРЭЭ, ОНЦЛОГ	64
2. АНГИЛАЛ.....	65
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	66
4. ЗАРДАЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ	68
5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	69
6. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	70
 10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ	 75
1. ХАМРАХ ХҮРЭЭ, ОНЦЛОГ	75
2. АНГИЛАЛ.....	76
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	79
4. ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ	83
5. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	84
6. ТОДРУУЛГА	84
7. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	85
 11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ	 91
1. ХАМРАХ ХҮРЭЭ, ОНЦЛОГ, АНГИЛАЛ	91
2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	91
3. ДАРАА ҮЕИЙН ХЭМЖИЛТ	92
4. ХӨРӨНГИЙН ХОРОГДУУЛГА, АШИГЛАЛТЫН ХУГАЦАА	93

5. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	94
6. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	94
7. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	95

12. ӨР ТӨЛБӨР, БОЛЗОШГҮЙ, ӨР ТӨЛБӨР, НӨӨЦ	98
1. ХАМРАХ ХҮРЭЭ	98
1. АНГИЛАЛ.....	98
2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	99
3. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	100
4. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	100

13. САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР	103
1. АНГИЛАЛ.....	103
2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	103
3. ДАРААГИЙН ТАЙЛАНТ ҮЕИЙН ХЭМЖИЛТ	104
4. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	104
5. ТОЛИЛУУГА, ТОДРУУЛГА	105
7. САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	105

14. ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ	109
1. ХАМРАХ ХҮРЭЭ	109
2. АНГИЛАЛ.....	109
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	109
4. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	111
5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	111

15. ТҮРЭЭС	114
1. ТҮРЭЭСИЙН АНГИЛАЛ.....	114
2. ТҮРЭЭСЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТҮРЭЭС	114
3. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТҮРЭЭС	115
4. БОРЛУУЛАХ БА БУЦААН ТҮРЭЭСЛЭХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ	115
5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	116
6. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	116

16. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН, ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ, АЛДАА	119
1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО	119
2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ.....	120
3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АЛДАА	121

17. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ	122
1. ХАМРАХ ХҮРЭЭ	122
2. АНГИЛАЛ.....	123
3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ	123
4. БҮРТГЭЛИЙН ВАЛЮТААС ӨӨР ВАЛЮТЫГ ТОЛИЛУУЛГАД АШИГЛАХ	124
5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:	124

18. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ	130
1. КОНЦЕССЫН ХӨРӨНГИЙН АНГИЛАЛ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	130
2. КОНЦЕССЫН ХӨРӨНГИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ	130

3. КОНЦЕССЫН ХӨРӨНГИЙГ ХЭМЖИХ БА ҮНЭЛЭХ	131
4. ӨР ТӨЛБӨРИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ.....	131
5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	132
 19. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ	132
1. ХАМРАХ ХҮРЭЭ	132
2. ХӨРӨНГИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ, ХЭМЖИЛТ.....	133
3. ХӨРӨНГИЙН АНГИЛАЛ, ТӨРӨЛ	133
4. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА	133
 20. САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОЛИЛУУЛГА	134
1. ТӨСӨВ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮНГҮҮДИЙН ЗЭРЭГЦҮҮЛСЭН ТОЛИЛУУЛГА	134
2. ТӨСВИЙН СУУРЬ, ЦАР ХҮРЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ ТОДРУУЛГА	134
 21. ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ.....	136
22. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА	136
23. САНХҮҮГИЙН ТАЙЛАН	138

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1. ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Улсын секторын байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зорилго нь Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын дагуу байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэхэд оршино.
- 1.2 Нягтлан Бодох Бүртгэлийн энэхүү бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хууль, тогтоомж болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (цаашид УСНББОУС гэх), Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалд нийцсэн болно.
- 1.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь хэрэглэгчдийн шийдвэр гаргах хэрэгцээг хангасан, үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллийг илэрхийлэх санхүүгийн тайланг бэлтгэх хэмжээнд боловсрогдсон байх болно. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчдийг хамгийн ашигтай мэдээллээр хангаж чадахуйц санхүүгийн тайланг бэлтгэх шийдэл болно.

2. ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

- 1.4 Нягтлан бодох бүртгэлийн энэхүү бодлогыг байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан бэлтгэх үйл ажиллагаанд мөрдөнө.
- 1.5 УСНББОУС 35 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан”-ын 38 дахь параграфт “ хяналт тавигч байгууллага нь төсөөтэй нөхцөл байдал дахь ажил гүйлгээ ба үйл явдлын хувьд нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого баримталснаар нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ.” гэж заасны дагуу улсын секторын байгууллагууд нь энэхүү нэгдмэл бодлогыг ашиглана.
- 1.6 Улсын секторын тайлагнагч байгууллага /цаашид байгууллага гэх/ энэхүү журмыг байгууллагынхаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болгон ашиглана.
- 1.7 Дараах бүх шалгуурыг хангасан улсын секторын байгууллага нь УСНББОУС, энэхүү зааврыг мөрдөнө.
 - 1) Олон нийтэд үр өгөөж өгөх, орлого баялагийг дахин хуваарилах үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлага хүлээдэг;
 - 2) Засгийн газрын бусад түвшнүүдээс авах татвар, шилжүүлэг, нийгмийн даатгалын шимтгэл, өр төлбөр буюу үйлчилгээний хөлсөөр өөрсдийн үйл ажиллагааг шууд ба шууд бусаар ихэвчлэн санхүүжүүлдэг;
 - 3) Ашиг олох үндсэн зорилгогүй байх.

3. НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

- 1.8 Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан /цаашид санхүүгийн тайлан гэх/ нь өөрсдийн мэдээллийн тусгай хэрэгцээ шаардлагыг хангахын тулд санхүүгийн тайлан бэлтгэлтийг түүнд тохируулан нийцүүлэхийг шаардах чадвар,

боломжгүй тийм хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахад зориулагдсан санхүүгийн тайлан юм.

- 1.9 Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилт нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын хувьд нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой, уг тайлагнагч байгууллагын талаархи мэдээллээр хангана. Санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчид нь үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчид юм.
- 1.10 Санхүүгийн тайлан нь тухайн тайлант үеийн турш дахь уг байгууллагын санхүүгийн үр дүн, гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, түүнчлэн тайлангийн өдрөөрх түүний хөрөнгө, өр төлбөр болон тайлант үе дэх тэдгээрийн өөрчлөлт, үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилтийн талаархи мэдээллээр хангадаг.
- 1.11 Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгах мэдээллийн чанарын шинжүүд нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх гэсэн шинжүүд юм.
- 1.12 Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн нийтлэг хязгаарлалтууд нь материаллаг байдал, өртөг-өгөөж бөгөөд энэ нь чанарын шинжүүдийн хоорондох зохих тэнцвэрийг тогтоодог.
- 1.13 Санхүүгийн тайлан бэлтгэгч нь тодорхой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөх хэрэгтэй эсэх, эсхүл мэдээллийн зүйлийг тухайн байгууллагын санхүүгийн тайланд тусад нь тодруулвал зохих эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС-ын шаардлагын дагуу материаллаг байдлыг харгалзан үзнэ.
- 1.14 Мэдээллийн зүйлийг тусгахгүй орхигдуулах буюу буруу илэрхийлэх тухайн тайлагнагч байгууллагын санхүүгийн мэдээлэлд үндэслэн хэрэглэгчдийн гаргах шийдвэрт нөлөөлөхөөр байвал уг мэдээллийг материаллаг гэж үзнэ.
- 1.15 Материаллаг байдал нь байгууллага бүрийн тухайн нөхцөл байдалд харгалзан үзэж буй уг зүйлийн шинж төрөл ба дүнгийн аль алианаас хамаардаг. Иймээс тодорхой төрлийн мэдээлэл нь материаллаг байх нь нийтлэг тоон босго шалгуурыг тухайн байгууллага шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно.
- 1.16 Санхүүгийн тайлан бэлтгэгч нь тодорхой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөх эсэх, эсхүл мэдээллийн зүйлийг тухайн байгууллагын санхүүгийн тайланд тусад нь тодруулбал зохих эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС-ын шаардлагын дагуу материаллаг байдлыг харгалзан үзнэ.
- 1.17 Байгууллагын санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийн үнэн зөв илэрхийлэл, ойлгомжтой байдал буюу шалгах боломжтой байдалд сөргөөр нөлөөлж чадах эсэхийг тодорхойлохдоо тухайн зүйлийн материаллаг байдлыг харгалзан үзвэл зохино.
- 1.18 Мэдээллээр хангах өртөг зардал нь мэдээллийг олж цуглуулах ба боловсруулах зардал, мэдээллийг шалгах, арга зүйг танилцуулах зардал, мэдээллийг түгээн дамжуулах зардлаас бүрддэг.
- 1.19 Хэрэглэгчид нь санхүүгийн тайлангаар хангах мэдээллийн ихэнх үр өгөөжийг хүртдэг. Өртөг-өгөөжийн хязгаарлалтын хэрэглээ нь мэдээллийг тайлагнасны өгөөж тухайн мэдээллийг бэлтгэх ба ашиглахад гарах өртөг зардлыг зөвтгөн батлах магадлалтай эсэх үнэлгээг агуулсан байдаг. Ийм үнэлгээг хийх тохиолдолд өртөг зардлыг бууруулахын тулд нэг буюу хэд хэдэн чанарын шинжүүдийг тодорхой хэмжээгээр алдагдуулж болох эсэхийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.

4. ТАЙЛАГНАГЧ БАЙГУУЛЛАГА

- 1.20 Улсын секторын тайлагнагч байгууллага нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан бэлтгэдэг засгийн газар болон улсын секторын бусад байгууллага, хөтөлбөр буюу үйл ажиллагааны тодорхойлж болох талбар /цаашид байгууллага/ юм. Улсын секторын тайлагнагч байгууллагын гол шинж чанар нь дараах байдалтай байна. Үүнд:
- 1) Энэ нь иргэд сонгогчдоос буюу тэдний өмнөөс нөөцийг босгон бий болгож, тэдгээр иргэд сонгогчдын ач тусын төлөө эсхүл тэдний өмнөөс үйл ажиллагаа явуулахын тулд нөөцийг ашиглан зарцуулдаг байгууллага юм;
 - 2) Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилго бүхий мэдээллийн хувьд тухайн байгууллагын санхүүгийн тайлангаас хамааралтай, үйлчилгээ хүлээн авагчид буюу нөөцөөр хангагчид байдаг.
- 1.21 Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдалд тусгайлан мөрдөх УСНББОУС байхгүй тохиолдолд удирдлага нь дараах шинж нөхцөл бүхий мэдээллийг бий болгоход хүргэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулж, мөрдөхдөө өөрийн шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлийг ашиглана.
- 1.22 Байгууллага шүүн тунгаалт хийхдээ дараах дарааллаар илэрхийлсэн эх сурвалжуудыг мөрдөх боломжтой байдлыг авч үзнэ. Үүнд:
- 1) Ижил төсөөтэй ба холбоотой асуудлуудын талаарх УСНББОУС-ын шаардлагууд;
 - 2) Улсын Секторын байгууллагуудын нийтлэг зорилготой Санхүүгийн тайлагналын Онолын Үзэл баримтлал-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн шалгуур.
- 1.23 Байгууллага нь энэхүү нэгдмэл бодлогын баримт бичигт үйл ажиллагааны онцлог шинж чанар болон үйл явдлын шинж байдлаас шалтгаалан шүүн тунгаалт хийх замаар мэргэжлийн шийдлээ ашиглан холбогдох стандартаар хүлээн зөвшөөрсөн тохиолдолд дараах зүйлсийг тодруулах байдлаар нэмэлт бодлогыг боловсруулж болно. Үүнд:
- 1) Сангийн сайдын тушаалаар батлагдсан дансны зааврын хүрээнд дансныг ангилах;
 - 2) Материаллаг байдал нь байгууллага бүрийн тухайн нөхцөл байдалд харгалзан үзэж буй уг зүйлийн шинж төрөл ба дүнгийн аль алинаас хамаардаг. Иймд тодорхой төрлийн мэдээлэл нь материаллаг байх нь нийтлэг тоон босго шалгуурыг тухайн байгууллага шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно;
 - 3) Орлогын ажил гүйлгээ нь ялган тодорхойлж болох арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээний бүрэлдэхүүн хэсгүүдтэй эсэхийг тогтоохын тулд шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно;
 - 4) УСНББОУС нь тухайн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын зүйлсийг юу бүрдүүлэхийг зааж өгөөгүй тул байгууллагын тухайн тодорхой нөхцөл байдалд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хэрэглэхдээ шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно гэж заасан байдаг. Иймд стандартын заалтын дагуу тухайн санхүүгийн элементийн бүлэглэлд хамааруулан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг ангилах, хяналтын системийн талаарх асуудлыг байгууллагын бодлогодоо тодорхой заасан байна;

- 5) Үзүүлэх үйлчилгээ, худалдаа буюу бусад үйл ажиллагааг эрхлэн явуулахад тулгардаг тодорхойгүй байдлын улмаас санхүүгийн тайлан дахь олон зүйлсийг нарийн оновчтой хэмжиж чадахгүй боловч зөвхөн ойролцоогоор тооцоолж чаддаг. Тооцоолол нь хамгийн сүүлийн үеийн байдлаар бэлэн байгаа, найдвартай мэдээлэлд үндэслэн шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлохыг агуулдаг;
- 6) Тухайн байгууллагын хувьд биет хөрөнгө болон биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааны тооцоолол нь ижил төсөвтэй хөрөнгүүдийн талаарх уг байгууллагын туршлагад үндэслэн шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно.
- 7) гэх мэт

5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЭЛЕМЕНТҮҮД

- 1.24 Санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба бусад үйл явдлуудыг санхүүгийн үр нөлөөг тэдгээрийн эдийн засгийн нийтлэг шинжийг агуулсан санхүүгийн тайлангийн элементүүдээр бүлэглэн харуулдаг. Эдгээр ерөнхий ангиудыг санхүүгийн тайлангийн элементүүд гэнэ.
- 1.25 Санхүүгийн байдлын хэмжилттэй шууд холбоотой элементүүд нь хөрөнгө, өр төлбөр, өмч, өмчийн хувь оролцоо юм. санхүүгийн үр дүнгийн хэмжилттэй шууд холбоотой тайлангийн элементүүд нь орлого ба зардал

А. ХӨРӨНГӨ

- 1.26 Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага хяналтандаа оруулсан бөгөөд түүнээс уг байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болохоор хүлээгдэж буй нөөц юм.
- 1.27 Үйлчилгээний чадавхи бүхий улсын секторын хөрөнгөнд засгийн газрын ба улсын секторын байгууллагуудын эзэмшиж байгаа бөгөөд гуравдагч талд үйлчилгээ үзүүлэхийн тулд ашигладаг амралт зугаалгын, соёлын өвийн, батлан хамгаалахын болон бусад хөрөнгүүд хамаарна.
- 1.28 Байгууллага нь нөөцийг хянадаг байх ёстой. Нөөцийн хяналт нь нөөцийг ашиглах /буюу түүний ашиглалтын хувьд бусад талуудыг удирдан чиглүүлэх/, ингэснээр өөрийн үйлчилгээ үзүүлэх болон бусад зорилтуудыг биелүүлэхдээ тухайн нөөцөд агуулагдаж буй эдийн засгийн үр өгөөжийг гарган ашиглах уг байгууллагын чадварыг бүрдүүлдэг.
- 1.29 Байгууллагын одоо хянаж буй нөөц нь өнгөрсөн ажил гүйлгээ буюу өнгөрсөн бусад үйл явдлаас үүссэн байхыг хөрөнгийн тодорхойлолтоор шаарддаг.

Б. ӨР ТӨЛБӨР

- 1.30 Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд нөөцийг гадагш зарцуулах уг байгууллагын одоогийн үүргийг хэлнэ.
- 1.31 Одоогийн үүрэг нь хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг эсхүл хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг юм. Өр төлбөр үүсэхэд хүргэхийн тулд гаднын талын өмнө үүрэг хүлээсэн байх ёстой. Үүрэг үүсэхэд хүргэдэг олон хэлцэл нь төлбөр барагдуулах хугацааг тусган агуулсан байдаг.
- 1.32 Цэвэр санхүүгийн байдал нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн бусад нөөцийг нэмж, бусад үүргийг хассаны дараах хөрөнгө ба өр төлбөрийн

хоорондох зөрүү юм. Цэвэр санхүүгийн байдал нь эерэг эсхүл сөрөг үлдэх дүнтэй байж болно.

В. ОРЛОГО БА ЗАРДАЛ

- 1.33 Орлого гэдэг нь өмчлөлийн хувь оролцооноос үүссэн нэмэгдэлтээс бусад байдлаар тухайн байгууллагын цэвэр байдалд гарсан өсөлтийг хэлнэ.
- 1.34 Зардал гэдэг нь өмчлөлийн хуваарилалтаас үүссэн багасалтаас бусад байдлаар тухайн байгууллагын цэвэр санхүүгийн байдалд гарсан бууралтыг хэлнэ.
- 1.35 Байгууллагын тайлант үеийн ашиг, алдагдал нь санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан орлого ба зардлын хоорондох зөрүү юм.
- 1.36 Орлого ба зардал нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээ, хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнийн хэрэгжээгүй өсөлт болон бууралт, элэгдлээр дамжин гарах хөрөнгийн ашиглан зарцуулалт, үнэ цэнийн бууралтаар дамжин илэрхийлэгдэх үйлчилгээний чадавхийн болон эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын багасалт гэх мэт бусад үйл явдлуудаас үүсдэг.
- 1.37 Байгууллагын тайлант үеийн ашиг, алдагдал нь санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан орлого ба зардлын хоорондох зөрүү юм.

Г. ӨМЧИЙН ХУВЬ ОРОЛЦОО БА ӨМЧЛӨЛИЙН ХУВААРИЛАЛТ

- 1.38 Өмчлөлийн хувь оролцоо гэдэг нь эзэд болохын хувьд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд гаднын талуудаас оруулсан бөгөөд байгууллагын цэвэр санхүүгийн байдал дахь хувь оролцоог тогтоох буюу нэмэгдүүлэх тухайн байгууллагад орох нөөцийн орлогын гүйлгээ юм.
- 1.39 Өмчлөлийн хуваарилалт гэдэг нь эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд гаднын талуудад хуваарилсан бөгөөд байгууллагын цэвэр санхүүгийн байдал дахь хувь оролцоог буцаах буюу багасгах тухайн байгууллагаас гарах зарлагын гүйлгээ юм.
- 1.40 Өмчлөлийн хувь оролцоо нь тухайн байгууллагыг үүсгэн байгуулах үеийн нөөцийн анхны хувь оруулалт эсхүл нөөцийн дараагийн тайлант үеийн хувь оруулалт, байгууллагын бүтцийн өөрчлөлтийн үеийн хувь оруулалт хэлбэртэй байж болно.
- 1.41 Өмчлөлийн хуваарилалт нь хөрөнгө оруулалтын өгөөж, хөрөнгө оруулалтын бүрэн буюу хэсэгчилсэн буцаалт эсхүл тухайн байгууллагыг татан буулгах буюу бүтцийн өөрчлөлт хийх тохиолдолд аливаа үлдэх нөөцийн буцаалт хэлбэртэй байж болно.

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 1.42 Хүлээн зөвшөөрөлт гэдэг нь тухайн элементийн тодорхойлолтыг хангах бөгөөд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг биелүүлэх зүйлийг санхүүгийн байдлын тайланд дүрслэн илэрхийлж, эсхүл үр дүнгийн тайланд тусган оруулах үйл явц юм.
- 1.43 Хүлээн зөвшөөрөлтийн шалгуур нь дараах байдалтай байна.
 - 1) Тухайн зүйл нь элементийн тодорхойлолтыг хангах,

- 2) Чанарын шинжүүдийг биелүүлэх ба санхүүгийн тайланд тусгах мэдээллийн хязгаарлагдмал байдлыг харгалзсан тийм байдлаар хэмжиж болохоор байх.
- 1.44 Энэ нь элементийн тодорхойлолтыг хангаж буй зүйлийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө.
- 1) Тухайн зүйлтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь байгууллагад орох эсхүл түүнээс гарах нилээд их магадлалтай байх;
- 2) Тухайн зүйл нь найдвартай хэмжиж чадах өртөг буюу үнэ цэнэтэй байх.
- 1.45 Хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангасан бүх зүйлсийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.
- 1.46 Ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн урсгалд хамаарах тодорхойгүй байдлын үнэлгээг тухайн санхүүгийн тайлан бэлтгэх үед бэлэн боломжтой байгаа нотолгоонд үндэслэн хийдэг.
- 1.47 Тухайн зүйл найдвартайгаар хэмжих чадах ул үндэслэлтэй тооцоолол хийж чадахгүй тохиолдолд уг зүйлсийг санхүүгийн байдлын эсхүл үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.
- 1.48 Хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хугацааны тодорхой агшинд хангадаггүй байсан зүйл нь дараагийн тайлант үеийн нөхцөл байдал буюу үйл явдлын үр дүнд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хожим хангаж болно. Иймээс тодорхойгүй байдлыг тайлангийн өдөр бүрээр үнэлнэ.
- 1.49 Хэмжилтийн хамааралтай ба үнэн зөв илэрхийллийн талаарх шийдвэр нь тооцооллын арга зүй, түүнчлэн тайлангийн өдрөөр оршин байсан эдийн засгийн нөхцөл байдлын тухай нэмэлт нотолгоо бэлэн боломжтой байгаа эсэхийг харгалзан үздэг. Хэрэв хэмжилтийн хамааралтай ба үнэн зөв илэрхийллийг эргэлзээтэй болгохуйц нөхцөл байдалд тухайн зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй.
- 1.50 Элементийн чухал шинж чанаруудыг агуулсан боловч хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангадаггүй зүйлийг тодруулга тайланд тусгана.
- 1.51 Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт-хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь байгууллагад орох нилээд их магадлалтай бөгөөд тухайн хөрөнгө нь найдвартайгаар хэмжиж чадах өртөг буюу үнэ цэнэтэй тохиолдолд хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.
- 1.52 Эдийн засгийн үр өгөөж нь тухайн тайлант үеэс цаашхи хугацаанд уг байгууллагад орох магадлалгүй гэж үзсэн зүйлийн хувьд зарлага гарсан тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй. Харин ийм ажил гүйлгээ нь санхүүгийн үр дүнгийн тайланд зардал гэж хүлээн зөвшөөрнө.
- 1.53 Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт-одоогийн үүргийг барагдуулснаар эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлалтай бөгөөд уг барагдуулалтыг хийх дүнг найдвартайгаар хэмжиж чадах тохиолдолд өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.
- 1.54 Орлогын хүлээн зөвшөөрөлт- хөрөнгийн өсөлт эсхүл өр төлбөрийн бууралттай холбоотой ирээдүйн эдийн засгийн өгөөжийн нэмэгдэлт үүссэн бөгөөд түүнийг найдвартайгаар хэмжиж чадах тохиолдолд санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 1.55 Зардлын хүлээн зөвшөөрөлт-хөрөнгийн бууралт эсхүл өр төлбөрийн өсөлттэй холбоотой ирээдүйн эдийн засгийн өгөөжийн багасалт үүссэн бөгөөд түүнийг найдвартайгаар хэмжиж чадах тохиолдолд санхүүгийн үр дүнгийн тайланд зарлагыг хүлээн зөвшөөрнө.

- 1.56 Гарсан өртөг зардал ба олсон тодорхой орлогын хоорондох шууд хамааралд үндэслэн зардлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Зардал ба орлогын уялдуулах энэхүү процесс нь нэг ажил гүйлгээ эсхүл бусад үйл явдлуудын шууд болон хамтын үр дүн болох орлого, зардлыг нэгэн зэрэг хүлээн зөвшөөрөлтийг илэрхийлдэг.
- 1.57 Эдийн засгийн үр өгөөж нь нягтлан бодох бүртгэлийн хэд хэдэн тайлант үеийн туршид үүсэхээр хүлээгдэж байгаа бөгөөд орлоготой хамааралтай байдлыг тодорхойлж чадах тохиолдолд зардлыг системчилсэн ба ул үндэслэлтэй хуваарилалтын горимд үндэслэн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлыг хүлээн зөвшөөрөхөд ашигладаг. Ийм хуваарилалтын горим нь тухайн зүйлстэй холбоотой эдийн засгийн үр өгөөжийг ашиглан зарцуулах буюу тэдгээрийн хугацаа багасан дуусах нягтлан бодох бүртгэлийн тайлант үеүдэд зардлыг хүлээн зөвшөөрөх зорилготой.
- 1.58 Зарлага нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж бий болгохгүй болсон эсхүл ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь санхүүгийн байдлын тайланд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй буюу хангахаа больсон үед болон хангахгүй тэр хэмжээгээр зардлыг үр дүнгийн тайланд нэн даруй хүлээн зөвшөөрнө.

7. ХЭМЖИЛТИЙН ЗОРИЛГО, СУУРЬ

- 1.59 Хэмжилт гэдэг нь: санхүүгийн тайлангийн элементүүдийг санхүүгийн байдлын болон үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч, тусгах мөнгөн дүнг тодорхойлох үйл явц юм. Энэ нь хэмжилтийн тодорхой суурийг сонгох явдал юм.
- 1.60 Хэмжилтийн ялгаатай, олон сууриудыг санхүүгийн тайланд өөр, өөр зэрэг хэмжээтэйгээр, янз бүрийн байдлаар хослуулан ашигладаг. Хөрөнгийн хувьд дараах хэмжилтийн сууриуд байдаг.
- Түүхэн өртөг
 - Зах зээлийн үнэ цэнэ
 - Орлуулалтын өртөг
 - Борлуулалтын цэвэр үнэ
 - Ашиглалтын үнэ цэнэ
- 1.61 Түүхэн өртөг гэдэг нь: Хөрөнгийг олж эзэмших буюу хөгжүүлэхийн тулд төлсөн төлбөр, энэ нь түүний олж эзэмшилт буюу хөгжүүлэлтийн хугацаанд өгсөн мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгө болон бусад зүйлийн бодит үнэ цэнэ юм.
- 1.62 Хөрөнгийн хувьд одоогийн үнэ цэнийн хэмжилт нь зах зээлийн үнэ цэнэ, борлуулалтын өртөг, борлуулалтын цэвэр үнэ, ашиглалтын үнэ цэнэ гэсэн 4 суурь байна.
- 1.63 Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь: Зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийг арилжиж болох дүн юм. Нээлттэй, идэвхтэй зах зээлд тухайн хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж байгаа үед зах зээлийн үнэ цэнэ нь илүү тохиромжтой байдаг. Улсын секторын байгууллагууд нь ашиг олох үндсэн зорилго бүхий үйл ажиллагаа эрхлэн явуулдаггүй, үйлчилгээг ихэвчлэн арилжааны бус ажил гүйлгээр буюу хөнгөлттэй нөхцлөөр үзүүлдэг учраас зах зээлийн үнээс хязгаарлагдмал байдаг.

- 1.64 Орлуулалтын өртөг гэдэг нь: тухайн тайлангийн өдрөөр уг хөрөнгийн үйлчилгээний чадавхийг /үүн дотроо, байгууллага нь хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст түүний данснаас хасалтаас хүлээн авах дүнг/ орлуулахад тэрхүү байгууллагад шаардлагатай хамгийн хэмнэлттэй өртөг юм.
- 1.65 Борлуулалтын цэвэр үнэ цэнэ гэдэг нь: хөрөнгийн борлуулалтаас уг борлуулалтын өртгийг хассаны дараа тухайн байгууллагын олж авах дүн юм. Энэ нь нээлттэй, идэвхтэй, хэвийн зах зээлд, зах зээлийн үнийн тооцоолол хийхийг шаарддаггүй, тухайн байгууллагын борлуулалтыг өртгийг хамруулдаг учраас зах зээлийн үнэ цэнээс өөр юм. Тухайн байгууллагын хувьд нөөцийг зарцуулах хамгийн үр ашигтай арга нь борлуулалт байх тохиолдолд борлуулалтын цэвэр үнэ нь ач холбогдолтой.
- 1.66 Ашиглалтын үнэ цэнэ гэдэг нь: хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглавал түүний үлдэх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвараас тухайн байгууллагад орох, түүнчлэн хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст түүний данснаас хасалтаас байгууллагын хүлээн авах цэвэр дүнгийн өнөөгийн үнэ цэнэ юм. Ашиглалтын үнэ цэнийн тооцооллын нарийн цогц байдал, түүний хязгаардмал хэрэглээ мөнгө бий болгодоггүй хөрөнгийн улсын секторын үйл ажиллагаанд орлох зүйл болгон орлуулалтын өртгийг ашигладаг зэргийн харгалзан үзвэл, ашиглалтын үнэ цэнэ үйлчилгээний өртгийг тодорхойлоход ерөнхийдөө тохиромжгүй байдаг.
- 1.67 Түүхэн өртгийн загварын дагуу, хөрөнгийг түүний олж эзэмшилтийн хувьд зарцуулсан өртгөөр эхлээд тайлагнана. Зарим хөрөнгүүдийн бүрдүүлэх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвар нь тэдгээрийн ашиглалтын хугацааны туршид зарцуулагдан ашиглагдах учраас анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэхүү өртгийг тэдгээр хөрөнгийн элэгдэл буюу хорогдуулга хэлбэрээр тайлант үеүдэд зардал байдлаар хуваарилж болно.
- 1.68 Түүхэн өртгийн загварын дагуу, хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх замаар түүний дүнг бууруулж болно. Үнэ цэнийн бууралт нь хөрөнгийн ашиглан зарцуулалтад хамааралгүй эдийн засгийн болон бусад нөхцөл байдлын улмаас түүний ханган бүрдүүлэх, үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын багасан буурах хэмжээ юм.
- 1.69 Өр төлбөрийн хувьд дараах хэмжилтийн сууриудыг тодорхойлно.
- Түүхэн өртөг
 - Гүйцэтгэлийн өртөг
 - Зах зээлийн үнэ цэнэ
 - Чөлөөлөгдсөн өртөг
 - Үүрэг хариуцсаны үнэ
- 1.70 Өр төлбөрийн хувьд түүхэн өртөг гэдэг нь: өр төлбөрийг хариуцахын тулд хүлээн авсан төлбөр, энэ нь өр төлбөр үүсэх үед хүлээн авсан мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгө болон бусад зүйлийн бодит үнэ цэнэ юм.
- 1.71 Түүхэн өртгийн загварын дагуу хүүний хуримтлуулалт, хөнгөлөлтийн нэмэгдүүлэлт буюу урамшууллын хорогдуулга гэх мэт хүчин зүйлсийг тусгахын тулд анхны хэмжүүрийг тохируулж болох юм.
- 1.72 Гүйцэтгэлийн өртөг гэдэг нь: өртөг зардал хамгийн бага байхаар гүйцэтгэнэ гэж төсөөлөхөд уг өр төлбөрөөр илэрхийлэгдэж буй үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд байгууллагын зарцуулах өртөг зардал юм.

- 1.73 Өр төлбөрийн хувьд зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь: зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр өр төлбөрийг барагдуулж болох дүн юм.
- 1.74 Чөлөөлөгдөх өртөг нь үүргээс нэн даруй чөлөөлөгдөх дүнг илэрхийлдэг. Чөлөөлөгдөх өртөг нь зээлдүүлэгчийн нэхэмжлэлийг барагдуулахад түүний зөвшөөрөх дүн эсхүл зээлдэгчээс өр төлбөрийг шилжүүлэхэд гуравдагч талын зөвшөөрөх дүн байдаг.
- 1.75 Үүрэг хариуцсаны үнэ нь одоо байгаа өр төлбөрийг хариуцсаны хариуд байгууллагын ул үндэслэлтэйгээр хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа дүн юм.
- 1.76 Хөрөнгө, өр төлбөрийг анхны удаа хүлээн зөвшөөрөх буюу анхны хэмжилт мөн дараагийн тайлант үед санхүүгийн тайланд тайлагнах буюу дараагийн хэмжилтийн аль алины хувьд хэмжилтийн суурийг сонгох шаардлагатай.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

Холбогдох Улсын секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 2 Мөнгөн гүйлгээний тайлан
- Бусад УСНББОУС

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

- 2.1 Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн зорилго нь нөөцийн хуваарилалтын талаархи шийдвэрийн үнэлгээ ба шийдвэр гаргалтын хувьд янз бүрийн хэрэгчлэгчдэд ач холбогдолтой уг байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тухай мэдээллээр хангах явдал юм.
- 2.2 Байгууллагын санхүүгийн алба, эсхүл нягтлан бодогч нь жилийн болон завсрын хугацааны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлэн бэлтгэнэ.
- 2.3 Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, мөн “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” гэж тус тус заасан.
- 2.4 Байгууллагын удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар нь санхүүгийн тайланд үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг үнэн зөв, бүрэн гүйцэд тусгасан гэдгийг баталж нэмэлт мэдэгдлийг хавсарган толилуулж, тодруулан тайлбар хийсэн байна.
- 2.5 Санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна.
 - Санхүүгийн байдлын тайлан;
 - Санхүүгийн үр дүнгийн тайлан;
 - Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;
 - Мөнгөн гүйлгээний тайлан;
 - Байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулдаг тохиолдолд тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсхүл санхүүгийн тайлан

дахь төсвийн багана байдлаар харуулсан, төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлт;

- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба бусад тайлбар мэдээллээс бүрдэх тодруулга.

- 2.6 Санхүүгийн тайлангаас байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, санхүүгийн байдал зэргийг илэрхийлсэн удирдлагын тойм тайлбар, санхүүгийн шинжилгээ, нэмэлт хавсралтыг толилуулж болно.
- 2.7 Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогын хүрээнд тусгай данс бүрийн хувьд санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэгдэнэ. Эдгээр нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн удирдлагын тойм тайлбар, нэмэлт хавсралт болно. Тусгай дансад хамаарахгүй бусад зайлшгүй шаардлагатай нэмэлт тойм, тайлбарыг тухайн тайлант хугацааны санхүүгийн тайланд тусгаж болно.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ЗАРЧИМ, ЕРӨНХИЙ ШИНЖ ЧАНАР

- 2.8 Аккреул суурь: байгууллага нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад зүйлсийн хувьд санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн аккреул суурьд үндэслэн бэлтгэнэ. Энэ нь ажил гүйлгээг мөнгөөр хэрэгжсэн үед бус ажил гүйлгээ гарсан тайлант үед нь хүлээн зөвшөөрч, бүртгэж, тайлагнах зарчим юм.
- 2.9 Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал: Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг.
- 2.10 Тасралтгүй байх суурь: Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжүүлэн явуулах уг байгууллагын чадвар боломжийг үнэлэх хэрэгтэй, Удирдлага нь байгууллагыг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмаар бэлтгэнэ.
- 2.11 Толилуулгын тууштай байдал: УСНББОУС-д зааснаас бусад тохиолдолд санхүүгийн тайлан дахь зүйлсийн толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн тайлант үед тогтвортой хадгална.
- 2.12 Материаллаг байдал ба нэгтгэн нийлүүлэлт: Ижил төсөөтэй зүйлсийн материаллаг анги тус бүрийг санхүүгийн тайланд тусад нь толилуулна. Материаллаг биш байхаас бусад тохиолдолд, ижил бус шинж төрөл буюу чиг үүрэг бүхий зүйлсийг тусад нь толилуулна.
- 2.13 Мэдээллийн зохистой байх нь түүний мөн чанар, материаллаг байдлаар тодорхойлогдоно.
- 2.14 Цэвэр дүн гаргах: УСНББОУС-аар шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрөнгө ба өр төлбөр, эсхүл орлого ба зардлыг хооронд нь хаах, цэвэр дүнг гаргахгүй. Цэвэр дүн гаргалт нь ажил гүйлгээ буюу бусад үйл явдлын мөн чанарыг тусган илэрхийлэхээс бусад тохиолдолд санхүүгийн үр дүнгийн тайланд эсхүл санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнг гаргах нь а. Тухайн гарч тохиолдсон ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлыг ойлгох, б. Уг байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээг үнэлэх хэрэглэгчдийн чадвар боломжийг бууруулдаг. Хөрөнгө ба өр төлбөр, орлого ба зардлыг тус тусад нь тайлагнах нь чухал ач холбогдолтой.

- 2.15 Зэрэгцүүлэгдэх мэдээлэл: УСНББОУС нь өөрөөр шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага нь санхүүгийн тайланд тайлагнасан бүх дүнгийн хувьд харгалзах өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах хэрэгтэй.
- 2.16 Байгууллага нь хамгийн наад зах нь өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар санхүүгийн байдлын нэг тайлан, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар санхүүгийн үр дүнгийн нэг тайлан, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар мөнгөн гүйлгээний нэг тайлан, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэг тайлан болон холбогдох тодруулгыг толилуулна.

2. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

- 2.17 Төсөвт байгууллагын санхүүгийн байдлыг тодорхой хугацаагаар буюу тайлагналын өдрөөр тасалбар болгон харуулдаг тайлан нь санхүүгийн байдлын тайлан юм.
- 2.18 Улсын секторын байгууллагын санхүүгийн байдлын талаархи мэдээлэл нь тухайн байгууллагын нөөц болон тэдгээр нөөцийн нэхэмжлэлийг тайлангийн өдрөөр тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог. Энэ нь
- 1) Байгууллагын нөөцийг аюулгүй хадгалах ба удирдан зохицуулах өөрийн үүрэг хариуцлагыг удирдлага ханган биелүүлсэн хэмжээ;
 - 2) Ирээдүйд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг дэмжих бэлэн боломжтой байгаа нөөцийн хэмжээ, тэрхүү нөөцийн дүн, бүтэц бүрэлдэхүүн болон тэдгээр нөөцийн нэхэмжлэлд тухайн тайлант үеийн туршид гарсан өөрчлөлт;
 - 3) Байгууллагын нөөцийн одоо байгаа нэхэмжлэлийг хангах ба буцаан төлөхөд шаардлагатай ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн ба хугацаа гэх мэт мэдээллээр хангадаг.
- 2.19 Санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмч гэж ангилна.
- 2.20 Байгууллага хөрөнгө ба өр төлбөрийг шинж чанар, хөрвөх чадварын дарааллаар толилуулна.
- 2.21 Хөрөнгийг хөрвөх чадвараар нь эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгө гэж ангилна.
- 2.22 Хөрөнгө нь дараах шалгууруудын аль нэгийг хангах тохиолдолд түүнийг эргэлтийн хөрөнгө гэж ангилна:
- 1) тухайн хөрөнгийг хэрэгжүүлэхээр хүлээж буй эсхүл уг байгууллагын хэвийн үйл ажиллагааны циклийн явцад борлуулах ба ашиглан зарцуулахаар эзэмшиж байгаа;
 - 2) тухайн хөрөнгийг үндсэндээ худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж байгаа;
 - 3) тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор тухайн хөрөнгийг хэрэгжүүлэхээр хүлээгдэж буй; эсхүл
 - 4) тухайн хөрөнгө нь тайлант үеийн эцсээс хойш наад зах нь 12 сарын хугацаанд арилжаа гүйлгээ хийхээр эсхүл өр төлбөрийг барагдуулахаар ашиглахыг нь хязгаарлаагүй мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгө байх.
- 2.23 Өр төлбөр нь дараах шалгууруудын аль нэгийг хангах тохиолдолд түүнийг богино хугацаат өр төлбөрт ангилна:

- 1) байгууллагын үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь барагдахаар хүлээгдэж буй;
 - 2) өр төлбөрийг юуны өмнө худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж байгаа;
 - 3) тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор барагдуулах хугацаатай өр төлбөр;
 - 4) байгууллага нь өр төлбөрийн барагдуулалтыг тухайн тайлант хугацааны эцсээс хойш наад зах нь 12 сарын хугацаагаар хойшлуулах нөхцөлт бус эрхгүй байх. Харилцагч нөгөө талын сонголтоор хийгдэх ба өмчийн хэрэглүүр гаргаснаар өр төлбөрийг барагдуулахад хүргэж болох тухайн өр төлбөрийн нөхцөл нь түүний ангилалд нөлөөлдөггүй байх.
- 2.24 Байгууллага богино хугацаат өр төлбөрөөс бусад бүх өр төлбөрийг урт хугацаат өр төлбөр гэж ангилна.
- 2.25 Байгууллага нь санхүүгийн байдлын тайландаа эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгө, богино ба урт хугацаат өр төлбөрийг тусдаа ангиллууд байдлаар толилуулна.
- 2.26 Санхүүгийн байдлын тайланг санхүүгийн тайлангийн маягтын дагуу зэрэгцүүлсэн байдлаар толилуулна.
- 2.27 Хөрөнгө, өр төлбөрийн ангилал бүрийн хувьд хүлээн зөвшөөрөх, үнэлэх, данснаас хасахад баримталсан бүртгэлийн бодлогыг тодруулна.
- 2.28 Тайлант хугацааны эцэс дэх хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг дансдын бүлгээр өмнөх тайлант хугацааны үлдэгдэлтэй зэрэгцүүлсэн байдлаар харуулна.
- 2.29 Хөрөнгийн өмчлөх эрхтэй холбоотой аливаа барьцаа, эрсдлийг тодруулна.
- 2.30 Байгууллага нь санхүүгийн тайландаа аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа аудит хийлгэж, аудитлагдсан санхүүгийн тайлангаа олон нийт болон эрх бүхий байгууллагад тайлагнана.
- 2.31 Байгууллагын бүртгэлийн болон тайлагнах валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгө байна.

3. САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

- 2.32 Санхүүгийн үр дүнгийн талаархи мэдээлэл нь уг байгууллага нөөцийг хэмнэлттэй байдлаар олж авсан бөгөөд өөрийн үйлчилгээ үзүүлэх зорилтуудыг биелүүлэхийн тулд тэдгээрийг үр ашигтай ба үр дүнтэйгээр ашигладаг эсэх, гэх мэт асуудлуудын үнэлгээг тусган илэрхийлдэг. Үйлчилгээ үзүүлэх өртөг зардал болон тухайн тайлант үеийн турш дахь өртөг зардлын нөхөлтийн дүн ба эх үүсвэрийн талаархи мэдээлэл нь үйл ажиллагааны зардлыг тухайлбал, татвар, хэрэглэгчийн төлбөр, шимтгэл, шилжүүлгээр нөхсөн эсхүл уг байгууллагын өрийн хэмжээг нэмэгдүүлэх замаар санхүүжүүлсэн эсэхийг тодорхойлоход хэрэгчдэд тусалдаг.
- 2.33 УСНББОУС-д өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд, тайлант үед хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын бүх зүйлсийг ашиг, алдагдалд тусгана.
- 2.34 Санхүүгийн үр дүнгийн тайлан нь тухайн тайлант үеийн хувьд хамгийн наад зах нь дараах дүнгүүдийг толилуулах мөрийн зүйлсийг агуулсан байна:
- 1) Орлого;
 - 2) Санхүүгийн зардал;
 - 3) Өмчийн арга ашиглан тайлагнасан хараат байгууллага ба хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдал дахь хувь хэмжээ;

- 4) Зогсоосон үйл ажиллагаанд хамаарах хөрөнгийн данснаас хасалт буюу өр төлбөрийн барагдуулалтаар хүлээн зөвшөөрсөн татварын өмнөх олз, гарз;
- 5) Ашиг алдагдал.
- 2.35 Дараах зүйлсийг тайлант үеийн ашиг, алдагдлын хуваарилалт байдлаар санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулна.
- 1) Хяналтын бус хувь оролцоонд хамаарах ашиг, алдагдал;
- 2) Хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах ашиг, алдагдал.
- 5. ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**
- 2.36 Цэвэр хөрөнгө/өмч нь санхүүгийн байдлын тайлан дахь үлдэх хэмжүүрийг (хөрөнгөөс өр төлбөрийг хасах) илэрхийлнэ. Цэвэр хөрөнгө/өмч нь эерэг, сөрөг утгатай байж болно.
- 2.37 Хоёр тайлангийн өдрийн хооронд байгууллагын цэвэр хөрөнгө/өмчид орсон өөрчлөлт нь тухайн тайлант үеийн турш дахь түүний цэвэр хөрөнгийн өсөлт бууралтыг илэрхийлнэ.
- 2.38 Тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид орсон нийт өөрчлөлт нь тухайн тайлант үеийн ашиг, алдагдлын нийт дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт байдлаар шууд хүлээн зөвшөөрсөн бусад орлого ба зардлыг эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эздийн оруулсан аливаа хувь оролцоо болон тэдэнд олгосон хуваарилалтын хамт харуулна.

6. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- 2.39 Мөнгөн гүйлгээний тайлан нь тухайн тайлант үеийн туршид байгууллага хэрхэн мөнгө үүсгэн бий болгож, ашиглан зарцуулсныг, үүн дотроо түүний зээл ба зээлийн буцаан төлөлт, тухайлбал үндсэн хөрөнгийн худалдан авалт ба борлуулалтыг харуулдаг. Мөн татвар ба шилжүүлгээс хүлээн авсан мөнгө, бусад засгийн газар, засгийн газрын агентлаг буюу олон улсын байгууллагаас хүлээн авсан болон шилүүлсэн мөнгөн гүйлгээг тодорхойлдог.
- 2.40 Мөнгөн гүйлгээний тайлан нь тухайн тайлант үеийн туршид гарсан мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны гэж ангилж, тайлагнадаг.

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлагнал

- 2.41 Үндсэн үйл ажиллагаанаас үүсэх цэвэр мөнгөн гүйлгээний дүн нь тухайн байгууллагын үйл ажиллагааг дараах байдлаар санхүүжүүлсэн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлт юм.
- шууд ба шууд бус татвараар; эсхүл
 - Тухайн байгууллагын нийлүүлсэн бараа, үйлчилгээг хүлээн авагчдаар.
- 2.42 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь өөрийн одоогийн үйл ажиллагааг Засгийн газар татвар болон төлбөрөөр санхүүжүүлсэн хэмжээг илэрхийлэх үзүүлэлтээр хангадаг.
- 2.43 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь юуны өмнө тухайн байгууллагын мөнгө бий болгох үндсэн үйл ажиллагаанаас үүсдэг. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний жишээг доор дурдав.
- 1) Татвар, хураамж, торгуулиас бий болсон мөнгөн орлого;
- 2) Тухайн байгууллагын нийлүүлсэн бараа, үйлчилгээний төлбөрөөс орсон мөнгөн орлого, бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгөн төлбөр;

- 3) Буцалтгүй тусламж буюу шилжүүлэг ба төв засгийн газар эсхүл улсын секторын бусад байгууллагаас олгосон бусад хуваарилалт болон төсвийн бусад эрх мэдлээс үүссэн мөнгөн орлого;
 - 4) Эрхийн шимтгэл, төлбөр, хураамж ба бусад орлогоос бий болсон мөнгөн орлого;
 - 5) Улсын секторын бусад байгууллагуудад тэдгээрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан олгосон мөнгөн төлбөр;
 - 6) Ажиллагчдад төлсөн эсхүл тэдний өмнөөс төлсөн мөнгөн төлбөр;
 - 7) Даатгалын байгууллагын даатгалын хураамж, хохирлын төлбөр, аннуити болон даатгалын гэрээний бусад үр өгөөжийн мөнгөн орлого ба мөнгөн төлбөр;
 - 8) Үндсэн үйл ажиллагаанд хамаарах үл хөдлөх орон нутгийн татвар;
 - 9) Худалдаа буюу арилжааны зорилготой гэрээнээс үүссэн мөнгөн орлого бө мөнгөн төлбөр;
 - 10) Зогсоосон үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн орлого буюу мөнгөн төлбөр ба;
 - 11) Зарга маргааны барагдуулалттай холбоотой мөнгөн орлого буюу мөнгөн төлбөр.
- 2.44 Байгууллага нь шууд аргыг ашиглан үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тайлагнана.
- 2.45 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд аргаар тайлагнаж буй байгууллага нь ердийн үйл ажиллагааны ашиг, алдагдлыг уг үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээтэй уялдуулах тохируулгын тайлан бэлтгэхийг дэмжинэ. Энэхүү тохируулгыг мөнгөн гүйлгээний тайлангийн нэг хэсэг байдлаар эсхүл санхүүгийн тайлангийн тодруулгад харуулж болно.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

- 2.46 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын ирээдүйн үйлчилгээ нийлүүлэлтэд хувь нэмрээ оруулах нөөцийн хувьд зарцуулсан мөнгөн зарлагын гүйлгээний дүнг илэрхийлнэ. Санхүүгийн байдлын тайланд хөрөнгө хүлээн зөвшөөрөхөд хүргэх зөвхөн тийм мөнгөн зарлага нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа гэж ангилагдах шалгуурыг хангана.
- 2.47 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна.
- 1) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгийг худалдан авахад төлсөн мөнгө. Капиталжуулсан хөгжүүлэлтийн зардал болон өөрөө барьж байгуулсан үндсэн хөрөнгөтэй холбоотой төлбөрүүд;
 - 2) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгийг борлуулсны мөнгөн орлого;
 - 3) Бусад байгууллагуудын өмчийн буюу өрийн хэрэглүүр болсон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог худалдан авахад төлсөн мөнгөн төлбөр, мөн хувь оролцооны борлуулалтаас үүссэн мөнгөн орлого;
 - 4) Бусад талуудад олгосон зээл ба мөнгөн урьдчилгаа /улсын санхүүгийн байгууллагаас олгосон зээл ба мөнгөн урьдчилгаанаас бусад/;
 - 5) Бусад талуудад олгосон зээл ба мөнгөн урьдчилгааны буцаан төлөлтөөс хүлээн авсан мөнгө орлого /улсын санхүүгийн байгууллагаас олгосон зээл ба мөнгөн урьдчилгаанаас бусад/.

- 2.48 Худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж байгаа гэрээ эсхүл мөнгөн төлбөрүүдийг нь санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилснаас бусад тохиолдолд фьючерс гэрээ, форвард гэрээ, опционы гэрээ, свопын гэрээний хувьд төлсөн мөнгө төлбөр, гэрээнүүдээс үүссэн мөнгөн орлого.

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

- 2.49 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагад капитал нийлүүлэгчдийн зүгээс ирээдүйн мөнгөн гүйлгээнд тавих шаардлагыг урьдчилан таамаглахад ач тустай тул санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тусдаа толилуулах нь ач холбогдолтой байдаг. Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээнийн жишээд дараах зүйлс хамаарна.
- 1) Баталгаагүй өрийн бичиг, зээл, баталгаат өрийн бичиг, бонд, моргейжийн /үл хөдлөх хөрөнгийн барьцаат/ болон бусад богино буюу урт хугацаат зээллэгийн хэрэглүүрийн гаргалтаас хүлээн авсан мөнгөн орлого;
 - 2) Зээлийг буцаан төлөх мөнгөн төлбөр;
 - 3) Санхүүгийн түрээстэй холбоотой төлөгдөөгүй өр төлбөрийн бууралт болон түрээслэгчийн төлсөн мөнгөн төлбөр.

Мөнгөн гүйлгээг цэвэр сууриар тайлагнах

- 2.50 Дараах үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг цэвэр дүнгээр тайлагнаж болно.
- 1) Мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын биш, харин өөр бусад талын үйл ажиллагааг тусган илэрхийлэх тохиолдолд үйлчүүлэгч, татвар төлөгч, тэтгэмж авагчийн өмнөөс цуглуулсан мөнгөн орлого ба төлсөн мөнгөн төлбөр;
 - 2) Хурдан эргэлттэй, их дүнтэй, дуусгавар болох богино хугацаатай зүйлсэд хамаарах мөнгөн орлого ба төлбөр.
- 2.51 Улсын санхүүгийн байгууллагын дараах үйл ажиллагаа тус бүрээс үүссэн мөнгөн гүйлгээг цэвэр дүнгээр тайлагнаж болно.
- 1) Дуусгавар болох тогтмол хугацаатайгаар байршуулсан мөнгөний хүлээн авалт ба буцаан төлөлтөнд хамаарах мөнгөн орлого болон мөнгөн төлбөр,
 - 2) Бусад санхүүгийн байгууллагад мөнгө байршуулалт ба түүнийг буцаан таталт;
 - 3) Үйлчлүүлэгчдэд олгосон мөнгөн урьдчилгаа ба зээл, тэдгээр урьдчилгаа болон зээлийн буцаан төлөлт.
- 2.52 Улсын санхүүгийн байгууллагын дараах үйл ажиллагаа тус бүрээс үүссэн мөнгөн гүйлгээг цэвэр дүнгээр тайлагнаж болно.

Гадаад валютаар гарсан мөнгөн гүйлгээ

- 2.53 Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн гүйлгээг тухайн байгууллагын бүртгэлийн валютаар бүртгэнэ. Ингэхдээ уг мөнгөн гүйлгээ гарсан өдрөөрх гадаад валют ба бүртгэлийн валютын хоорондох ханшаар тэрхүү гадаад валютыг хөрвүүлж, бүртгэлийн валютаар илэрхийлнэ.
- 2.54 Гадаад дахь хяналтанд буй байгууллагын мөнгөн гүйлгээг тухайн мөнгөн гүйлгээний өдрөөрх бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох ханшаар хөрвүүлнэ.

- 2.55 Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг бүртгэх эсхүл гадаад дахь хяналтанд буй байгууллагын мөнгөн гүйлгээг хөрвүүлэхдээ тайлант үеийн жинэлсэн дундаж ханшийг ашиглаж болно. *Харин УСНББОУС 4 нь гадаад дахь хяналтанд байгаа буй байгууллагын мөнгөн гүйлгээг хөрвүүлэхдээ тухайн тайлант үеийн эцэс дэх ханш ашиглахыг зөвшөөрдөггүй.*

7. ТӨСӨВ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮНГИЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

- 2.56 Улсын секторын байгууллагууд нь төсвийн хязгаарт ихэвчлэн захирагдаж байдаг. Энэхүү төсвийн хязгаар нь зөвшөөрөн батлах хуулийн дагуу хүчин төгөлдөр болох төсвийн хуваарилалт эсхүл төсвийн төсөл хэлбэртэй байдаг. Байгууллагын санхүүгийн тайлагнал нь хуулиар баталсан төсвийн дагуу нөөцийг олж авсан ба ашиглан зарцуулсан эсэх талаарх мэдээллээр хангаж болох юм. Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй байлгадаг байгууллагууд нь УСНББОУС 24, Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга-ын шаардлагуудыг даган мөрдөн шаардлагатай байдаг.

8. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮЕ ШАТ

- 2.57 Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн систем нь нэр томъёоны тодорхойлолт, нягтлан бодох бүртгэл хөтлөх дүрэм, ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн процесс, уг процессод хэрэглэх анхан шатны баримт, ажлын хүснэгт, журнал, ерөнхий дэвтэр, санхүүгийн тайлан бэлтгэх, тодруулга хийх аргачлалыг багтаана.
- 2.58 Нягтлан бодох бүртгэлийн процесс гэдэг нь үйл явдал ба ажил гүйлгээг анх таньж тогтоохоос эхлэн санхүүгийн тайлан бэлтгэж, дараагийн тайлант хугацааны ажил гүйлгээг бүртгэхэд бэлтгэх хүртэлх бүхий л үе шатыг хэлнэ.
- 2.59 Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ:
- Анхан шатны баримт бүрдүүлэх;
 - Журналд бичих;
 - Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;
 - Ажил, гүйлгээний мэдээ гаргах;
 - Санхүүгийн тайлан гаргах.

9. АНХАН ШАТНЫ БАРИМТ БА БАРИМТ ЭРГЭЛТ, ФАЙЛЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

- 2.60 Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө хүчин төгөлдөр анхан шатны баримт, материалд үндэслэнэ.
- 2.61 Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн баримт материал, тайлан болон холбогдох файлыг Монгол Улсын Архивын тухай хууль болон бусад дүрэм журмын дагуу хадгалж, компьютерын программ хангамжаар бэлтгэсэн файлын хувьд нөөц үүсгэнэ.

10. ДАНСНЫ ЖАГСААЛТЫН ТӨРӨЛ, КОДЛОХ ЗАРЧИМ

- 2.62 Байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан бэлтгэх ажиллагаанд энэхүү дансны жагсаалтыг мөрдөнө.
- 2.63 Дансны жагсаалт нь тусгайлсан код, нэр бүхий байгууллагын хэмжээнд мөрдөх нийт дансдаас бүрдэнэ.

- 2.64 Дансны жагсаалтад тусгагдаагүй дансаар ажил гүйлгээг бүртгэх зайлшгүй шаардлагатай болсон тохиолдолд Санхүү тайлан бүртгэлийн хэлтэс нээх дансны нэр, кодыг тогтооно.
- 2.65 Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт нь 10 орон бүхий кодтой байна. Дансыг кодлохдоо дараах зарчмыг баримтална.
- 2.66 Харилцах 1-5 дугаар орон нь Сангийн яамнаас гаргасан улс орны хэмжээнд мөрдөх код байна. Харин 6-7 дугаар орон нь дансдын дэд ангилалыг илрэхийлэх ба 7 дугаар орон нь арилжааны банкны төрлийг, 8 дугаар орон нь валютын төрлийг, 9-10 дугаар орон нь банкны салбарыг тус тус заана.
- 2.67 Авлага, өглөгийн дансны хувьд 6-10 дугаар орон нь дансдын дэд ангиллыг заана.
- 2.68 Бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны хувьд 6-7 дугаар орон нь дансдын дэд ангилалыг, 8-9 дүгээр орон нь хөрөнгийн нэр төрлийг 10 дугаар орон нь дэдийн дэд ангилал анхны өртөг, хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт эсэхийг заана.
- 2.69

3. АРИЛЖААНЫ БОЛОН АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 9 Арилжааны ажил гүйлгээний орлого
- УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого
- Бусад УСНББОУС

1. АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГЫН АНГИЛАЛ

- 3.1 Орлого нь тайлагнагч байгууллагын хүлээн авсан буюу авах эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээнээс бүрдэх бөгөөд эздээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчид гарсан өсөлтийг илэрхийлдэг.
- 3.2 Арилжааны бус ажил гүйлгээнд байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах эсхүл өр төлбөрийг барагдуулах ба солилцоонд нөгөө талд ойролцоогоор тэнцүү бус үнэ цэнэ бүхий зүйлсийг өгч буй ажил гүйлгээг хамруулна.
- 3.3 Байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээнээс бий болох орлоготой холбоотойгоор зарим зардал гаргадаг тохиолдолд ирээдүйн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ нь орлого болох бөгөөд нөөцийн аливаа зарлагын гүйлгээг уг ажил гүйлгээний өртөг зардал гэж хүлээн зөвшөөрнө.
- 3.4 Улсын секторын байгууллага нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээнээс орлого олж болно. Байгууллага нь татвар, шилжүүлэг болон хандив, буцалтгүй тусламж, өрөөс чөлөөлөлт, торгууль, өвлүүлсэн хөрөнгө, бэлэг, хандив, хариу төлбөргүй бараа ба үйлчилгээг УСНББОУС 23 *Арилжааны бус ажил гүйлгээний орлого* дагуу хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

- 3.5 Шилжүүлэг гэдэг нь татвараас бусад, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн орлогын гүйлгээ байдаг.
- 3.6 Татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар тогтоосон албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.
- 3.7 Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.
- 3.8 Сангийн сайдын тушаалаар баталсан орлогын эдийн засгийн ангиллын дагуу орлогыг ангилна.

2. АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 3.9 Хариу төлбөргүй үйлчилгээнээс бусад, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн ба хөрөнгийн тодорхойлолтыг хангах нөөцийн орлогын гүйлгээг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө:
- 1) Хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд магадлалтай байх;
 - 2) Хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах.
- 3.10 Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг тухайн өдрийн бодит үнэ цэнээр анх хэмжинэ.
- 3.11 Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөн арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн нөөцийн орлогын гүйлгээг тэрхүү орлогын гүйлгээтэй холбоотойгоор өр төлбөрийг бас хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд орлого гэж хүлээн зөвшөөрнө.
- 3.12 Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөн арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн нөөцийн орлогын гүйлгээний хувьд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн одоогийн үүргийг барагдуулахын хэрээр тухайн байгууллага нь хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дансны үнийг бууруулах ба тэрхүү бууралттай тэнцүү дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 3.13 Арилжааны бус ажил гүйлгээний орлогыг тухайн байгууллагын хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өсөлтийн дүнгээр хэмжинэ.

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ХЭМЖИЛТ

- 3.14 Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг тухайн байгууллагын хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өсөлтийн дүнгээр хэмжинэ. Арилжааны бус ажил гүйлгээний үр дүнд байгууллага нь хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд өр төлбөрийг бас хүлээн зөвшөөрөх шаардлагатайгаас бусад тохиолдолд хөрөнгийн дүнтэй тэнцүү хэмжээгээр орлогыг мөн хүлээн зөвшөөрнө. Өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай тохиолдолд цэвэр хөрөнгийн өсөлтийн дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

ӨР ТӨЛБӨР ГЭЖ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ОДООГИЙН ҮҮРЭГ

- 3.15 Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн бөгөөд өр төлбөрийн тодорхойлолтыг хангах одоогийн үүргийг зөвхөн дараах тохиолдолд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

- Тухайн үүргийг барагдуулахын тулд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг агуулсан нөөцийг зарцуулах шаардлагатай гэдэг нь нилээд магадлалтай байх;
- Үүргийн дүнгийн талаар найдвартай тооцоолол хийж чадах.

ТАТВАР

- 3.16 Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон ба хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдсан тохиолдолд байгууллага нь уг татварын хувьд хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.
- 3.17 Татварын орлогыг зөвхөн татвар ногдуулдаг засгийн газар болон бусад байгууллагын хувьд бий болно.

ШИЛЖҮҮЛЭГ

- 3.18 Шилжүүлэгт татвараас бусад арилжааны бус ажил гүйлгээнээс бий болсон ирээдүйн эдийн засгийн өгөөж ба үйлчилгээний боломжийн орох урсгалыг тооцно.
- 3.19 Шилжүүлсэн нөөц нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлсэн тохиолдолд шилжүүлгийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.
- 3.20 Шилжүүлэг нь буцалтгүй тусламж, өрөөс чөлөөлөлт, торгууль, өвлүүлсэн хөрөнгө, бэлэг, хандив болон хариу төлбөргүй бараа, үйлчилгээнээс бүрддэг. Эдгээр зүйлс нь хариу болгон ойролцоогоор тэнцүү үнэ цэнийг өгөхгүйгээр нэг байгууллагаас нөгөө байгууллагад нөөцийг шилжүүлдэг нийтлэг чанартай.

Шилжүүлсэн хөрөнгийн хэмжилт.

- 3.21 Шилжүүлсэн хөрөнгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх түүний бодит үнэ цэнээр хэмждэг. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бараа материал, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг стандартын дагуу уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр анх хэмжинэ.
- 3.22 Санхүүгийн хэрэглүүрийг, үүн дотроо мөнгө, түүнчлэн санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах шилжүүлгийн авлага ба бусад хөрөнгийг уг олж авсан өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр бас хэмжинэ.

Өрөөс чөлөөлөх ба өр төлбөрийг хариуцах

- 3.23 Зээлдүүлэгч нь өрийг бүрмөсөн цуцалснаар улсын секторын байгууллагын төлөх өрийг цуглуулан авах өөрийн эрхээс зарим үед татгалздаг. Хуучин өр нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй буюу өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлээгүй болсон тохиолдолд тэрхүү өрөөс чөлөөлөлт нь эздийн хувь оролцооны тодорхойлолтыг хангахгүй бол байгууллага нь өрөөс чөлөөлөлтийн хувьд орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 3.24 Өрийн чөлөөлөлтөөр үүссэн орлогыг уг чөлөөлсөн өрийн дансны үнээр хэмжинэ.

ТОРГУУЛЬ

- 3.25 Торгууль нь тодорхой мөнгөн дүнг засгийн газарт төлөхийг ихэвчлэн байгууллагаас шаарддаг бөгөөд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ямар нэг үүргийг засгийн газарт хүлээлгэдэггүй. Иймээс авлага нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлж

байвал торгуулийг орлого гэж хүлээн зөвшөөрнө. Торгуулиас үүсэх хөрөнгийг тухайн байгууллагад орох нөөцийн орлогын гүйлгээний хамгийн сайн тооцооллоор хэмжинэ.

БЭЛЭГ, ХАНДИВ, ХАРИУ ТӨЛБӨРГҮЙ БАРАА

- 3.26 Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь уг байгууллагад орох нилээд магадлалтай бөгөөд хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд бэлэг ба хандивыг хөрөнгө ба орлого гэж хүлээн зөвшөөрнө.
- 3.27 Хэрэв хариу төлбөргүй барааг ямар нэг нөхцөлгүй хүлээн авсан бол орлогыг нэн даруй хүлээн зөвшөөрнө. Хэрэв нөхцөлтэй авсан бол өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх бөгөөд нөхцөл биелэгдсэнээр өр төлбөрийг бууруулж, орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 3.28 Бэлэг, хандивыг, үүн дотроо хариу төлбөргүй барааг анх хүлээн зөвшөөрөхдөө уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмждэг.
- 3.29 Хариу төлбөргүй бараа гэдэг нь арилжааны бус ажил гүйлгээгээр тухайн байгууллагад үнэгүй шилжүүлсэн бараа юм.

АМЛАЛТ

- 3.30 Амлалт нь хүлээн авагч байгууллагад хөрөнгийг шилжүүлэх хууль ёсны бус үүрэг хариуцлага юм. Амлалт нь хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй учраас уг амласан зүйлсийг хөрөнгө буюу орлого гэж хүлээн зөвшөөрөхгүй. УСНББОУС 19-ийн шаардлагуудын дагуу амлалтын хувьд болзошгүй хөрөнгө байдлаар тодруулга хийж болох юм.

ХӨНГӨЛТТЭЙ ЗЭЭЛ

- 3.31 Хөнгөлттэй зээл нь зах зээлийн нөхцлөөс хөнгөлөлттэйгээр уг байгууллагын авсан зээл юм. Аливаа хүүний төлбөрийн хамт буцаан төлөх зээлийн хэсэг нь арилжааны ажил гүйлгээ болох бөгөөд түүнийг УСНББОУС 29-ийн дагуу тайлагнана.
- 3.32 Анх хүлээн зөвшөөрөх үеийн ажил гүйлгээний үнэ ба уг зээлийн бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг байгууллага нь арилжааны бус орлого гэж тодорхойлсон бол одоогийн үүрэгтэй байхаас бусад тохиолдолд байгууллага нь тэрхүү зөрүүг орлого гэж хүлээн зөвшөөрнө. Харин одоогийн үүрэгтэй бол уг зөрүүг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь тэрхүү одоогийн үүргийг барагдуулахын хэрээр өр төлбөрийг бууруулж, түүнтэй тэнцүү дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

ХАНДИВ, ТУСЛАМЖ

- 3.33 Тусламжийн орлого нь дор дурдсан хэлбэртэй байна:
 - 1) Олон улсын гэрээний дагуу авах хөгжлийн тусламж;
 - 2) Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авах тусламж, хандив зэргээс бүрдэнэ.
- 3.34 Гадаадын тусламж гэж олон улсын байгууллага, түнш орноос Засгийн газрын шугамаар, эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүмүүнлэгийн болон буцалтгүй, техник тусалцааны хэлбэрээр Монгол Улсад олгож байгаа хөрөнгийн эх үүсвэрийг хэлнэ.

- 3.35 Ажил гүйлгээ нь ялган тодорхойлж болох арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүдтэй эсэхийг тогтоохын тулд шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно.
- 3.36 Арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүдийг тусад нь ялган тодорхойлох боломжгүй тохиолдолд уг ажил гүйлгээг арилжааны бус ажил гүйлгээ гэж үзнэ.

3. АРИЛЖААНЫ АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ХЭМЖИЛТ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 3.37 Арилжааны ажил гүйлгээ гэдэг нь нэг байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах, эсхүл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг нөгөө талд шууд өгдөг ажил гүйлгээг хэлнэ.
- 3.38 Арилжааны ажил гүйлгээнд байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах эсхүл өр төлбөрийг барагдуулах ба солилцоонд нөгөө талд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг (жишээ нь мөнгө, бараа, үйлчилгээ эсхүл хөрөнгө ашиглуулах) өгч буй ажил гүйлгээг хамруулна.
- 3.39 Арилжааны ажил гүйлгээний орлогод дараах төрлийн орлогууд хамаарна:
- 1) Үйлчилгээ үзүүлэх;
 - 2) Бараа борлуулалт;
 - 3) Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГЫН ХЭМЖИЛТ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 3.40 Орлогыг хүлээн авсан буюу хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Орлого нь мөнгөн хөрөнгө, авлага, бусад мөнгөн бус хэлбэрээр хэрэгжинэ. Хүлээн зөвшөөрсөн орлого нь эрх бүхий байгууллагаас баталсан үнэ, гэрээгээр хоёр талын тохирсон үнэ эсхүл зах зээлийн худалдах үнээр хэмжигдэнэ.
- 3.41 Ирээдүйд үзүүлэх үйлчилгээ, нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг үйлчлүүлэгчээс урьдчилан хүлээн авсан бол бараа үйлчилгээг бодитой нийлүүлэх хүртэл орлогоор хүлээн зөвшөөрөхгүй.
- 3.42 Үйлчилгээ үзүүлэхдээ холбоотой ажил гүйлгээ нь дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд хамаарах орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 1) Орлогын дүнг найдвартай хэмжиж чадах;
 - 2) Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх;
 - 3) Тухайн тайлангийн өдрөөрх уг ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг найдвартай хэмжиж чадах;
 - 4) Тухайн ажил гүйлгээний хувьд гарсан өртөг зардал ба ажил гүйлгээг дуусган иж бүрэн болгоход гарах өртөг зардлыг найдвартай хэмжиж чадах.
- 3.43 Үйлчилгээ үзүүлэхдээ холбоотой ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй тохиолдолд нөхөн төлөгдөх зөвхөн зардлын хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 3.44 Ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй ба гарсан өртөг зардлыг нөхөх магадлал багатай тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд гарсан өртөг зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрнө.

БАРАА БОРЛУУЛАЛТ

- 3.45 Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд бараа борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 1) Байгууллага нь барааны өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн;
 - 2) Байгууллага нь тухайн борлуулсан барааны өмчлөлттэй холбоотой удирдлагын оролцоо болон үр дүнтэй хяналтын аль алиныг хадгалан хариуцахаа больсон;
 - 3) Орлогын дүнг найдвартай хэмжиж чадах;
 - 4) Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх;
 - 5) Тухайн жил гүйлгээний хувьд гарсан буюу гарах өртөг зардлыг найдвартай хэмжиж чадах.
- 3.46 Байгууллага нь өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдлийг хадгалан үлддэг бол тухайн ажил гүйлгээг нь борлуулалт биш бөгөөд орлогыг хүлээн зөвшөөрөхгүй.
- 3.47 Хэрэв байгууллага нь өмчлөлийн өчүүхэн эрсдлийг хадгалан үлддэг бол уг ажил гүйлгээ нь борлуулалт болох бөгөөд орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 3.48 Тухайн ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь байгууллагад орох нилээд их магадлалтай зөвхөн тийм тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.
- 3.49 Орлогод нэгэнт тусгасан дүнгийн цуглуулалтын хувьд тодорхойгүй байдал үүссэн тохиолдолд уг үл цуглуулагдах дүн буюу нөхөн төлөгдөх магадлалгүй болсон дүнг тэрхүү анх хүлээн зөвшөөрсөн орлогын тохируулга байдлаар биш, харин зардал гэж хүлээн зөвшөөрнө.
- 3.50 Ирээдүйд үзүүлэх үйлчилгээ, нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг үйлчлүүлэгчээс урьдчилан хүлээн авсан бол бараа үйлчилгээг бодитой нийлүүлэх хүртэл орлогоор хүлээн зөвшөөрөхгүй.

ХҮҮ, ЭРХИЙН ШИМТГЭЛ, НОГДОЛ АШИГ БУЮУ АДИЛТГАХ ХУВААРИЛАЛТ

- 3.51 Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг бий болгох тухайн байгууллагын хөрөнгийг бусдад ашиглуулснаар үүсэх орлогыг нягтлан бодох бүртгэлийн дараах хандлагыг ашиглан хүлээн зөвшөөрнө:
- 1) Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх;
 - 2) Орлогын дүнг найдвартай хэмжиж чадах.
- 3.52 Дараах нягтлан бодох бүртгэлийн хандлагыг ашигласнаар орлогыг хүлээн зөвшөөрнө.

4. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 3.53 Байгууллага нь санхүүгийн тайланд эсхүл түүний тодруулгад дараах зүйлсийг толилуулна.
- 3.54 Тухайн тайлант үед хүлээн зөвшөөрсөн арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын дүнг гол ангиудаар толилуулна.
- 1) Арилжааны бус орлогын хувьд хүлээн зөвшөөрсөн авлагын дүн;
 - 2) Нөхцөлтэй шилжүүлсэн хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дүн гэх мэт.
- 3.55 Байгууллага нь санхүүгийн тайлангийн тодруулгад дараах зүйлсийг толилуулна.

- 1) Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- 2) Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын гол ангиудын хувьд нөөцийн орлогын гүйлгээний бодит үнэ цэнийг хэмжсэн суурь;
- 3) Байгууллага нь татвар ногдох үйл явдал гарч тохиолдолд тайлант үед найдвартай хэмжиж чадахгүй татварын орлогын гол ангиудын хувьд тэрхүү татварын шинж төрлийн талаарх мэдээлэл;
- 4) Өвлүүлсэн хөрөнгө, бэлэг, хандивын гол ангиудын шинж чанар ба төрөл, үүнд хүлээн авсан хариу төлбөргүй барааны гол ангиудын тусад нь харуулах.

3.55 Байгууллага арилжааны ажил гүйлгээний орлогын хувьд нь дараах зүйлсийг тодруулна.

- 1) Орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- 2) Тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн орлогын гол ангилал нэг бүрийн дүн;
- 3) Орлогын гол ангилал бүрт тусган оруулсан бараа буюу үйлчилгээний арилжаанаас үүссэн орлогын дүн.

5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилт

а) Урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг хүлээн авсан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүжилтийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б) Засгийн газрын дотоод шилжүүлэг хүлээн авсан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүжилтийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в) Төсөвт байгууллагаас дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Төвлөрүүлэх орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

г) Улсын төсөвт орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлогыг хүлээн авсан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Төсөв хоорондын шилжүүлгийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2. Мөнгөн хөрөнгийн буцалтгүй тусламж хүлээн авсан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хандив тусламжийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3. Мөнгөн бус хөрөнгийн буцалтгүй тусламж хүлээн авсан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үнэ төлбөргүй эсхүл хандив тусламжийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. Үйл ажиллагааны бусад орлого. Хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан цаг хугацаатай хувь тэнцүүлсэн сууриар хүүг хүлээн зөвшөөрнө.

Хүүгийн орлого	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хүүгийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хүүгийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хүүгийн авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Холбогдох гэрээний мөн чанарын дагуу олсон хэмжээгээр эрхийн шимтгэлийг хүлээн зөвшөөрнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Эрхийн шимтгэлийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Төлбөрийг хүлээн авах эрх үүссэн үед ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг хүлээн зөвшөөрнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ногдол ашгийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Ногдол ашгийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Ногдол ашгийн авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

5. Торгууль, алдангийн орлого. Тайлант үеийн эцэст гэрээнд заасан хувь хэмжээгээр ногдуулсан торгуулийн орлогыг хүлээн зөвшөөрөх буюу торгуулийг авахаар нэхэмжилсэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бусад авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Торгуулийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

6. Бусад орлого, олз. Мөнгө төлөгдөөгүй боловч гэрээ, эрхийн актаар хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэхэмжилсэн орлогын дүнгээр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
------------	------------	-------	--------	---------

Бусад авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үйл ажил-ны бус бусад орлого ба олз	..X-XX-XX-XXX		xxx.xx	

7. Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний орлогыг хүлээн зөвшөөрөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Туслах үйл ажиллагааны орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. ЗАРДАЛ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 4 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө
- УСНББОУС 16 түрээс
- УСНББОУС 25 Ажилтны тэтгэмж
- УСНББОУС 21 Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- УСНББОУС 26 Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- УСНББОУС 19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө
- Бусад УСНББОУС

1. ЗАРЛАГЫН АНГИЛАЛ

- 4.1 Энэхүү бүртгэлийн бодлогоор зардлыг хүлээн зөвшөөрөх, ангилах, түүнийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх, санхүүгийн тайланд тодруулах, тайлагнахад оршино.
- 4.2 Зардал гэдэг нь эздэд олгосон хуваарилалттай холбоотойгоос бусад байдлаар өмчийг багасгах үр дүн бүхий хөрөнгийн зарлагын гүйлгээ буюу хорогдон багасгалт, эсхүл өр төлбөр үүсэлт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөжийн бууралт юм.
- 4.3 Зардал нь үйл ажиллагааны зардал болон бусад зардал, гарзыг багтаана.
- 4.4 Тайлагнагч байгууллагын тодорхой хөтөлбөр, үйл ажиллагаа буюу бусад холбогдох сегментийн зардал ба зардлын нөхөлтийг онцлон илэрхийлэхийн тулд зардлуудыг дэд ангилалд хуваадаг.
- 4.5 Зардлын шинж төрлийн аргаар зардлуудыг тэдгээрийн шинж төрлийн /жишээлбэл: элэгдэл, материалын худалдан авалт, тээврийн зардал, ажилтны тэтгэмж, дагуу санхүүгийн үр дүнгийн тайланд нэгтгэн тусгах ба тухайн байгууллагын хүрээн дэх чиг үүргээр тэдгээр зардлыг дахин хуваарилахгүй. Зардлын чиг үүргийг аргаар тэдгээрийн зарцуулсан хөтөлбөр буюу зорилгын дагуу ангилдаг.
- 4.6

2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

- 4.7 Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал үйл ажиллагааны зардлыг хүлээн зөвшөөрнө.
- 4.8 Зардал нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээ хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнийн хэрэгжээнгүй өсөлт болон бууралт, элэгдлээр дамжин гарах хөрөнгийн ашиглах зарцуулалт, үнэ цэнийн бууралтаар дамжин илэрхийлэгдэх үйлчилгээний чадавхийн болон эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын багасалт гэх мэт бусад үйл явдлуудаас үүсдэг.
- 4.9 Эдийн засгийн үр ашиг нь тайлангийн хэд хэдэн үед гарахаар хүлээгдэж байгаа үед орлоготой шууд бусаар холбогдон тодорхойлогдох зардлыг тайлангийн үеүдэд системтэйгээр, оновчтой хуваарилалтын горимын үндсэн дээр хүлээн зөвшөөрнө. Энэ нь үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл гүүдвил, патент, худалдааны тэмдэг зэрэг хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлыг хүлээн зөвшөөрөх ба энэ тохиолдолд зардлыг элэгдэл, хорогдол гэж үзнэ.
- 4.10 Зарлага нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж бий болгохгүй болсон эсхүл ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь санхүүгийн байдлын тайланд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй буюу хангахаа больсон үед болон хангахгүй тэр хэмжээгээр зардлыг үр дүнгийн тайланд нэн даруй хүлээн зөвшөөрнө.
- 4.11 Үйл ажиллагааны зардлыг төлсөн, эсхүл төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжинэ.
- 4.12 Гадаад валютаар гарсан зардлыг зардал гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, түүхэн өртгөөр бүртгэнэ.

Цалин,хөлс болон нэмэгдэл урамшуулал

- 4.13 Байгууллага нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу удирдлагын болоод ерөнхий үйлчилгээний ажиллагчидтай хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгүүлэх гэрээгээр хувь хүнд олгосон цалин, түүнтэй адилтгах зардлыг энэ ангиллын зардалд хамруулна.
- 4.14 Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшууллаас бүрдэнэ. Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан тооцож олгоно. Цалин, түүнтэй адилтгах олговрын хэмжээг байгууллагын удирдлагаас ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна. Цалин холбогдох зардлыг аккрузал сууриар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал

- 4.15 Ажил олгогч Нийгмийн даатгалын хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож Нийгмийн даатгалын санд төлнө. Хуулийн дагуу ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг олгосон цалин, олговрын дүнгээс аккрузал сууриар тооцож тайланг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө

Нийгмийн зардал

- 4.16 Байгууллагын зүгээс ажилчдад олгож байгаа шагнал урамшуулал, тэтгэмж тусламж, нөхөн төлбөр, орон сууцны дэмжлэг, хөдөлмөрийн чадвараа түр

алдсаны тэтгэмж, сувиллын хөнгөлөлт зэрэг зардлуудыг удирдлагын шийдвэр болон холбогдох дүрэм журамд заасны дагуу тооцож олгоно.

Шатахууны зардал

- 4.17 Захиргаа, удирдлагын албан хэрэгцээнд болон борлуулалтын үйл ажиллагаанд ашигласан ачаа, хүн тээврийн үйлчилгээтэй холбогдсон шатахуун, тосолгооны материал, сэлбэг, засвар үйлчилгээ болон бусад холбогдох зардал, тээврийн хэрэгцээнд гаднын байгууллага иргэдээс хөлсөлсөн унаа, тээврийн зардлыг энэ зардлаар бүртгэнэ.

ХАБЭА зардал

- 4.18 Холбогдох дүрэм, журмын дагуу норм, нормативт үндэслэн олгодог хөдөлмөр хамгааллын хувцас, хор саармагжуулах бодис, хамгаалах хэрэгсэл, тоноглолыг олгосон үед нь гүйцэтгэлээр нь бүртгэнэ.

Харилцаа холбооны зардал

- 4.19 Байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа суурин телефон, интернет, шуудангийн зардал, батлагдсан төсвийн хүрээнд албан ажлын шаардлагаар гарч буй үүрэн телефоны зардал, холбоо харилцааны тоног төхөөрөмжийн ашиглалттай холбогдон гарсан материалын болон урсгал зардлыг энэ ангиллаар бүртгэнэ.
- 4.20 Шуудан холбооны зардлыг нэхэмжилсэн тухай бүр, эсхүл гарсан тухай бүр нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хүлээн зөвшөөрнө. Тайлант хугацаанд нэхэмжлэгдээгүй материаллаг дүн бүхий зардлыг өмнөх үеүдийн дундаж дүнгээр зардалд бүртгэж дараа сар нь буцаах бичилт хийнэ.

Элэгдлийн зардал

- 4.21 Захиргаа, удирдлагын албан хэрэгцээнд болон борлуулалтын үйл ажиллагаанд ашиглаж буй үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдлыг капиталжуулах зардалд хуваарилаагүй бол энэ ангиллын зардлаар бүртгэнэ. Элэгдлийг “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн тусгай бодлого”-оор тодорхойлсон хөрөнгө тус бүрт тооцно.

Хангамжийн зардал

- 4.22 Хангамжийн материалын зардал бичиг хэрэг, шатахуун, сэлбэг хэрэгсэл гэх мэт орж болно.
- 4.23 Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ашигласан бараа материал, хангамжийн зүйлс, сэлбэг хэрэгсэл гэх мэт зардлыг энэ зардлаар бүртгэж тайлагнана.

Урсгал засварын зардал

- 4.24 Удирдлага болон борлуулалтын хэрэгцээнд ашиглагдаж байгаа хөрөнгө болон багаж хэрэгслийн урсгал засвар үйлчилгээтэй /их засварт хамаарахгүй/ холбоотой бүх зардлыг бүртгэж тайлагнана. Урсгал засварын зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн тусгай бодлого”-оор тодорхойлсон зарчмыг баримтална.

Албан томилолтын зардал

- 4.25 Байгууллагын удирдлагын шийдвэрээр ажилтнуудын гадаад, дотоодод албан ажлаар явсан томилолтын зардлыг томилолтоор явсан ажлын тайлан, холбогдох баримтыг үндэслэн зардлаар бүртгэнэ. Энд байгууллагын албан хаагчид зэрэг үйлдвэрлэлийн бус зориулалтаар төсөвлөсөн бүхий л ажилтнуудын томилолтын зардлын хамааруулан бүртгэнэ.
- 4.26 Томилолтын зардлыг ихэвчлэн томилолтоор явах үед мөнгөн урьдчилгаагаар олгох буюу банкинд аккредитив нээх, төлбөрийн карт зэрэг зарцуулах эрх бүхий тусгаарласан дансанд мөнгө төвлөрүүлж зарцуулдаг. Олгох урьдчилгааны дүнг байгууллагаас тогтоосон журам болон томилогдогчийн гаргаж батлуулсан төсвийг үндэслэн тооцно.

Ашиглалтын зардал

- 4.27 Үйл ажиллагааны хүрээнд зарцуулагдаж байгаа уур, ус, цахилгаан, дулааны төлбөрийг бүртгэж тайлагнана. Ашиглалтын зардлыг тайлант хугацаанд нэхэмжлэгдээгүй материаллаг дүн бүхий ашиглалтын зардлыг өмнөх үеүдийн дундаж дүнгээр зардалд бүртгэнэ.

Цэвэрлэгээ үйлчилгээний зардал

- 4.28 Албан хэрэгцээнд шаардлагатай цэвэрлэгээний материал, ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээтэй холбоотой зардлыг энэ дансанд бүртгэнэ.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр

- 4.29 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг гарсан тухай бүр нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хүлээн зөвшөөрнө. Гэрээт үйлчилгээний зардлыг гэрээний дүнгээс зохих сууриар хуваарилж тайлант хугацаанд ноогдох дүнгээр зардлаар хүлээн зөвшөөрнө. Гэхдээ ажил гүйцэтгүүлэх гэрээ, ажлын гүйцэтгэлийн баримт, хүлээн авсан акт, гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн, зохих шатны удирдлагын зөвшөөрлөөр бүртгэнэ.

Урьдчилж төлсөн зардал

- 4.30 Нэг эсхүл хэд хэдэн тайлант үед ногдох зардлыг талуудын хооронд байгуулсан хүчин төгөлдөр гэрээний дагуу бөөнд нь урьдчилан төлсөн үед урьдчилж төлсөн зардлыг хүлээн зөвшөөрнө.
- 4.31 Урьдчилж төлсөн зардал хэрэгжсэн үед урьдчилж төлөгдсөн зардлыг холбогдох тайлант үед зардлаар бүртгэнэ.

3. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 4.32 Зардлын зүйлс нь материаллаг байх тохиолдолд тэдгээрийн шинж төрөл ба дүнг тусад нь толилуулна.
- 4.33 Зардлын зүйлсийг тусад нь толилуулахыг шаарддаг нөхцөл байдалд дараах зүйлс хамаарна.
- 1) Бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл, үндсэн хөрөнгийг түүний нөхөгдөх дүн эсхүл нөхөгдөх;
 - 2) үйлчилгээний дүнгийн аль тохиромжтой хүртэл бууруулалтын буцаалт;
 - 3) Байгууллагын үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлт ба ийм бүтцийн өөрчлөлтийн зардлын аливаа нөөцийн буцаалт;
 - 4) Үндсэн хөрөнгийн данснаас хасалт;

- 5) Хөрөнгө оруулалтын хувьчлал буюу бусад данснаас хасалт;
 - 6) Зогсоосон үйл ажиллагаа;
 - 7) Зарга маргааны шийдвэрлэлт;
 - 8) Нөөц сангийн бусад буцаалт.
- 4.34 Үнэн зөв илэрхийлэлт ба илүү хамааралтай мэдээллээр хангадаг эсэхээс шалтгаан зардлын шинж төрөлд эсхүл тухайн байгууллагын хүрээн дэх зардлын чиг үүрэгт үндэслэсэн ангиллыг ашигласнаар уг байгууллага нь зардлын задаргаа шинжилгээг санхүүгийн үр дүнгийн тайланд эсхүл тодруулгад толилуулна.
- 4.35 Зардлын бүртгэлийн бодлогыг өртгийн объект, зардлын ангилал бүрийн хувьд тодруулна. Энэ талаархи мэдэгдлийг тодорхой үзүүлнэ. Энэхүү тодруулга нь зардал хүлээн зөвшөөрөх, хэмжих, хуваарилах, хуримтлуулах, үнэлэх болон тайлагнахад ашиглагдах зардлын бүртгэлийн бодлогын бүх онцлог болон эдгээр бодлогод орсон томоохон өөрчлөлтийг харуулна.
- 4.36 Үйл ажиллагааны зардлыг орлого үр дүнгийн тайланд нийт ашгийн дараагийн зүйл болгон дээрхи ангиллаар тайлагнана.
- 4.37 Үйл ажиллагааны зардлын ангилал бүрийн дүнг, төлөвлөгөө, гүйцэтгэл, өмнөх үетэй зэрэгцүүлж харуулна.
- 4.38 Үйл ажиллагааны зардлын ангилал бүрээр зардал хүлээн зөвшөөрөх, хэмжих, хуваарилах, хуримтлуулах, үнэлэх болон тайлагнахад баримталсан бүртгэлийн бодлогын бүх онцлог болон эдгээр бодлогод орсон томоохон өөрчлөлтийг санхүүгийн тайланд тодруулна.
- 4.39 Үйл ажиллагааны зардлын үндсэн данс болон туслах дансдын дүнг харуулсан нэгдсэн товчоог толилуулна.

4. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Үндсэн болон нэмэгдэл цалин

Олгохоор тооцсон цалинг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Цалингийн өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
НДШ-н зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
НДШ, ЭМД-ын өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	

3. Нийгмийн зардал

Шагнал урамшуулал олгоход:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Шагнал урамшуулал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Цалингийн өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Тэтгэмж, тусламж, нөхөн төлбөр олгоход:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
------------	------------	-------	--------	---------

Тэтгэмж, тусламж, нөхөн төлбөр	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Нийгмийн зардлын өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	
ХХОАТ-ын өглөг - бусад	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Сувиллын хөнгөлөлт

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Сувилалын хөнгөлөлт	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Нийгмийн зардлын өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	
ХХОАТ-ын өглөг – бусад	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Шагнал урамшуулал /хамтын гэрээний дагуу ажил мэргэжил, хүндэт дэвтэр, хөдөлмөрийн аварга, бэлэг дурсгал/:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Шагнал урамшуулал /хамтын гэрээний дагуу/	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Нийгмийн зардлын өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Тэтгэмж тусламж /хамтын гэрээний дагуу/

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Тэтгэмж тусламж /хамтын гэрээний дагуу/	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Нийгмийн зардлын өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	
ХХОАТ-ын өглөг - бусад	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. Шатахууны зардал

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Шатахууны зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Байгууллагын дотоод авлага - авто аа	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Тээврийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Шатахуун: Бензин	..X-XX-XX-XXX		xxx.xx	

5. ХАБЭА зардал

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хөдөлмөр хамгааллын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
ХХ-ын хэрэгсэл: Ажлын хувцас	..X-XX-XX-XXX		xxx.xx	

6. Харилцаа холбооны зардал

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
------------	------------	-------	--------	---------

Харилцаа холбооны зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг	..X-XX-XX-XXX		XXX.XX	

7. Элэгдлийн зардал

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Элэгдлийн зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX		XXX.XX	

8. Хангамжийн зардал

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Конторын хангамжийн зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Хангамжийн зүйлс	..X-XX-XX-XXX		XXX.XX	
Мөнгөн хөрөнгө, өглөг			XXX.XX	

9. Урсгал засварын зардал

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урсгал засварын зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Өглөг, мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		XXX.XX	

Сэлбэгийн зардал

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Сэлбэг хэрэгслийн зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		XXX.XX	

10. Албан томилолтын зардал

Томилолтын урьдчилгааг бэлэн мөнгөөр олгоход:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дараа тайлангийн авлага	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		XXX.XX	

Томилолтын тайлан, зардлын гүйцэтгэлийн баримт эрх бүхий удирдлагын зөвшөөрлийг үндэслэн томилолтын зардлыг бүртгэж урьдчилгааг хаахад:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Томилолтын зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Дараа тайлангийн авлага	..X-XX-XX-XXX		XXX.XX	

Томилолтоор явах үед ажлын зайлшгүй шаардлагаар томилолтын урьдчилгаанаас илүү мөнгө зарцуулсан бол холбогдох баримт, эрх бүхий удирдлагын зөвшөөрлийг үндэслэн томилолтын зардалд нэмж бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Томилолтын зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		XXX.XX	

Албан томилолтын зардлын гүйцэтгэл нь урьдчилгаагаар авсан мөнгөнөөс дутуу байвал баримтанд үндэслэн томилолтын зардлыг бүртгэж, зөрүү мөнгийг буцааж тушаалгана.

Томилолтын зөрүү буцааж тушаасан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Дараа тайлангийн авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

11. Сургалт, семинарын зардал

Сургалтын зардлаас ноогдох хэмжээгээр:

Мөнгөөр төлөөгүй бол тайлант хугацаанд ногдох зардлыг хүлээн зөвшөөрч:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Сургалтын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бусад богино хугацаат өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Мөнгийг урьдчилан төлсөн бол зардлыг хүлээн зөвшөөрч:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Сургалтын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урьдчилж төлсөн зардал	..X-XX-XX-XXX		xxx.xx	

12. Даатгалын зардал

Даатгалыг зардлыг хүлээн зөвшөөрч:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Даатгалын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бусад богино хугацаат өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Даатгалын зардлыг урьдчилан төлсөн бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урьдчилж төлсөн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Урьдчилж төлсөн зардлаас тайлант хугацаанд ногдуулах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Даатгалын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урьдчилж төлсөн зардал	..X-XX-XX-XXX		xxx.xx	

13. Ашиглалтын зардал

Ашиглалтын зардлыг мөнгөөр төлсөн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ашиглалтын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Төлбөр гүйцэтгээгүй боловч тайлаугацаанд ногдох зардлаас хуваарилах дүнгээр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ашиглалтын зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Бусад өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Урьдчилж гарсан зардлаас тайлант хугацаанд ногдох дүнгээр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ашиглалтын зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Урьдчилж төлсөн тооцоо	..x-xx-xx-xxx		xxx.xx	

14. Цэвэрлэгээ үйлчилгээний зардал

Цэвэрлэгээ үйлчилгээний зардлыг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..x-xx-xx-xxx		xxx.xx	
Урьдчилж төлсөн зардал	..x-xx-xx-xxx		xxx.xx	
Өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	

15. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зардал /үйлчилгээний төрлөөр/	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..x-xx-xx-xxx		xxx.xx	
Урьдчилж төлсөн зардал	..x-xx-xx-xxx		xxx.xx	
Өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Хэрвээ тухайн ажил үйлчилгээнд зориулан байгууллагаас материал болон бусад нөөцийг зарцуулсан бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зардал /үйлчилгээний төрлөөр/	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Хангамжийн материал	..x-xx-xx-xxx		xxx.xx	

4.1 ЦАЛИНГИЙН БҮРТГЭЛ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 25 Ажилтны тэтгэмж,
- Бусад УСНББОУС

1. АНГИЛАЛ

- 4.40 Ажилтны богино хугацааны тэтгэмж нь ажилтнууд холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүхэлдээ төлөгдөж барагдуулахаар хүлээгдэж буй дараах гэх мэт тэтгэмжүүдийг багтаана.
- 1) Цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл;
 - 2) Ээлжийн амралтын цалин, өвчтэй хугацааны тэтгэмж;
 - 3) Ашиг хуваалт ба шагнал урамшуулал;
 - 4) Одоо байгаа ажилтнуудад олгодог мөнгөн бус тэтгэмж.
- 4.41 Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшууллаас бүрдэнэ. Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан тооцож олгоно. Цалин, түүнтэй адилтгах олговрын хэмжээг байгууллагын удирдлагаас ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.
- 4.42 Ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоон олгоно.
- 4.43 Байгууллагын зүгээс ажилчдад олгож байгаа шагнал урамшуулал, тэтгэмж тусламж, нөхөн төлбөр, орон сууцны дэмжлэг, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, сувиллын хөнгөлөлт зэрэг зардлуудыг удирдлагын шийдвэр болон холбогдох дүрэм журамд заасны дагуу тооцож олгоно.
- 4.44 Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно.
- 4.45 Байгууллагын удирдлагын шийдвэр буюу шийдвэрээр баталсан журмаар зохицуулж ажилчдад ажилдаа ирэх, очих унааны хөлсийг байгууллагаас олгох, өдрийн хоолны үнийн тодорхой хэсгийг олгох буюу өөрийн цайны газраар хөнгөлөлттэй үнээр үйлчлэх, орон сууцны хөлс, түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт зэрэг хөнгөлөлтийг ажилласан хугацаанд нь олгож болно.
- 4.46 Хоол, унааны хөнгөлөлт болон тусламж, тэтгэмжээс ХХОАТ, НДШ-ийг хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр тооцно.
- 4.47 Байгууллагын удирдлага үндсэн ажилтан бус хувь хүнтэй ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, хөлсөөр ажиллуулж болно. Түр гэрээгээр ажиллуулсан хувь хүнд олгосон хөдөлмөрийн хөлснөөс хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр ХХОАТ, НДШ тооцож төлнө.

2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

Ажилтны богино хугацааны тэтгэмж

- 4.48 Ажилтан нь нягтлан бодох бүртгэлийн тайлант үед байгууллагад үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд уг байгууллага нь тухайн үйлчилгээний хариуд төлөхөөр хүлээгдэж буй ажилтны богино хугацааны тэтгэмжүүдийг тэдгээрийн дискаунтчлаагүй дүнгээр дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.
- 1) Аль хэдийн төлсөн дүнг хассаны дараа, өр төлбөр хуримтлагдсан зардал байдлаар. Хэрэв аль хэдийн төлсөн дүн нь тухайн тэтгэмжийн

- дискаунтчлаагүй дүнгээс илүү байвал уг урьдчилсан төлбөр нь тухайлбал, ирээдүйн төлбөрүүдийн бууралт эсхүл мөнгөн буцаан олголт болох тэр хэмжээгээр байгууллага нь илүү төлөлтийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө;
- 2) Өөр бусад стандарт нь уг тэтгэмжийг хөрөнгийн өртөгт оруулахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд зардал байдлаар.
- 4.49 Цалинтай чөлөө хэлбэрээр олгох ажилтны богино хугацааны тэтгэмжийн хүлээгдэж буй зардлыг байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.
- 1) Хуримтлагдсан цалинтай чөлөөний хувьд, ажилтнууд нь ирээдүйд цалинтай чөлөө авах өөрсдийн эрхийг нэмэгдүүлэх үйлчилгээ үзүүлсэн үед;
- 2) Үл хуримтлагдах цалинтай чөлөөний хувьд, чөлөө авсан үед.
- 4.50 Байгууллага нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоолоор тогтоосон цалингийн сүлжээ болон бусад холбогдох журам, зааврыг баримталж цалин хөлсний тооцоолол хийнэ.
- 4.51 Ажил олгогч Нийгмийн даатгалын хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож Нийгмийн даатгалын санд төлнө. Хуулийн дагуу ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг олгосон цалин, олговрын дүнгээс аккрузал сууриар тооцож тайланг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.
- 4.52 Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу олгохоор тооцсон цалин, олговрын дүнгээс ажил олгогчоос төлөх нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын санд төлнө.
- 4.53 Цалингийн зардлын ангилал бүрээр хүлээн зөвшөөрөх, хэмжих, хуваарилах, хуримтлуулах, үнэлэх болон тайлагнахад баримталсан бүртгэлийн бодлогын бүх онцлог болон эдгээр бодлогод орсон томоохон өөрчлөлтийг санхүүгийн тайланд тодруулна.

3. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1.1 Олгохоор тооцсон цалинг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX		XXX.XX	

2. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг бүртгэхэд: Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
НДШ-н зардал	..X-XX-XX-XXX	XXX.XX		
НДШ, ЭМД-ын өглөг	..X-XX-XX-XXX		XXX.XX	

3. Ээлжийн амралттай холбоотой бичилтүүд

Ээлжийн амралтын мөнгийг ажилтанд олгохдоо холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан бодож олгоно. Ээлжийн амралтын олговрыг ажилтан ээлжийн амралт авах эхний өдрөөс өмнө НДШ болон ХХОАТ-ыг урьдчилсан байдлаар тооцож, суутган ажилтанд олгоно.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
------------	------------	-------	--------	---------

ААХ-с авах бусад авлага /ээлжийн амралт/	..X-XX-XX-XXX	xxx.xx		Татварыг урьдчилан тооцож хассан дүнгээр
Харилцах	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Хэрэв ажилтны амралтын хоног нь 2-3 сар дамнан үргэлжлүүлэхээр бол ээлжийн амралтын олговрыг ажилтанд бөөнд нь 1 удаа бодож олгох бөгөөд тухайн сард амрах амралтын хоногтой нь уялдуулан амралтын олговрыг бодож, цалингийн бүрэлдэхүүний “Ээлжийн амралтын тухайн сарын олговор” болон “Ээлжийн амралтын дараа сарын олговор” хэсгүүдэд тус тус тайлагнана.

“Ээлжийн амралтын тухайн сарын олговор” нь тухайн сарын олговол зохих цалингийн бүрэлдэхүүн хэсэг болно. Харин “Ээлжийн амралтын дараа сарын олговор” нь ажилтны дараа сард амрах хоногт ногдох амралтын олговор бөгөөд дараа сарын олговол зохих цалингийн бүрэлдэхүүн хэсэг болно.

Тухайн сарын цалингийн талбарын “Ээлжийн амралтын дараа сарын олговор” хэсэгт тусгагдсан дүнгээр ямар нэгэн журналын бичилт хийхгүй бөгөөд дараа сарын цалингийн талбарын “Ээлжийн амралтын олговор өмнөх сар” хэсэгт тусгагдаж, олговол зохих цалингийн бүрэлдэхүүн хэсэг болно.

Харин тухайн сард ногдох болон өмнөх сарын амралтын хоногийн олговроос татварыг тооцон суутгаж, олгосон дүнгээр ажилтнаас сар бүр суутгал хийнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Татварыг урьдчилан тооцож хассан дүнгээр
ААХ-с авах бусад авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. Цалингийн бусад бичилтүүд

Ажилчдад урьдчилгаа цалин болон үр дүнгийн шагнал олгоход олгоход:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Касс /бэлэн мөнгөөр олговол/	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Банк дахь харилцах данс /карт ба хувийн харилцах дансаар олговол/	..X-XX-XX-XXX		xxx.xx	

5. Нийгмийн даатгалын шимтгэлийн болон Хувь хүний орлогын албан татварын суутгал

Монгол Улсын Нийгмийн даатгалын хуулийн дагуу олгохоор тооцсон цалин, олговрын дүнгээс даатгуулагчаас төлөх нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын (НДШ, ЭМДШ) шимтгэлийг хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцон, дундын суутгалыг хийж, зохих даатгалын сангуудад төлнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Цалингаас НДШ суутгасан дүнгээр
НДШ-н өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна гэж заасны дагуу ажилтанд олгож

байгаа цалингийн орлогоос ЭМНДШ-ийг хасч, хуульд заасан хувь хэмжээгээр татвар ногдуулна.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Цалингаас ХХОАТ суутгасан дүнгээр
Хүн амын орлогын татварын өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Суутган тооцсон харьяа татварын албанд төлөхөд

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
НДШ-ийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Цалингаас ХХОАТ суутгасан дүнгээр
Хүн амын орлогын татварын өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Банк дахь харилцах данс /төгрөг/	..X-XX-XX-XXX		xxx.xx	

1. Олгохоор тооцсон цалингаас бусад суутгал хийхэд;

Байгууллагын нийт ажилчдаас дараах суутгалуудыг цалингаас суутгана. Бүх суутгалыг авлагын дансаар дамжуулан бүртгэнэ.

- Цалингийн урьдчилгаа
- Утасны төлбөр
- Хоолны мөнгө
- ҮЭ-ийн татвар
- Бусад төлбөр суутгалууд

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Цалингаас суутгасан суутгалууд
ААХХ тооцоо	..X-XX-XX-XXX		xxx.xx	
ҮЭ-ийн татвар	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Цалингийн урьдчилгаа тооцоог хааж;

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Сарын үр дүн болон урьдчилгаа цалингийн суутгал
Цалингийн урьдчилгаа	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Бүх суутгалуудыг хийсний дараа гарт олгох дүнгээр ажилчдад олгоход:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Гарт олгох цалингийн дүнгээр
Касс /бэлэн мөнгөөр олговол/	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Банк дахь харилцах данс /карт ба хувийн харилцах дансаар олговол/	..X-XX-XX-XXX		xxx.xx	

5. МӨНГӨН ХӨРӨНГӨ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 2 Мөнгөн гүйлгээний тайлан
- УСНББОУС 4 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- Бусад УСНББОУС

1. ХАМРАХ ХҮРЭЭ

- 5.1 Тайлант үеийн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө бий болгох чадварыг үнэлэх, мөнгөн хөрөнгийн хэрэгцээг тодорхойлох, мөнгөн гүйлгээг үндсэн, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагаанд ангилж, аж ахуйн нэгжийн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн түүхэн өөрчлөлтийн тухай мэдээллийг хангах явдал юм.
- 5.2 Мөнгө нь бэлэн мөнгө ба харилцах данснаас бүрдэнэ.
- 5.3 Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, ихээхэн өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт юм.
- 5.4 Мөнгөтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг хангахын тулд хөрөнгө оруулалт нь мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой бөгөөд үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй байх ёстой.
- 5.5 Иймээс хөрөнгө оруулалт нь богино хугацаатай, тодруулбал: худалдан авч эзэмшсэнээс хойш 3 сар буюу түүнээс богино хугацаанд дуусгавар болох хугацаатай зөвхөн тийм тохиолдолд мөнгөтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг ихэвчлэн хангадаг. Мөн чанарын хувьд мөнгөтэй адилтгах хөрөнгө байх тухайлбал: дуусгавар болох богино хугацааны дотор болон эргэлтээс гаргах тусгайлан заасан хугацаатайгаар худалдан авснаас бусад тохиолдолд өмчийн хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй.
- 5.6 Замд яваа мөнгө Зарим тохиолдолд сарын эцсийн өдөр Монголбанкны гүйлгээ хаагдсаны дараа харилцагч байгууллагаас банк хоорондын гүйлгээгээр шилжүүлсэн мөнгө нь дараа сарын эхний өдөр байгууллагын харилцах дансанд орж ирэх тохиолдол гардаг. Үүнийг уг харилцагчтай тооцоо нийлж, анхан шатны баримтыг үндэслэн тухайн сардаа замд яваа мөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.
- 5.7 Жижиг мөнгөн сан: Байгууллагын өдөр тутмын жижиг зарлагад зориулсан, үндсэн кассаас тусдаа мөнгөн сан байж болно. Ийм мөнгөн санг “Жижиг мөнгөн сан” гэж нэрлэх бөгөөд дүн хязгаарлагдмал, тодорхой зориулалттай байна.

2. АНГИЛАЛ

- 5.8 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:
 - 1) Зоос ба бэлэн мөнгө;
 - 2) Жижиг мөнгөн сан;
 - 3) Харилцах дансанд байгаа мөнгө;
 - 4) Төлбөрийн болон бусад картын данс;
 - 5) Хугацаагүй хадгаламж;
 - 6) Гурван сар хүртэл хугацаанд түргэн борлогдох санхүүгийн хөрөнгө;
 - 7) Гурван сар хүртэл хугацаатай замд яваа мөнгө;

- 8) Гурван сар хүртэл хугацаатай аккредитивүүд.
- 5.9 Мөнгөн чек, карт, хугацаагүй хадгаламж зэрэг зарцуулалт нь ямар нэг хязгаарлалтгүй эсхүл зарцуулснаар ямар нэг төлбөр, торгууль ногдохгүй шилжих хэрэгслийг мөнгө гэж үзнэ.
- 5.10 Мөнгөн хөрөнгийг бэлэн мөнгө, харилцах данс гэж үндсэнд нь хоёр ангилж бүртгэнэ. Бэлэн мөнгө гэдэгт бэлнээр байгаа мөнгөн хөрөнгийг, харилцах данс гэдэгт бэлэн бусаар буюу банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийг хамааруулна. Мөнгөн хөрөнгийг төгрөг, гадаад валютын төрлөөр ангилж бүртгэнэ.

3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

АНХДАГЧ ХЭМЖИЛТ

- 5.11 Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэнэ. Гадаад валютыг тухайн үеийн албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэнэ.

АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТИЙН ДАРАА ҮЕИЙН ХЭМЖИЛТ

- 5.12 Балансад гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг балансын өдрийн Монголбанкны хаалтын албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэж тайлагнана.
- 5.13 Энд гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүүгээс үүссэн олз, гарзыг Санхүүгийн үр дүнгийн тайланд “Валютын ханшийн өөрчлөлтийн олз, гарз” хэмээн хүлээн зөвшөөрч тусгана.

4. ТОДРУУЛГА

- 5.14 Санхүүгийн тайланд бэлэн мөнгийг нэгдүгээр зүйл, харилцах дансыг хоёрдугаар зүйл болгон төгрөг, мөнгөөр тайлагнана. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгийг Монголбанкнаас зарласан хаалтын албан ханшаар төгрөгт шилжүүлж, санхүүгийн тайланд тусгана. Төлбөрийн болон бусад картын данс нь харилцахын бүрэлдэхүүнд орж, тайлагнагдана.
- 5.15 Бэлэн мөнгийг валютын төрөл, ханш, дэд ангилалаар тодруулга хийж харуулна. Харилцах дансыг валютын төрөл, ханш, дэд ангилалаас гадна харилцагч банк, санхүүгийн байгууллагаар тодруулга хийнэ. Мөн хязгаарлагдсан, барьцаалагдсан эсэх болон хүүний тухай мэдээллийг тодруулгад оруулна.
- 5.16 Мөнгөн хөрөнгийн ангилал бүрээр дансдын өмнөх болон тайлант үеийн үлдэгдлийг дэлгэрэнгүйгээр тодруулна. Шаардлагатай бол мөнгөн хөрөнгө байршуулах, төлбөр гүйцэтгэх томоохон дүн бүхий гэрээ, хэлцэл эдгээрийн дагуу хийгдсэн ажил гүйлгээ, үр дүнг тодруулна.
- 5.17 Мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг бэлэн мөнгө, харилцах данс болон валютын төрлөөр ангилж, төгрөгөөрх гүйлгээг Мөнгөн гүйлгээний журнал (МГ-1)-д, валютаарх гүйлгээг Мөнгөн гүйлгээний журнал (МГ-2)-д тус тусад нь бүртгэнэ.
- 5.18 Мөнгөн хөрөнгийн данс хооронд хийгдсэн гүйлгээнээс бусад бүх мөнгөн орлого, зарлагын гүйлгээг холбогдох авлага болон өглөгийн дансанд тус тус бичилт хийнэ.

5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэлийг дараах нийтлэг ажил гүйлгээгээр харуулъя.

- а) Мөнгөн хөрөнгийн орлогын гүйлгээнүүд:

Харилцахаас касст бэлэн мөнгө авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлэн мөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Авлага мөнгөн хөрөнгөөр орж ирэх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлэн мөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Авлага (холбогдох дансны)	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Богино, урт хугацаат зээлийг мөнгөн хөрөнгөөр авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлэн мөнгө-валютын төрлөөр	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Богино хугацаат зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

а) Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээнүүд:

Харилцах данснаас цалингийн урьдчилгаа болон үр дүнгийн урамшуулал олгох үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ажилчин, албан хаагчдын цалингийн урьдчилгаа	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах-төгрөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Харилцах данснаас цалингаас бусад урьдчилгаа олгох үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ажилчин, албан хаагчдын цалингийн урьдчилгаа	..X-XX-XX-XXX	xxx.xx		(ААХ-н цохолтоор авсан цалингийн урьдчилгаа)
Харилцах-төгрөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Харилцах данснаас цалингийн өрийг төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах-төгрөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Харилцах данснаас өр төлбөрийг төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Өглөг (Холбогдох данс)	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX		xxxx.xx	

Дараа тайлангаар харилцах данснаас мөнгө олгох үед (томилолт, сэлбэг материал, төсвийн дагуу зарцуулах үед):

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дараа тайлангийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Бэлэн мөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Байгууллагын удирдлагын тушаалын дагуу олгогдож бүх төрлийн тэтгэмж шагнал урамшуулал:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
ААХ-д өгөх өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

b) Бэлэн мөнгөний зарлагын гүйлгээнүүд:

Бэлэн мөнгийг харилцах дансанд тушаах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Клирингийн данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Клирингийн данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бэлэн мөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Бэлэн мөнгөөр цалингийн урьдчилгаа болон үр дүнгийн урамшуулал олгох үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
ААХ-ын цалингийн урьдчилгаа	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бэлэн мөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Бэлэн мөнгөөр цалингаас бусад урьдчилгаа олгох үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
ААХ-ын цалингаас бусад урьдчилгаа	..X-XX-XX-XXX	xxx.xx		(ААХ-н цохолтоор авсан цалингийн урьдчилгаа)
Бэлэн мөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Бэлэн мөнгөөр цалингийн өрийг төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бэлэн мөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

1. Гадаад валютын бүртгэлийг дараах нийтлэг ажил гүйлгээгээр харуулъя.

a) Бэлэн мөнгөний орлогын гүйлгээнүүд:

Валютыг бэлэн мөнгө болгох үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлэн мөнгө-төгрөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Арилжааны ханш
Бэлэн мөнгө-валют	..X-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..X-XX-XX-XXX		xxx.xx	Арилжааны болон Албан ханшийн зөрүү дүнгээр

Төгрөгийн харилцах данснаас төгрөгийн кассанд чекээр мөнгө авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
------------	------------	-------	--------	---------

Бэлэн мөнгө-төгрөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Валютын харилцах данснаас төгрөгийн кассанд чекээр мөнгө авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлэн мөнгө-төгрөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Арилжааны ханш
Харилцах данс-валют	..X-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..X-XX-XX-XXX		xxx.xx	Арилжааны болон Албан ханшийн зөрүү дүнгээр

Валютын харилцах данснаас кассанд чекээр валют авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлэн мөнгө-валют	102-XX-XX-XXX	xxx.xx		Албан ханш
Харилцах данс-валют	112-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш

Авллага валютаар бэлнээр төлөгдөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлэн мөнгө-валют	..X-XX-XX-XXX	xxx.xx		Албан ханш
Авллага (холбогдох дансны)	..X-XX-XX-XXX		xxx.xx	Дансны үнэ
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..X-XX-XX-XXX		xxx.xx	Арилжааны болон Албан ханшийн зөрүү дүнгээр

б) Бэлэн мөнгөний зарлагын гүйлгээнүүд:

Бэлэн мөнгөөр валют худалдан авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлэн мөнгө-валют	..X-XX-XX-XXX	xxx.xx		Албан ханш
Бэлэн мөнгө-төгрөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Арилжааны ханш
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..X-XX-XX-XXX		xxx.xx	Арилжааны болон Албан ханшийн зөрүү дүнгээр

Бэлэн валютыг төгрөгийн харилцах дансанд тушаах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах данс-төгрөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Арилжааны ханш
Бэлэн мөнгө-валют	..X-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..X-XX-XX-XXX		xxx.xx	Арилжааны болон Албан ханшийн зөрүү дүнгээр

Бэлэн валютыг валютын харилцах дансанд тушаах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах данс-валют	..X-XX-XX-XXX	xxx.xx		Албан ханш
Бэлэн мөнгө-валют	..X-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш

Бэлэн валютаар өр төлбөрийг төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Өглөг (Холбогдох данс)	..X-XX-XX-XXX	xxx.xx		Дансны үнэ
Бэлэн мөнгө-валют	..X-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш

Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..x-xx-xx-xxx		xxx.xx	Дансны үнэ болон Албан ханшийн зөрүү дүнгээр
---	---------------	--	--------	--

Дараа тайлангаар бэлэн валют олгох үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дараа тайлангийн авлага	..x-xx-xx-xxx	xxx.xx		Албан ханш
Бэлэн мөнгө-валют	..x-xx-xx-xxx		xxx.xx	Албан ханш

с) Харилцах дансны орлогын гүйлгээнүүд:

Бэлэн бусаар валют худалдан авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах-валют	..x-xx-xx-xxx	xxx.xx		Албан ханш
Харилцах-төгрөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Арилжааны ханш
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..x-xx-xx-xxx		xxx.xx	Арилжааны болон Албан ханшийн зөрүү дүнгээр

Бэлэн бусаар валют худалдсан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах-төгрөг	..x-xx-xx-xxx	xxx.xx		Арилжааны ханш
Харилцах-валют	..x-xx-xx-xxx		xxx.xx	Албан ханш
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..x-xx-xx-xxx		xxx.xx	Арилжааны болон Албан ханшийн зөрүү дүнгээр

Бэлэн валютыг төгрөгийн харилцах дансанд тушаах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах данс-төгрөг	..x-xx-xx-xxx	xxx.xx		Арилжааны ханш
Бэлэн мөнгө-валют	..x-xx-xx-xxx		xxx.xx	Албан ханш
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг/алдагдал	..x-xx-xx-xxx		xxx.xx	Арилжааны болон Албан ханшийн зөрүү дүнгээр

Бэлэн валютыг валютын харилцах дансанд тушаах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах данс-валют	..x-xx-xx-xxx	xxx.xx		Албан ханш
Бэлэн мөнгө-валют	..x-xx-xx-xxx		xxx.xx	Албан ханш

Авлага валютаар бэлэн бусаар төлөгдөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Харилцах-валют	..x-xx-xx-xxx	xxx.xx		Албан ханш
Авлага	..x-xx-xx-xxx		xxx.xx	Дансны үнэ
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Дансны үнэ болон Албан ханшийн зөрүү дүнгээр

d) Харилцахын зарлагын гүйлгээнүүд:

Харилцах данснаас валютаар өр төлбөрийг төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Өглөг (Холбогдох данс)	..x-xx-xx-xxx	xxx.xx		Дансны үнэ

Харилцах-валют	..X-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш болон дансны үнийн зөрүү дүнгээр

Дараа тайлангаар бэлэн валют олгох үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дараа тайлангийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		Албан ханш
Харилцах-валют	..X-XX-XX-XXX		xxx.xx	Албан ханш

2. Хадгаламж ба төлбөрийн бусад хэрэгсэл

Хадгаламжид мөнгө байршуулахад:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Банк дахь хадгаламж-валютын төрлөөр	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Касс/Харилцах	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Байршуулсан хадгаламжийг буцааж татахад:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Касс/Харилцах	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Банк дахь хадгаламж-валютын төрлөөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3. Байгууллага бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг ашиглаж, тухайн зориулалтаар мөнгөн хөрөнгө тусгаарлаж болно.

Төлбөрийн дебит картын эх үүсвэрт мөнгө тусгаарлавал:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Картын харилцах данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Касс/Харилцах	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Банкинд нээсэн аккредитивын эх үүсвэрт хөрөнгө тусгаарлавал:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Тусгаарласан мөнгө-холбогдох валют	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Касс/Харилцах	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. Барьцаа

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бусад авлага-Барьцаа	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Касс/Харилцах	..X-XX-XX-XXX		xxx.xx	

6. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Холбогдох Улсын секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- УСНББОУС 30 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга
- Бусад УСНББОУС

1. ХАМРАХ ХҮРЭЭ

- 6.1 Санхүүгийн хэрэглүүр гэдэг нь нэг аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн хөрөнгө болон нөгөө аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн өр төлбөр эсхүл өмчийн хэрэглүүр хоёрыг аль алиныг үүсгэх гэрээ юм. Үүнд мөнгөн хөрөнгө, авлага, зээл, үнэт цаас, гадаад валютын форвард, своп хэлцэл гэх мэт санхүүгийн хэрэгслийг арилжаалах хэлцлүүд болон эдгээртэй адилтгах гэрээ, хэлцэл багтана.
- 6.2 Гэрээ, гэрээний эрх, үүрэг гэдэг нь талуудын хоорондох гэрээ, тохиролцоо хуулийн дагуу хүчин төгөлдөр байх учраас аливаа эрх, үүргээс зайлсхийх боломжгүй, хэрэв зайлсхийнэ гэвэл магадлал багатай тийм хэлцлийг илэрхийлнэ.
- 6.3 Санхүүгийн хөрөнгө нь дараах аливаа хөрөнгө юм.
- 1) мөнгө;
 - 2) өөр байгууллагын өмчийн хэрэглүүр;
 - 3) Доорх гэрээний эрх;
 - 4) Өөр байгууллагаас мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах; эсхүл
 - 5) Санхүүгийн хөрөнгө эсхүл санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагад тааламжтай байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох.
- 6.4 Бараа материал, үндсэн хөрөнгө, түрээслэсэн хөрөнгө түүнчлэн биет бус хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө биш юм. Мөн ирээдүйд мөнгө биш, харин бараа үйлчилгээ хүлээн авах урьдчилж төлсөн зардал нь санхүүгийн хөрөнгө болохгүй юм. Үүнтэй адилаар мөнгөн төлбөр хийхгүй харин бараа, үйлчилгээ нийлүүлэх урьдчилж орсон орлого, баталгаат өглөг нь санхүүгийн өр төлбөрт хамаарахгүй.
- 6.5 Тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох гэрээ санхүүгийн хэрэглүүрийг боломжит тааламжтай нөхцлөөр бусад аж ахуйн нэгж, байгууллагатай солилцох гэрээний эрх юм.
- 6.6 Мөнгөн зүйлсийн санхүүгийн хэрэглүүр гэдэг нь тогтмол буюу тодорхой хэмжээний мөнгийг хүлээн авах эсхүл төлөх санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр юм.

2. АНГИЛАЛ

- 6.7 Санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр, өмчийн хэрэгсэл гэж, мөн анхдагч ба үүсмэл хэрэглүүр гэж хоёр ангилана.

- 6.8 Анхдагч санхүүгийн хэрэглүүрт мөнгө болон авлага, өглөг, өмчийн үнэт цаас хамаарна. Харин үүсмэл санхүүгийн хэрэглүүрт опцион, фьючерс, форвардс, хүүний түвшний своп, валютын своп зэрэг хамаарна.
- 6.9 Санхүүгийн хөрөнгөнд 3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, авлага, өрийн болон өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт хамаарна.

3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ, ХЭМЖИЛТ

- 6.10 Байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон зөвхөн тийм тохиолдолд уг байгууллага нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа хүлээн зөвшөөрнө.
- 6.11 Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь түүний бодит үнэ цэнээр хэмжинэ.
- 6.12 Харин ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр байх тохиолдолд тэдгээрийн олж эзэмшилт буюу гаргалтанд шууд хамаарах ажил гүйлгээний тэрхүү дүн дээр нэмэх эсхүл хасах байдлаар хэмжинэ.
- 6.13 Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа санхүүгийн хөрөнгийг хэмжих зорилгын хувьд санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна.
- 1) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө;
 - 2) Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
 - 3) Зээл ба авлага;
 - 4) Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө.
- 6.14 Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь доор дурдсанаас бусад, санхүүгийн хөрөнгийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд тухайн хөрөнгийг борлуулах буюу бусад байдлаар данснаас хасахад гарч болох ажил гүйлгээний зардлын хувьд аливаа хасалт хийхгүй.
- 1) Үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг зээл ба авлага;
 - 2) Үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
 - 3) Идэвхтэй зах зээл дэх жишиг зах зээлийн үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүйгээс өртгөөр хэмждэг тийм өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт.
- 6.15 Санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжихийн тулд түүнийг найдвартай тодорхойлж, ул үндэслэлтэй тооцоолж чадах урьдчилсан нөхцөл хангагдсан байх ёстой.
- 6.16 Богино хугацааны арилжааны зорилготой, тогтмол дуусгавар хугацаатай эсхүл уг байгууллагын өөрийн үүсгэсэн зээл, авлагыг бодит үнэ цэнээр хэмжсэнээс үүсэх олз буюу гарзыг тайлант хугацааны цэвэр ашиг, алдагдлын тооцоололд оруулна. Харин дээрх гурваас бусад санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжсэнээс үүссэн олз буюу гарзыг өмчийн өөрчлөлтийн тайланд тусгана.
- 6.17 Зээл ба авлага
- 6.18 Улс, орон нутгийн төсвөөс эрх бүхий байгууллагын шийдвэрээр, бодлого зохицуулалтын зорилгоор эсхүл сул чөлөөтэй мөнгөө бусдад зээлдүүлсэн, мөн гадаад улс, олон улсын байгууллага, болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл аван уг зээлийг бусад байгууллагад богино хугацаагаар

- дамжуулан зээлдүүлсэн бол энэ дансанд бүртгэнэ. Дансны авлагыг ирээдүйд хүлээн авахаар тооцсон цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн байдлын тайланд толилуулна.
- 6.19 Зээлийн авлагыг олгосон хугацаанаасаа хамааран богино, урт хугацаат зээлийн авлага гэж ангилна.
- 6.20 Засгийн газар гадаад зээлийг гаднын зээлдүүлэгчээс мөнгөн хөрөнгөөр хүлээн авч дахин дотоодын зээлдэгчид дамжуулан зээлдүүлэх болон гэрээнд тохиролцсон нөхцөлийн дагуу гадаад дахь зээлдүүлэгчийн харилцах данснаас Засгийн газрын харилцах дансаар дамжихгүй шууд дотоодын эцсийн зээлдэгчид эсхүл тэдний бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчийн харилцах дансанд төлбөр хийх гэсэн хоёр хувилбараар үүсч болно.
- 6.21 Зээл болон бусад авлагыг үндсэн зах зээлийн хэрэгсэл гэж үзсэн тохиолдолд, зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур олгосон зээл болон бусад авлагыг анх хүлээн зөвшөөрч бүртгэхэд гарах алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Харин зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур олгосон тухайн зээл болон бусад авлага нь үндсэн зах зээлийн тодорхойлолтын шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд ашиг, алдагдлаар тайлагнана.
- 6.22 Хөрөнгө оруулалтыг эзэмшиж буй хугацаанаас нь хамааран богино, урт хугацаат хөрөнгө оруулалт гэж ангилна.
- 6.23 Богино хугацаат хөрөнгө оруулалт гэж мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөөр ангилагдаагүй бөгөөд арилжааны зориулалттай, нэг жил хүртэлх хугацаатай хөрөнгө оруулалтыг хэлнэ.
- 6.24 Хөрөнгө оруулалтыг үнэт цаасны төрлөөс нь хамааруулан өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт, өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт гэж ангилна.
- 6.25 Бизнес загвар болон мөнгөн урсгалын онцлогт үндэслэн өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг дараах байдлаар ангилж, бүртгэнэ:
- 1) Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө (Арилжааны үнэт цаас);
 - 2) Борлуулахад бэлэн бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө;
 - 3) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө (Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө).
- 6.26 Хувьцаа гаргагчийн хувьд өмчийн тодорхойлолтод нийцэх санхүүгийн хөрөнгийг хөрөнгө оруулагч байгууллагын гаргасан өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт гэж үзнэ. Өмчийн үнэт цааст санхүүжигчийн гаргасан энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцааг тооцно.
- 6.27 Санхүүжигч байгууллагын саналын эрхтэй хувьцааны 20% хүртэл эзэмшилтэй тохиолдолд уг хөрөнгө оруулалтыг дараах 2 ангиллаар бүртгэлд тусгана:
- 1) Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө /арилжааны хөрөнгө оруулалт/;
 - 2) Борлуулахад бэлэн бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө.
- 6.28 Өрийн болон өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө /арилжааны хөрөнгө оруулалт/-ийг Санхүүгийн байдлын тайланд богино хугацаат хөрөнгө оруулалтаар ангилан тайлагнана. Борлуулахад бэлэн бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө болон хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгийг Санхүүгийн байдлын тайланд урт хугацаат хөрөнгө оруулалтаар ангилан тайлагнана.
- 6.29 Санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах, борлуулах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн

төлөлтөөс бүрдсэн бол ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө гэж үзнэ.

4. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 6.30 Байгууллага нь зөвхөн дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.
- 1) тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан буюу хүчингүй болсон; эсхүл
 - 2) тухайн санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан.
- 6.31 Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед данснаас хасагдах аргаар бүртгэнэ.
- 6.32 Санхүүгийн хөрөнгийн бүх буюу зарим хэсэг нь үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах тийм шилжүүлэлтээр тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлж болно.
- 6.33 Байгууллага нь санхүүгийн хөрөнгөнд тавих хяналтаа шилжүүлж, өөр санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөртэй болсон тохиолдолд уг шинэ хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч, дансны үнэ ба бодит үнэ цэнийн зөрүүгээр олз, гарзыг хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт ба үл цуглуулагдах байдал

- 6.34 Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан буюу түүний дансны үнэ нь тооцоолсон эргэн нөхөгдөх дүнгээс бага болсон эсэхийг үнэлэх хэрэгтэй. Хэрэв үнэ цэнэ буурсан бол үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын зардлыг хүлээн зөвшөөрнө. Хэрэв санхүүгийн хөрөнгө нь дангаараа материаллаг дүнтэй бол тус тусын хувьд, материаллаг биш бол бүлгийн хувьд үнэ цэнийн бууралтыг тооцоолно.
- 6.35 Үнэ цэнийн бууралтын гарз учирсан гэсэн бодит нотолгоо байгаа бол уг: хорогдуулсан өртгөөр бүртгэдэг зээл ба авлага эсхүл дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн хувьд анхны үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба тэрхүү хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр газрын дүнг хэмжинэ. Тухайн хөрөнгийн дансны үнийг шууд аргыг ашиглан бууруулна. Гарзын дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 6.36 Өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн хувьд ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгийн одоогийн зах зээлийн өгөөжийн түвшнээр дискаунтчилсан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр үнэ цэнийн бууралтын газрын дүнг хэмжинэ.
- 6.37 Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрдөг.

5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 6.38 Санхүүгийн хөрөнгийн ангилал тус бүрийн дансны үнийг санхүүгийн байдлын тайланд эсхүл тодруулгад нэмж тодруулна.
- 6.39 Санхүүгийн хөрөнгийн бүх буюу зарим хэсэг нь үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангасан хөрөнгийн анги тус хувьд тодруулна.
- 6.40 Стандартаар шаардсан тодруулгыг байгууллага бэлтгэсэн байна.

6. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний мэдээллийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, зээлийн ашиглалт гарснаар авлагад дараах байдлаар бүртгэнэ.

(а) Олон улсын байгууллага, түнш орноос гадаад зээл авсан:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(б) Олон улсын байгууллага, түнш орноос авсан гадаад зээлийг дотоодын зээлдэгчид дамжуулан зээлдүүлэх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зээлийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2. Хэрэв дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлийн дагуу уг зээлийг гадаад дахь зээлдүүлэгчийн харилцах данснаас дотоодын эцсийн зээлдэгчид эсхүл тэдний бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчид шууд төлбөр хийж, харин Засгийн газраар дамжуулан зээлдүүлсэн нөхцөлийг гэрээгээр хүлээсэн бол гадаадаас авч ашигласан зээлийн хэмжээгээр түүнийг нотолсон анхан шатны баримтыг үндэслэн дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад зээлдүүлсэн гэж хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зээлийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

- 2.1 Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох спот ханшаар гадаад валютын дүнг бүртгэлийн валют руу хөрвүүлнэ.

(а) Гадаад валютаарх авлагыг валютын ханш өссөн үед цуглуулсан:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Зээлийн авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б) Гадаад валютаарх авлагыг валютын ханш буурсан үед цуглуулсан:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Зээлийн авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

- 2.2 Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагыг тайлант хугацааны эцэст Монгол банкны хаалтын ханшаар үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлж бүртгэнэ.

(а) Гадаад валютын авлагын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст өссөн хаалтын ханшаар үнэлэхэд үүсэх ханшийн зөрүүгийн олз:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зээлийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(б) Гадаад валютын авлагын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст буурсан хаалтын ханшаар үнэлэхэд үүсэх ханшийн зөрүүгийн гарз:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Зээлийн авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2.3 Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагын үлдэгдэлд хийгдсэн ханшийн тэгшитгэлийн олз, гарзыг тухайн тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

3.1 Санхүүгийн хөрөнгийг үл зөвшөөрөх үед:

(а) Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Санхүүгийн хөрөнгийг данснаас хассаны зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүгийн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3.2 Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хэмжиж, бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгийг худалдан авахтай холбоотой ажил гүйлгээний өртгийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

(а) Санхүүгийн хөрөнгө худалдан авахад:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Санхүүгийн хөрөнгө - төрлөөр нь	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(б) Үнэт цаасыг урамшуулалтай худалдан авахад:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Санхүүгийн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүгийн хөрөнгийн урамшуулал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(в) Үнэт цаасыг хөнгөлөлттэй / хямдруулалттай худалдан авахад:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Санхүүгийн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүгийн хөрөнгийн хөнгөлөлт хямдруулалт	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(г) Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын тайлант хугацааны хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хүүгийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хүүгийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(д) Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын тайлант хугацааны ногдол ашгийг хүлээн зөвшөөрөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ногдол ашгийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Ногдол ашгийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(е) Санхүүгийн хөрөнгийн хугацаа дуусч үндсэн төлбөр төлөгдөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүгийн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3.4 Санхүүгийн хөрөнгийг худалдсан бол борлуулсан өдрийн дансны үнэ болон хүлээн авсан мөнгөн хөрөнгийн зөрүүгээр санхүүгийн хөрөнгө борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрнө.

(а) Санхүүгийн хөрөнгийг олзтой борлуулах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүгийн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Санхүүгийн хөрөнгө борлуулсны олз	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(б) Санхүүгийн хөрөнгийг гарзтай борлуулах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүгийн хөрөнгө борлуулсны гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүгийн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3.5 Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэ ангиллын санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, тайлагнах ба бодит үнэ цэнэд гарсан өсөлт, бууралтаас үүссэн хөрөнгө оруулалтын үнэлгээний хэрэгжээгүй олз, гарзыг тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

(а) Бодит үнэ цэнэ нь дансны үнээс бага бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Санхүүгийн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(б) Бодит үнэ цэнэ нь дансны үнээс их бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Санхүүгийн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй олз	..X-XX-XX-XXX		xxx.xx	

(в) Санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчилсөн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Санхүүгийн хөрөнгө	..х-хх-хх-ххх	ххх.хх		
Ашиг, алдагдлаар илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө	..х-хх-хх-ххх		ххх.хх	

7. АВЛАГА

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 4 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- УСНББОУС 30 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга
- Бусад УСНББОУС

1. ХАМРАХ ХҮРЭЭ

- 7.1 Авлага гэж зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээнийхээ төлбөрийг худалдан авагч, бусад харилцагч этгээдээс нэхэмжлэн авах мөнгөн дүнг хэлнэ.
- 7.2 Дансны (Худалдааны) авлага нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн юм.

2. АНГИЛАЛ

- 7.3 Авлагыг дараах байдлаар ангилж болно.
- 1) Татварын авлага;
 - 2) НДШ – ийн авлага;
 - 3) ТЕЗ нар бусад холбоотой талаас авах авлага (эргэлтийн хөрөнгөнд хамаарах дүн);
 - 4) Ажиллагчдаас авах авлага;
 - 5) Байгууллагаас авах авлага /тогтмол зардалтай холбоотой цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус болон эм, хоолны гэх үйл ажиллагаатай холбоотой гэж ангилж болно./;
 - 6) Хувь хүмүүсээс авах авлага;
 - 7) Бусад авлага.
- 7.4 Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран авлагыг ангилан бүртгэлж болно.

3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

- 7.5 Авлагыг найдвартай хэмжиж болохуйц бөгөөд байгууллага нэхэмжлэх баримт үйлдэн худалдан авагч буюу хариуцагч талд шилжүүлснээр мөнгө буюу бусад

- хөрөнгө хүлээн авах эрхтэй болсон нөхцөлд балансдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.
- 7.6 Санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед ажил гүйлгээний өртгийг багтаан, бодит үнэ цэнээр нь хэмжинэ.
- 7.7 Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр эсхүл бодит үнэ цэнээр хэмжинэ.
- 7.8 Хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, анхны дүн ба дуусгавар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хуримтлагдсан хорогдуулгыг нэмж эсхүл хасаж, санхүүгийн хөрөнгийн хувьд, аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно.
- 7.9 Хорогдуулсан өртгийг тооцоолоход үр ашигт хүүгийн аргыг хэрэглэх ба энэ нь орлого ба зардлыг хэрэглүүрийн хугацааны турш тогтмол хувиар хуваарилах арга юм.
- 7.10 Байгууллагаас авах авлагыг аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлагыг энэ дансанд бүртгэнэ. Авлагын тооцоог үүссэн тухай бүр валютын төрлөөр туслах данс нээн бүртгэл хөтөлнө.
- 7.11 Хувь хүмүүстэй үүссэн авлагын тооцоог хувь хүнээс авах авлага гэсэн ангилалд бүртгэнэ.
- 7.12 Дээр дурдсанаас бусад хэлбэрээр үүссэн бусад авлага гэсэн ангиллаар бүртгэнэ. Тооцооны төрөл тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

- 7.13 Хүлээгдэж буй алдагдлын хувийг жил бүрийн эцэст хянаж, шинэчилж байх шаардлагатай.
- 7.14 Авлагуудын төлөгдөхгүй байх магадлал дүнг тооцоолоход доорх зүйлсийг харгалзан үзнэ.
- 1) Авлага нь төлөгдөх хуваарьт өдрөөс хойш 1 жилээс дээш хугацаанд хөдөлгөөн хийгдээгүй бол,
 - 2) Авлага нь харилцагч талтай тооцоо зөрүүтэй, баталгаажаагүй тохиолдолд чанар муудсан байх, муудах тохиолдол үүсэх магадлал ихэссэн гэж үзнэ.
- 7.15 Дээрх ерөнхий үнэлгээнээс гадна тус авлагын үнэ цэнийн бууралтын тухай олж авсан тухайлсан мэдээлэл, дүгнэлтэнд үндэслэх ёстой.

4. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 7.16 Авлага эргэн төлөгдөх найдваргүй болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон үед шүүхийн шийдвэр, нотолгоог үндэслэн тухайн авлагын шинж чанар, дүнгээс хамаарч байгууллагын гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогчийн зөвшөөрөл, шийдвэрээр авлагыг данснаас хасаж авлага хариуцсан нягтлан бодогч бүртгэлд тусгана.

5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 7.17 Авлагын тооцоотой байгууллага, иргэд тус бүрийн хувьд авлагын дэлгэрэнгүй бүртгэл нээж, хөтлөх бөгөөд авлагын болон төлбөрийн гүйлгээ гарсан тухай бүр үлдэгдлийг шинэчлэж байна.

- 7.18 Тайлант үе бүрээр авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг нэгтгэж, дэлгэрэнгүй бүртгэлийн товчоо буюу хөдөлгөөний тайланг авлагын ангилал бүрээр бэлтгэж, дэлгэрэнгүй бүртгэл, балансын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- 7.19 Сар бүрийн эцэст материаллаг дүн бүхий авлагын үлдэгдлийг холбогдогч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж, баталгаажуулна.
- 7.20 Авлагыг санхүүгийн байдлын тайланд дараах авлагын төрлөөр нь ангилан тайлагнана.
- 7.21 Авлагын дансдын төрөл тус бүрийн хувьд доорхи асуудлыг санхүүгийн тайланд тодруулна. Үүнд:
- 1) Авлагын үнэлгээ, үнэлгээнд баримталсан зарчим;
 - 2) Авлагын ангилал тус бүрээрх үлдэгдлийн дэлгэрэнгүй жагсаалт (үүссэн жагсаалт, насжилт, баталгаажуулалт);
 - 3) Гадаад валютаарх дансны авлагыг тайлангийн валют руу хөрвүүлэхэд ашигласан ханшийг тодруулах;
 - 4) Данснаас хасагдсан авлагын дэлгэрэнгүй жагсаалт (данснаас хассан үндэслэл ба шийдвэр);
 - 5) Насжилт;
 - 6) Авлагын дансны аливаа хязгаарлалтууд (барьцаалал, шилжүүлэлт, худалдаа зэрэг);
 - 7) Болзошгүй авлагууд;
 - 8) Балансын дараах авлагатай холбоотой үйл явдал.

6. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Дансны авлагатай холбоотой журналын бичилтүүд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Орлого, холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Авлага төлөгдөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Дансны авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2. Бусад авлагын хувьд

а. Хүүгийн авлага

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хүүгийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хүүгийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Авлага төлөгдөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хүүгийн авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3. Торгууль, алдангитай холбоотой бусад авлага

а. Тайлант үеийн эцэст гэрээнд заасан хувь хэмжээгээр ноогдуулсан торгуулийн орлогыг хүлээн зөвшөөрөх буюу торгуулийг авахаар нэхэмжилсэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бусад авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Торгуулийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

6. Авлага төлөгдөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бусад авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. Бусад орлого, олзтой холбоотой авлага

а. Мөнгө төлөгдөөгүй боловч гэрээ, эрхийн актаар хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэхэмжилсэн орлогын дүнгээр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бусад авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үйл ажиллагааны бус бусад орлого ба олз	..X-XX-XX-XXX		xxx.xx	

6. Авлага төлөгдөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бусад авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

5. Найдваргүй авлагыг данснаас хасах үеийн журналын бичилтүүд

а. Авлага эргэн төлөгдөхгүй болох нь батлагдсан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Найдваргүй авлагын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Холбогдох авлагын данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

6. Найдваргүй гэж үзсэн авлага эргэн төлөгдсөн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Холбогдох авлагын данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Найдваргүй авлагын орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Холбогдох авлагын данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

8. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС
- Бусад УСНББОУС

1. ХАМРАХ ХҮРЭЭ

- 8.1 Урьдчилж төлсөн тооцоо, зардал нь тайлант хугацаанд мөнгө буюу бусад зарлага гарсан боловч дараагийн тайлант хугацаанд зардал буюу бараа, үйлчилгээгээр тооцогдох ирээдүй цагийн зарлагыг илэрхийлнэ.
- 8.2 Урьдчилгаа буюу урьдчилж төлсөн тооцоо нь мөнгө, бараа материал, хөрөнгө, үйлчилгээгээр хаагдах тооцоо юм.
- 8.3 Урьдчилж төлсөн зардал гэдэг нь мөнгө, бараа, үйлчилгээ буцаан авахгүй харин зардал болж, орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөх зарлагыг илэрхийлнэ.
- 8.4 Урьдчилж төлсөн тооцоо гэдэг зардал нь нэг жилийн дотор хаагдах, тооцогдох шинж чанартай тул цаашид хөрөнгө бүртгэгдэнэ.

2. АНГИЛАЛ

- 8.5 Урьдчилж төлсөн тооцоо, зардлыг санхүүгийн тайланд үндсэнд нь урьдчилж төлсөн тооцоо, урьдчилж төлсөн зардал гэж хоёр ангилан харуулна. Урьдчилж төлсөн тооцоо, зардлыг ажил гүйлгээний утга, гүйлгээ гарсан валютын төрлөөс хамааран ангилж, дэд дансдыг бүртгэнэ.
- 8.6 Урьдчилж төлсөн тооцоо, зардал нь нэг жилийн дотор буцаан тооцогдох бүх төрлийн мөнгөн ба мөнгөн бус урьдчилгаа, урьдчилж төлсөн зардлаас бүрдэнэ.
- 8.7 Урьдчилж төлсөн тооцоо нь бараа материал, үндсэн хөрөнгө бэлтгэхээр олгосон урьдчилгаа, ажил үйлчилгээ ханган нийлүүлэхээр олгогдсон урьдчилгаа, томилолтын зардлын урьдчилгаа гэсэн бүрэлдэхүүнтэй байна.
- 8.8 Урьдчилж төлсөн зардал нь ажил гүйлгээний эдийн засгийн утгаас хамааран урьдчилж төлсөн даатгалын зардал, урьдчилж төлсөн түрээсийн зардал гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байж болно.
- 8.9 Урьдчилж төлсөн тооцоо: Худалдан авах бараа, үйлчилгээний үнийг урьдчилан төлсөн тооцоо болон мөнгөөр төлөөд буцаан мөнгөн хэлбэрээр барагдуулах зориулалтаар үүссэн тооцоог хамааруулна. Тухайлбал: Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа гэх мэт тооцоонууд хамаарагдана.
- 8.10 Урьдчилж төлсөн зардал: Нэг буюу хэд хэдэн тайлант үед ногдох зардлыг бөөнд нь урьдчилан төлсөнтэй холбоотой үүссэн тооцоог хамааруулах ба эдгээр тооцоо нь системтэйгээр зардал хэлбэрээр хүлээн зөвшөөрөгдөнө. Жишээ нь, урьдчилан төлсөн даатгалын зардал, урьдчилан төлсөн үйл ажиллагааны түрээс гэх мэт.

3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

- 8.11 Урьдчилж төлсөн зардал болон тооцоог төлөгдсөн дүнгээр үнэлж бүртгэнэ.
- 8.12 Байгууллага нь бараа эсхүл хөрөнгө худалдан авах зорилгоор урьдчилан төлбөр гүйцэтгэх болон дараа тооцоогоор мөнгөн хөрөнгийг бусдад түр ашиглуулсан үед уг тооцоог Урьдчилж төлсөн тооцоо хэмээн хүлээн зөвшөөрч бүртгэнэ.
- 8.13 Нэг эсхүл хэд хэдэн тайлант үед ногдох зардлыг талуудын хооронд байгуулсан хүчин төгөлдөр гэрээний дагуу бөөнд нь урьдчилан төлсөн үед урьдчилж төлсөн зардлыг хүлээн зөвшөөрнө.
- 8.14 Урьдчилж төлсөн зардал хэрэгжсэн үед урьдчилж төлөгдсөн зардлыг холбогдох тайлант үед зардлаар бүртгэнэ.

4. ТОДРУУЛГА

- 8.15 Урьдчилж төлсөн тооцоо, зардлыг урьдчилгаа, зардлын төрөл, харилцагч бэлтгэн нийлүүлэгч, ажилтан зэргээр тодруулга хийж харуулна. Мөн

урьдчилгааны зориулалт, олгосон хугацаа, валютын төрөл зэрэг мэдээллийг тодруулж, санхүүгийн тайланд тэмдэглэл хэлбэрээр харуулна.

- 8.16 Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардлыг тооцоотой байгууллага, иргэд тус бүрийн хувьд урьдчилгаа төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэл нээж, хөтлөх бөгөөд төлбөр хийх болон хаагдах гүйлгээ гарсан тухай бүр үлдэгдлийг шинэчлэж байна.
- 8.17 Тайлант үе бүрээр урьдчилгаа, урьдчилж төлсөн зардлын дэлгэрэнгүй бүртгэлийг нэгтгэж, дэлгэрэнгүй бүртгэлийн товчоо буюу хөдөлгөөний тайланг ангилал бүрээр бэлтгэж, дэлгэрэнгүй бүртгэл, балансын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.
- 8.18 Тайлант хугацааны эцэст материаллаг дүн бүхий тооцооны үлдэгдлийг холбогдогч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж, баталгаажуулна.
- 8.19 Урьдчилгаа хүссэн баримтанд урьдчилгаа авах гэж байгаа шалтгаан, мөн урьдчилгаатай холбогдон гарах зардал ямар тайлангийн улиралд хамаарагдахыг тодорхойлсон байх ёстой.

5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Урьдчилж төлсөн тооцоо

а. Бэлтгэн нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урьдчилж төлсөн тооцоо	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Бэлтгэн нийлүүлэгчээс бараа материал, хөрөнгийг хүлээн авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа, материал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урьдчилж төлсөн тооцоо	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2. Урьдчилж төлсөн зардал

а. Тайлант үеийн өртөг зардлаар хаагдах, ажил үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн үед урьдчилж төлсөн зардал дансанд төлбөр хийсэн валют, төгрөгөөр зэрэг бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урьдчилж төлсөн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Ажил үйлчилгээг хүлээн авч зохих өртөг, зардалд урьдчилгааг хаах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Холбогдох зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урьдчилж төлсөн зардал	..X-XX-XX-XXX		xxx.xx	

9. БАРАА МАТЕРИАЛ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга

- УСНББОУС 12 Бараа материал
- УСНББОУС 21 Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- УСНББОУС 26 Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- Бусад УСНББОУС

1. ХАМРАХ ХҮРЭЭ, ОНЦЛОГ

- 9.1 Бараа материалын нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх ба холбогдох орлогыг хүлээн зөвшөөрөх хүртэл дараагийн үеүдэд тусгах өртгийн дүнг тодорхойлоход чиглэгдэнэ. Мөн материалын нөөцийг оновчтой бүртгүүлж, хэмжилтийг зөв хийж, үр ашигтай хуваарилж зарцуулах, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зөв зохион байгуулж хөтлөх, дотоод хяналтыг сайжруулахад оршино.
- 9.2 Бараа материал байгууллагын эзэмшилд байгаа дараах хөрөнгүүд орно.
- 1) Үйлдвэрлэлийн процессод ашиглах, зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа;
 - 2) Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах буюу түгээн хуваарилагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа;
 - 3) Хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах буюу түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа;
 - 4) Борлуулах буюу түгээн хуваарилахын тулд үйлдвэрлэлийн процессод байгаа.
- 9.3 Бараа материал байгууллагын эзэмшилд дараах хөрөнгүүд юм.
- 9.4 Улсын секторын байгууллагуудын хувьд бараа материал нь буцаан борлуулахын тулд худалдан авч эзэмшиж буй бараа, борлуулах зорилгоор үйлдвэрлэсэн бараанаас илүүтэйгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой байдаг.
- 9.5 Зарим барааг нэн даруй ашиглахын тулд биш харин бичиг хэрэг, оффисын хангамж, цэвэрлэгээний материал, жижиг нөөц гэх мэт хэрэглээний материалаа нөөцлөхийн тулд худалдаж авдаг. Заримдаа эдгээр зүйлсийг нягтлан бодох бүртгэлийн нэг тайлант үед худалдаж аваад дараагийн тайлант үед ашиглах нь бий. Гэхдээ хангамжийн материалуудын үнэ тус бүрдээ буюу дангаараа бага байвал өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болгон ашигладаг бөгөөд хэрэгцээгүй байхад нь хуримтлуулахгүй байх үүднээс хяналт тавьж, худалдаж авсан тайлант хугацааны зардлаар тооцох хэрэгтэй: өөрөөр хэлбэл, эдгээр зүйлсийн өртгийг нягтлан бодох бүртгэлийн өөр өөр тайлант үеүдэд хуваарилах шаардлагагүй.
- 9.6 Эдгээр зүйлсийг нөөцлөхдөө бодит хэрэгцээтэй уялдуулах буюу түүнээс хэтрүүлэн хуримтлуулахгүй байх, хуучирч муудах эсхүл хадгалах хугацаа хэтэрснээр муудах зэргээс зайлсхийх үүднээс тодорхой хэмжээнд шалгаж байх нь зүйтэй.
- 9.7 Эсрэгээрээ, "хангамж" гэдэг нь аж ахуйн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгддэг бараа юм. Жишээлбэл, бичиг хэрэг, ажлын байран дээрх бүтээгдэхүүн, сургуулийн материалын нөөц (сурах бичиг орно), эмнэлэг, эрүүл мэндийн хэрэглээний материал, жижиг сэлбэг хэрэгсэл, инженерийн

хангамжийн зүйлсийг хэлж болно. Эдгээр зүйлийг нягтлан бодох бүртгэлд тусгайлан авч үзэхгүй, ихэвчлэн худалдан авмагц зарлагаддаг.

- 9.8 Хангамжийн материал ба бараа материалын хоорондох ялгааны талаар байнга маргаан өрнөдөг бөгөөд энэ нь эд бараа/ таваар (goods)-ыг бараа материал, эсхүл хэрэглээний материалын алин гэж үзэх асуудал юм. Заримдаа, материаллаг байдал ба өртөг-үр өгөөжийн тэнцвэрт үндэслэсэн шийдвэр гаргах нь бий. Эд бараа/ таваар тус бүрийн үнэ цэнэ бага, агуулах дахь хөдөлгөөний өөрчлөлт их биш байвал тэдгээрийг хэрэглээний материал гэж үзэх хандлага илүү хүчтэй байдаг. Харин эд бараа/ таваарын үнэ цэнэ өндөр, эзэмших буюу хадгалах хугацаа урт, илүү арилжааны шинжтэй орчинд ашиглагддаг, агуулах дахь хөдөлгөөн нь бизнесийн мөчлөгтэй зэрэгцэн өсч, буурч болзошгүй тохиолдол нь тэдгээрийг бараа материал гэж үзэх хандлагыг илүү хүчтэй болгодог.

2. АНГИЛАЛ

- 9.9 Улсын секторын байгууллагуудын хувьд бараа материал нь буцаан борлуулахын тулд худалдан авч эзэмшиж буй бараа, борлуулах зорилгоор үйлдвэрлэсэн бараанаас илүүтэйгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой байдаг.
- 9.10 Улсын секторын бараа материалд дараах зүйлс хамаарч болно.
- 9.11 Бараа материалын үндсэн ангилал нь дэд ангилалтай байна.
- 9.12 Бараа материалыг дараах дэд ангиллаар ангилж, ангилал бүрээр туслах данс нээж бүртгэнэ. Үүнд:
- 1) Цэргийн тоног төхөөрөмж;
 - 2) Барааны агуулах;
 - 3) Засвар, үйлчилгээний материал;
 - 4) Үндсэн хөрөнгийн стандартад хамаарахаас бусад, үндсэн хөрөнгийн сэлбэг хэрэгсэл;
 - 5) Стратегийн нөөц;
 - 6) Дуусаагүй үйлдвэрлэл;
 - 7) Боловсрол/сургалтын материал;
 - 8) Үйлчилгээг холбоогүй талуудын ажил гүйлгээний үнээр борлуулдаг тохиолдолд үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээ;
 - 9) Борлуулах зорилгоор эзэмшиж буй газар, үл хөдлөх хөрөнгө;
 - 10) Үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө;
 - 11) Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс.

- 9.13 Байгууллага бараа материалын дансад ямар хөрөнгийг бүртгэхийг байгууллагынхаа **бодлогын** баримт бичгээр тодруулна.

- 9.14 **Түүхий эд, материал** – *Үйлдвэрлэлийн боловсруулах үйл ажиллагаанд орж хэлбэр дүрсээ өөрчлөх, эсхүл үйлчилгээнд ашиглах байдлаар шууд зарцуулагдах*, худалдан авсан үндсэн түүхий эд, туслах **материал** орно. Энэ хэсэгт удирдлага, борлуулалтын үйл ажиллагаанд ашиглагдах хангамжийн материал болон бусад туслах материалыг оруулахгүй. Эмийн зардал, хоол,

Бараа, Бэлэн бүтээгдэхүүн

- 9.15 Худалдан борлуулах зорилгоор үйлдвэрлэсэн болон гадны байгууллага, хувь хүнээс худалдан авсан, олж бэлтгэсэн хөрөнгө орно.
- 9.16 Бараанд худалдан борлуулах зорилгоор эзэмшиж байгаа бараа, худалдан авагчид өмчлөх эрх шилжээгүй ачуулсан бараа, агентын бараа, бизнесийн үйл

ажиллагаанд ашиглахгүй цаашид борлуулах зориулалттай үндсэн хөрөнгө болон барилга гэх мэт хөрөнгүүд хамрагдана.

9.17 **Хангамжийн материал**-үйлдвэрлэл, **үйлчилгээнд** болон удирдлага, борлуулалтын **үйл ажиллагаанд ашиглагдах** нэг жилээс бага хугацаанд, эсхүл **үйл ажиллагааны нэг циклд зарцуулагдах хангамжийн материал, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материал, бичиг хэргийн зүйлс, бусад хангамжийн шинжтэй зүйлүүд орно.**

9.18 Хангамжийн материалыг 2 ангилан бүртгэнэ.

1. **Агуулахад байгаа хангамжийн материал.** Энэ хөрөнгийг тавьж олгосон үед нь шууд зардлаар хүлээн зөвшөөрнө.

- 1) Засвар үйлчилгээний хангамжийн зүйлс (Багаж хэрэгсэл);
- 2) Бичиг хэргийн зүйлс;
- 3) Нийтлэг аж ахуйн хангамжийн зүйлс;
- 4) Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл.

Жишээ нь: бичиг хэргийн зүйлс, цэвэрлэгээний материал, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, ном, сэтгүүл, бага үнэтэй олон жил ашиглаж болох хөрөнгө тооны машин, хогийн сав, ус буцалгагч, тог баригч, ...

Байгууллага нь эдгээр хөрөнгийг ямар хугацаанд тавьж олгох тухай бодлоготой байна. тухайлбал, нормын хувцасаар 2 жилд нэг удаа хангах, анх ажилд орох үед нь бичгийн хэрэгслээр хангах гэх мэт.

2. **Ашиглалтанд буй хангамжийн материал** – энэ нь дараах шинжтэй байна.

- 1) Нэг жилээс дээш ашиглалтын хугацаанд үйл ажиллагаанд ашиглагдах хангамжийн материал;
- 2) Тодорхой ашиглалтын хугацаатай байх;
- 3) Үндсэн хөрөнгөнд бүртгэх босго үнийн шалгуурт хүрэхгүй байх;
- 4) Ихэвчлэн үйлчилгээ үзүүлэх албан тасалгаанд байрлуулдаг байх.

Жишээ нь ширээ, сандал, хөшиг, тавилга, толь, өлгүүр, сургалтын болон лаборторийн багаж хэрэгсэл, сурах бичиг....

Эдгээр хөрөнгийн ашиглалтад байгаа хангамжийн материал гэсэн ангилалд бүртгэнэ. Тодорхой ашиглалтын хугацааны дараа тухайн хөрөнгөө зардлаар хүлээн зөвшөөрнө.

9.19 *Шатах тослох материал-байгууллагын тээвэр, үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай дизелийн түлш, бензин, тослох материал зэргийг зүйл бүрээр данс нээж бүртгэнэ.*

9.20 Аюулгүйн нөөц-байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн үед байгууллагын аюулгүй, найдвартай хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор бүрдүүлсэн түлш, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нөөц юм.

9.21 Аюулгүй нөөцөд байх сэлбэг хэрэгслийн жагсаалтыг байгууллагын гүйцэтгэх захирлын тушаалаар батлах ба цех тус бүрд бараа материалын нөөцийн данс тусад нь нээж. ангилан бүртгэнэ.

3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

9.22 Хөрөнгийн тодорхойлолт болон дараах хоёр шалгуурыг хангаж байгаа тохиолдолд хөрөнгийг хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын тайланд тусгана.

- 1) Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь байгууллагад орох нилээд их магадлалтай байх;
- 2) Хөрөнгийн өртгийг найдвартай хэмжиж чадах.

- 9.23 Ирээдүйд эдийн засгийн үр ашиг авчрах нь эргэлзээтэй байх зүйлд зардал гаргасан байвал тийм зүйлийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.
- 9.24 Хөрөнгийн тодорхойлолтыг хангах боловч санхүүгийн тайлагналын зорилтуудад хүрэхийн тулд чанарын шинжүүдийг хангалттай биелүүлэх тийм арга замаар хэмжих боломжгүй зүйлсийн талаарх мэдээллийг тодруулгад тусгана.
- 9.25 Тодорхойгүй байдал үүсэхэд хүргэх хэрэв байгаа бол тэдгээр нь өөрчлөгдөж болно. Иймээс тодорхойгүй байдлыг тайлангийн өдөр бүрээр нь үнэлэх нь чухал ач холбогдолтой байдаг.
- 9.26 УСНББОУС-12 “Бараа материал” стандартын 15-р параграфт заасны дагуу хэмжинэ.
- 9.27 Бараа материалыг ямар зорилгоор эзэмшиж байгаагаас хамааруулан өртөг ба цэвэр боломжид үнэ цэнийн аль багаар эсхүл өртөг ба орлуулалтын өртгийн алт багаар нь хэмжинэ.
- 9.28 Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ.
- 9.29 Бараа материалыг дараах зорилгоор эзэмшиж буй тохиолдолд өртөг ба одоогийн орлуулалтын өртгийн аль багаар нь хэмжинэ:
- 1) Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах, эсхүл
 - 2) Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах барааны үйлдвэрлэлийн процессод ашиглан зарцуулах.
- 9.30 Байгууллагын хувьд бараа материалыг байнгын системийн аргаар бүртгэнэ.
- 9.31 Байнгын систем нь бараа материалын орлого зарлагын хөдөлгөөнийг гарсан тухай бүрт нь бараа материалын дансанд бүртгэх ба бараа материал нэг бүр дээр карт хөтөлдөг арга юм.
- 9.32 Бараа материалын өртөг нь худалдан авалтын бүх өртөг зардал, хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гарсан бусад зардлаас бүрдэнэ.
- 9.33 Бараа материалын худалдан авалтын өртөг нь худалдан авсан үнэ, импорт татвар ба бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас тухайн аж ахуйн нэгж дараа нь нөхөн авч болохоос бусад), тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэл бүтээгдэхүүн, материал, үйлчилгээний худалдан авалтанд шууд хамаарах бусад зардлуудаас бүрддэг. Худалдан авалтын өртгийг тодорхойлохдоо худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлсийг хасна.
- 9.34 Гадаад валютаар худалдан авсан бараа материалыг төгрөгт хөрвүүлж бүртгэлд тусгахдаа худалдан авсан өдрийн Монголбанкны ханшид үндэслэнэ.
- 9.35 Бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гарсан зөвхөн тэр хэмжээгээр бусад зардлыг тухайн бараа материалын өртөгт оруулдаг.
- 9.36 Харилцан сольж орлуулах боломжгүй бараа материал, түүнчлэн тусгай төслүүдэд зориулан үйлдвэрлэсэн ба тусгаарласан бараа эсхүл үйлчилгээний өртгийг тодорхойлохдоо тусгайлан тэмдэглэлтийг аргыг ашиглана.
- 9.37 Байгууллага нь дээр дурдсанаас бусад бараа материалын өртгийг эхэлж авсныг эхэлж зарлагадах аргыг ашиглан хуваарилна.
- 9.38 Эхэлж авсныг эхэлж зарлагадар арга-эхлээд худалдан авсан буюу үйлдвэрлэсэн бараа материалыг эхэлж борлуулна гэж төсөөлдөг бөгөөд иймээс тайлант үеийн эцэст үлдэж байгаа бараа материал нь хамгийн сүүлд худалдан авсан буюу үйлдвэрлэсэн зүйлс байх юм.

Бараа материалын үнэлгээ

- 9.39 Бараа материал гэмтсэн, бүхэлдээ буюу хэсэгчлэн хоцрогдолд орсон, эсхүл тэдгээрийн борлуулалтын үнэ буурсан бол бараа материалын өртөг нь нөхөгдөхгүй болж болох юм. Тиймээс бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар эсхүл өртөг ба орлуулалтын өртгийн аль багаар нь үнэлнэ.
- 9.40 Цэвэр боломжит үнэ цэнийн тооцоололд тухайн бараа материалыг эзэмшиж буй зорилгыг харгалзан үздэг. Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зах зээлээс олж авч чадахгүй тохиолдолд орлуулалтын өртгийг тооцоолох шаардлагатай байдаг.
- 9.41 Орлуулалтын өртгийг тайлант үе бүрийн эцэст тооцох бөгөөд орлуулалтын өртөг нь өртгөөс бага тохиолдолд үнийн бууралтын гарз үүсэх бөгөөд уг гарзыг тухайн тайлант үеийн зардал гэж үзнэ.
- 9.42 Хэрэв материал ба бусад хангамжийн зүйлсийг ашиглах түгээн хуваарилахаар хүлээгдэж байгаа бол тэдгээр бараа материал ба хангамжийн зүйлсийг өртгөөс нь бага дүнгээр бүртгэхгүй.
- 9.43 Нэг үес дээш хугацаанд хугацаанд эзэмшиж байгаа барааны орлуулалтын өртөг нь өсвөл өмнөх тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн үнийн бууралтыг буцаана.

Бараа материалын үнэлгээний хасагдуулга

- 9.44 Улсын секторын байгууллагад ихэвчлэн бараа материалыг өртөг ба одоогийн орлуулалтын өртөгийн аль багаар нь үнэлэхийн тулд орлуулалтын өртгөөс давсан өртгийн дүнгээр үнэлгээний хасагдуулга бүртгэнэ.
- 9.45 Мөн тайлант жилийн эцсээр бараа материалын үлдэгдэлд тооллого хийн агуулахад хадгалагдаж байгаа хугацаагаар нь бараа материалын насжилтын судалгаа гаргана. Уг насжилтын судалгаанд хамрагдсан материал тус бүрийн цаашид ашиглагдах боломжтой байдал, биет байдлаараа хуучирч муудсан, моралын элэгдэлд орсон, удаан хугацаагаар ашиглагдахгүй байгаа эсэхэд тооллогын комисс болон өмч хамгаалах Байнгын зөвлөл үнэлгээ, дүгнэлт гаргана.
- 9.46 Дээрх үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн хуучирсан, ашиглалтгүй байгаа бараа материалын хасагдуулгыг байгууллагын удирдлагаас өмнөх жилүүдийн туршлага дээр үндэслэн тусгай хувь тогтоон гаргаж батална.
- 9.47 Хуучирсан болон ашиглалтгүй байгаа бараа материалын хасагдуулгын эхний эцсийн үлдэгдэлийн зөрүүгээр бууралтын гарз үүсэх бөгөөд уг гарзыг тухайн тайлант үеийн зардал гэж үзнэ.

4. ЗАРДАЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ

- 9.48 Бараа материалыг борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилах тохиолдолд холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед тэдгээр бараа материалын дансны үнийг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Хэрэв хамаарах орлого байхгүй бол барааг түгээн хуваарилсан буюу холбогдох үйлчилгээг үзүүлсэн үед зардлыг хүлээн зөвшөөрнө. Бараа материалын аливаа бууруулалтын дүн ба бараа материалын бүх гарзыг тэдгээр бууруулалт эсхүл гарз гарсан тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрнө. Бараа материалын аливаа бууруулалтыг буцаах аливаа буцаалтыг өмнө нь зардлаар хүлээн

зөвшөөрсөн бараа материалын дүнгийн бууралт байдлаар тухайн буцаалт хийгдсэн тайлант үед хүлээн зөвшөөрнө.

- 9.49 Зарим бараа материалыг, тухайлбал өөрөө барьж байгуулж буй үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэг байдлаар ашиглагдах бараа материалыг бусад хөрөнгийн дансад хуваарилан ангилж болох юм. Ийм байдлаар өөр бусад хөрөнгөнд хуваарилагдсан бараа материалыг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид зардал гэж хүлээн зөвшөөрнө.
- 9.50 Бараа материалыг ашиглалтанд тавьж олгосон үед нь тайлант хугацааны өртөг, зардлаар хүлээн зөвшөөрнө. Хангамжийн материалын энэ хэсэгт бага үнэтэй зүйлс тухайлбал: тооны машин, хогийн сав, бичгийн хэрэгсэл,
- 9.51 Ашиглалтанд тавьж олгосон бараа материал нь удаан хугацаанд ашиглагдахаар бол ашиглалтанд буй хангамжийн материал дансанд бүртгэж, тухайн бараа материалд хяналт тавина. Эдгээр хөрөнгийн тодорхой ашиглалтын хугацааны эцэст зардалд бичнэ.
- 9.52 Бараа материалын тооллого хийхэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12-р зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэнэ.
- 9.53 Байгууллагын үйл ажиллагаанд нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах үнэ бүхий хангамжийн зүйлсийг зарлага болгохдоо хэрэглэглэж байгаа хэрэглэж байгаа ажилтан, албан хаагчийн нэр дээр карталж /эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлд/ ашиглалтаас хасах үед зарлага болгоно.
- 9.54 Бараа материалын тооллогыг хагас, бүтэн жил, ажил хүлээлцэх тооллогыг товлосон хугацаанд бусад тохиолдолд, гэнэтийн нөхцөлөөр хийлгэнэ. Тооллогын комисс гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдох бөгөөд тооллого хийсний дараа тооллогын комиссын акт үйлдэж, нэг хувийг агуулахын няравт, нөгөө хувийг бараа материалын нягтлан бодогчид хүлээлгэн өгнө. Байгууллагын нягтлан бодогч нь бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.
- 9.55 Бараа материалын тооллогоор илэрсэн илүүдлийг "Тооллогоор илүүдсэн олз" дансанд, дутагдлыг тооллогын комиссын актыг үндэслэн холбогдох эд хариуцагчаар төлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд авлага үүсгэн бүртгэнэ.

5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 9.56 Санхүүгийн тайланд бараа материалыг авлагын дараа толилуулна. Бараа материалын дүн нь анхны өртгөөс үнэ цэнийн бууралтыг хасагдуулсан дансны үнэ байна.
- 9.57 Санхүүгийн тайланд дараах зүйлсийг тодруулна:
- 1) бараа материалыг хэмжихэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, үүн дотроо ашигласан өртгийн томъёолол;
 - 2) бараа материалын нийт дансны үнэ болон тухайн аж ахуйн нэгжид тохирох ангилал тус бүрийн бараа материалын дансны дүн;
 - 3) борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр бүртгэсэн бараа материалын дансны үнэ;
 - 4) тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын дүн;
 - 5) тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын аливаа бууруулалтын дүн;

- 6) зардал гэж хүлээн зөвшөөрсөн бараа материалын дүнгийн бууруулалт байдлаар тухайн тайлант үед хүлээн зөвшөөрсөн аливаа бууруулалтын буцаалтын дүн;
- 7) бараа материалын бууруулалтын буцаалт хийхэд хүргэсэн нөхцөл байдал буюу үйл явдал;
- 8) өр төлбөрийн баталгаа болгож барьцаалсан бараа материалын дансны үнэ.

9.58

6. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Бараа материалын дансдын худалдан авалт, өртөг бүрдэлтийн үндсэн бичилт нь дараах байдалтай байна. Бараа материалыг бэлнээр болон зээлээр худалдан авсан эсэхээс үл хамааран бэлтгэн нийлүүлэгчийн өглөг үүсгэн бүртгэлд тусгана.
 - а. Дотоодын зах зээлээс авсан бараа, материалын худалдан авалтын өртөг Худалдан авсан үнэ дээр тээврийн зардал болон худалдан авалттай холбоотой бусад нэмэгдэл зардлуудыг нэмсэн дүнгээс бүрдэнэ.

I. Аж ахуйн нэгж, хувь хүнээс бараа материал худалдан авсан тохиолдолд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материал-холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		Худалдан авсан өртгөөр
Дансны өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Худалдан авсан үнээр
Дансны өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Тээврийн зардал
Дансны өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Бусад зардал

Хэрэв бараа хүлээн авахаас өмнө урьдчилгаа төлбөр төлсөн бол “Урьдчилж төлсөн тооцоо” дансаар бүртгэх бөгөөд барааг хүлээн авсаны дараа дансны өглөг дансанд хааж бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны өглөг	..x-xx-xx-xxx	xxx.xx		Урьдчилгаанд төлсөн дүнгээр
Урьдчилж төлсөн тооцоо /мөнгийг урьдчилж төлсөн бол/	..x-xx-xx-xxx		xxx.xx	Урьдчилгаанд төлсөн дүнгээр

II. Татвар төлөгч бус хувь хүнээс бараа материал худалдан авсан тохиолдолд:

Татвар төлөгчөөр бүртгүүлээгүй хувь хүнээс бараа материал худалдан авсан тохиолдолд хувь хүний орлогын албан татварыг суутгаж, ТТ-12 тайлангийн тохирох хэсэгт тайлагнаж, татвар ногдуулан, уг татварыг харъяа дүүргийн татварын албанд шилжүүлнэ.

- Бараа материал орлого авах үед

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материал-холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		Худалдан авсан өртгөөр
Дансны өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Худалдан авсан үнээр
Дансны өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Тээврийн зардал
Дансны өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Худалдан авалтын бусад зардал

- Бараа материалын үнийг төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Худалдан авсан үнээр
Дансны өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Тээврийн зардал
Дансны өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		Худалдан авалтын бусад зардал
ХХОАТ-ын өглөг бусад	..X-XX-XX-XXX		xxx	Худалдан авсан үнийн 10%
Харилцах	..X-XX-XX-XXX		xxx	Татвар хассан дүн

б. Гадаадын зах зээлээс худалдан авсан материал, сэлбэгийн худалдан авалтын өртөг

Худалдан авсан үнэ дээр импортын болон бусад татвар, тээврийн зардал, гаалийн бүрдүүлэлтийн зардал зэрэг зардлуудыг нэмсэн дүнгээс бүрдэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материал-холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		Худалдан авсан өртгөөр
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Худалдан авсан үнэ
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Тээврийн зардал
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Гаалийн бүрдүүлэлт тээвэр зуучийн зардал
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Гаалийн татвар

Худалдан авалттай холбоотой нэмэгдэл зардлыг тохиромжит суурийг үндэслэн худалдан авсан тухайн хөрөнгийн нэр төрөл тус бүрээр барааны өртөгт хуваарилна. Нэг нэр төрлийн хөрөнгийн нийт өртгийг тухайн төрлийн хөрөнгийн тоо, хэмжээнд харьцуулах замаар нэгжийн өртгийг тодорхойлно.

Импортоор худалдан авч байгаа сэлбэг, материал, хөрөнгийн худалдан авалтын өртгийг тодорхойлж, бүртгэх, худалдан авсан хөрөнгийн нэр төрөл тус бүрийн өртөг, нэгжийн өртгийг тооцож бүртгэл хөтлөх үйл ажиллагааг хариуцсан нягтлан бодогч гүйцэтгэнэ.

В. Бараа материалын зүйлийг хандив, бэлэглэл зэрэг бусдаас үнэ төлбөргүйгээр хүлээн авсан эсхүл шилжүүлсэн үед:

Тухайн бараа материалыг үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн тохиолдолд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материалын шилжүүлсэн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		Нэрлэсэн үнэ цэнээр
Бараа материал	..XX-XX-XX-XXX		xxx.xx	Нэрлэсэн үнэ цэнээр

Тухайн бараа материалыг бодит үнэ цэнээр нь үйл ажиллагааны бус орлогоор бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материал-холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		Бодит үнэ цэнээр
Бусад орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	Бодит үнэ цэнээр

2. Бараа, материалын зарлагын бүртгэл

а. Гадны байгууллага, хувь хүмүүст бараа материалыг борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилах үед тухайн тайлант хугацаанд түүний дансны үнийг зардал гэж хүлээн зөвшөөрнө. *Борлуулсан барааг ЭАЭЗА аргаар нь зарлага болгоно.*

б. Хэрэв бараа материалыг худалдан борлуулсан үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материалын зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		Өртгөөр нь
Бараа, материал /холбогдох данс/	..x-xx-xx-xxx		xxx.xx	Өртгөөр нь

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..x-xx-xx-xxx	xxx.xx		Бодит үнэ цэнээр
Бараа борлуулсаны орлого	..x-xx-xx-xxx		xxx.xx	Бодит үнэ цэнээр

3. Бараа, материалын үнэ цэнийн бууралтын бүртгэл

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ өртгөөс бага болж үнийн бууралтын гарзыг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материалын үнэлгээний хасагдуулгын зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Бараа материалын үнэ цэнэ бууралтын хасагдуулга	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Удирдлагын шийдвэрээр үнэ цэнийн бууралтаар бараа, материалын өртгийг хорогдуулахад:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материалын үнэ цэнэ бууралтын хасагдуулга	149-xx-xx-xxx	xxx.xx		
Бараа, материал /холбогдох данс/	14x-xx-xx-xxx		xxx.xx	

Өмнө нь өртгийг бууруулсан бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ өссөн тохиолдолд өртөг ба өөрчилсөн цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бараа материалын дансны шинэ үнийг тодорхойлж, буцаах тохируулга хийнэ.

2014 оны 12 дугаар сарын 31-нээр барааны өртөг 90,000 төгрөг, байсан бөгөөд тухайн үеийн цэвэр боломжит үнэ цэнэ 80,000 төгрөг гэж үзвэл тухайн өдөр дараах бичилт хийнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материалын үнэ цэнийн бууралтын олз, гарз	..x-xx-xx-xxx	10,000.00		

Бараа материалын үнэ цэнэ бууралтын хасагдуулга	..x-xx-xx-xxx		10,000.00	
---	---------------	--	-----------	--

Үүний дараа тухайн барааны дансны үнэ 80,000 төгрөг болно.2015 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тухайн барааны үнэ цэнэ өсч, шинээр тогтоосон цэвэр боломжит үнэ цэнэ нь 95,000 төгрөг болсон бол тухайн барааг өртөг ба шинээр тогтоосон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлж дараах буцаах бичилтийг хийнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материалын үнэ цэнэ бууралтын хасагдуулга	..x-xx-xx-xxx	10,000.00		
Бараа материалын үнэ цэнийн бууралтын олз, гарз	..x-xx-xx-xxx		10,000.00	

5. Бараа, материалын тооллогын үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах
Тайлант хугацааны эцэст бараа, материалыг тоолсон тооллогын үр дүнг бүртгэхдээ комиссын акт, удирдлагын шийдвэрийг үндэслэн дараах бичилтүүдийг хийнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа, материал /холбогдох данс/	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Тооллогоор илүүдсэн хөрөнгийн орлого	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Тооллогоор бараа, материалын дутагдал гарч, дутагдлыг эд хариуцагчаар төлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн дундаж үнийн аль өндрөөр хийнэ"-т заасны дагуу авлага үүсгэн бүртгэнэ.

а. Дутагдсан бараа, материалын өртгөөр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материалын дутагдал	..x-xx-xx-xxx	xxx.xx		Өртөгөөр нь
Бараа, материал /холбогдох данс/	..x-xx-xx-xxx		xxx.xx	

б Өртөг болон зах зээлийн дундаж үнийн аль өндрөөр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ажилчин албан хаагчаас авах бусад авлага	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Бараа, материал борлуулсаны орлого	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Тооллогоор илэрсэн дутагдал нь эд хариуцагчийн буруугаас биш шалтгаанаар дутагдсан тохиолдолд дутагдлыг шалтгаан, үндэслэлээс хамаарч материаллаг үнэт зүйлсийн дутагдал болон үндсэн хөрөнгийн устгалаас гарах алдагдлыг хүлээн зөвшөөрч:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа материалын дутагдал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Бараа, материал /холбогдох данс/	..x-xx-xx-xxx		xxx.xx	

6. Хуучин сэлбэг, материалын бүртгэл

Үйлдвэрлэлийн тоноглол, автомашин тээврийн хэрэгслийн урсгал болон их засварын явцад сольж тавьсан сэлбэг, материалын оронд гарч байгаа хуучин сэлбэг, материал нь тодорхой үнэ цэнэтэй бөгөөд эргүүлж ашиглах боломжтой тохиолдолд түүнийг бараа, материалд бүртгэнэ.

Хуучин сэлбэг, материалыг чанараас нь хамаарч ерөнхийд нь хоёрдогч түүхий эд болгож худалдах, эсхүл эргүүлж ашиглах боломжтой материал гэж ангилна. Ингэхдээ Өмч хамгаалах байнгын зөвлөлийн тухайн барааны тогтоосон үнэ /цэвэр боломжит үнэ цэнэ/-ээр тухайн бараа материалыг орлогод бүртгэж дараах бичилтүүдийг хийнэ.

а. Хоёрдогч түүхий эд болгож худалдах сэлбэг материалыг цэвэр боломжит үнэ цэнээр нь орлого болгоно:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хоёрдогч түүхий эдийн бараа	..X-XX-XX-XXX	xxx.xx		ӨХБЗ-ийн тогтоосон үнээр
Хоёрдогч түүхий эдийн БМ-р буцаан орлогодсон орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	ӨХБЗ-ийн тогтоосон үнээр

в. Эргүүлж ашиглах боломжтой сэлбэг, материалыг үйлдвэрлэл, үйлчилгээ болон хөрөнгийн урсгал болон их засварт ашиглахад дансны үнээр нь зарлага болгоно;

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар

9.1 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 12 Бараа материал
- Бусад УСНББОУС

1. ХАМРАХ ХҮРЭЭ, ОНЦЛОГ

- 9.59 Энэ УСНББОУС-ын ангилал ба толилуулгын шаардлагуудыг тухайн байгууллагын хүлээн зөвшөөрсөн бүх эргэлтийн бус хөрөнгө ба данснаас хасах бүлгүүдийн хувьд мөрдөнө.
- 9.60 Эргэлтийн бус хөрөнгийг (буюу данснаас хасах бүлгийг) үргэлжлүүлэн ашиглах замаар биш, харин борлуулах ажил гүйлгээгээр түүний дансны үнийг үндсэндээ нөхөх бол байгууллага нь уг хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилна.
- 9.61 Байгууллага нь ашиглалтаас хасах эргэлтийн бус хөрөнгө (буюу данснаас хасах бүлэг)-ийг борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилахгүй.

- 9.62 Улсын секторын байгууллагын хувьд энэхүү ангилалд төсвийн ерөнхийлөн захирагчийн улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн бэлтгэн бусдад шилжүүлэн хуваарилах барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын ажлыг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэнэ.
- 9.63 Байгууллага нь борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгийг түүний дансны үнэ ба борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар хэмжинэ.
- 9.64 Байгууллага нь хуваарилах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгийг түүний дансны үнэ ба хуваарилах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар хэмжинэ.
- 9.65 Байгууллага нь тухайн хөрөнгийн анхны буюу дараагийн аливаа үнэ цэнийн бууралтын хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөөгүй байгаа тэр хэмжээгээр түүний борлуулах зардлыг бодит үнэ цэнэ хүртэл хүлээн зөвшөөрнө.
- 9.66 Байгууллага нь хуваарилах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгийг элэгдүүлэхгүй.
- 9.67 Төсвийн ерөнхийлөн захирагч буюу захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусгах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр санхүүгийн байдлын тайланд тусгана.
- 9.68 Бусад эргэлтийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг дараагийн үеүдэд хуваарилахдаа УСНББОУС 2-ын дагуу зардлаар хүлээн зөвшөөрнө.
- 9.69 Байгууллага нь борлуулах, хуваарилах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгүүдийг санхүүгийн тайланд бусад хөрөнгүүдээс тусдаа толилуулна.

10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө
- УСНББОУС 5 Зээлийн өртөг
- УСНББОУС 21 Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- УСНББОУС 26 Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- Бусад УСНББОУС

1. ХАМРАХ ХҮРЭЭ, ОНЦЛОГ

- 10.1 Үндсэн хөрөнгийн мөн чанар, түүнийг хүлээн зөвшөөрөх, үнэлж хэмжих, анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараах үйл явдал, элэгдэл тооцох, зардлыг капиталжуулах, үндсэн хөрөнгийг дахин үнэлэх зэрэг үндсэн хөрөнгийг бүртгэж, тайлагнах нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлно.
- 10.2 Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ. Үүнд


- 1) Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглах, бусдад түрээслэх эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа;
 - 2) Нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй.
- 10.3 Улсын секторын байгууллагууд нь өөрийн ихэнх хөрөнгийг арилжааны үр өгөөж бий болгох зорилгоор эзэмшдэггүй, харин үйлчилгээ үзүүлэх зорилгоор эзэмшдэг тул ихэвчлэн мөнгө бий болгодоггүй шинжтэй байдаг.
- 10.4 Үндсэн хөрөнгө-гол төлөв "үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж, тоног төхөөрөмж" гэж нэрлэдэг зүйлс бол нэг жилээс дээш хугацаанд эзэмшдэг, ашиглах боловч хэрэглэхэд зориулагдаагүй зүйл (үйлдвэрлэл, үйлчилгээний процесст хэрэглэдэг зүйлсийг бараа материал гэж үзээд тусад нь ангилдаг)-ийг хэлнэ. Ихэнх үндсэн хөрөнгө бодит хэлбэрээр оршдог тул биет хөрөнгө гэдэг.
- Капиталжуулах босго шалгуур
- 10.5 Жижиг эсхүл хямд өртөгтэй тоног төхөөрөмжийн олон зүйл, жишээлбэл, компьютер, оффисын тоног төхөөрөмж зэрэг нь онолын хувьд үндсэн хөрөнгө. Гэхдээ практик дээр үндсэн хөрөнгө гэж бүртгэхдээ өртгийг нь оруулдаг учраас үндсэн хөрөнгө гэж үзэхэд тохиромжгүй. Иймээс Сангийн яамнаас "капиталжуулах босго шалгуур"-ыг ашигласан, уг босго шалгуурт зааснаас доогуур өртөгтэй зүйлсийг үндсэн хөрөнгө гэж үзэхгүй, харин худалдаж авсан жилийнхээ зардалд оруулж тооцдог.
- 10.6 Үндсэн хөрөнгийн анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн зарлагыг үндсэн хөрөнгө дансанд бүртгэхэд дараах үнийн босго шалгуурыг ашиглана. Үүнд:
- 1) Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангасан зөвхөн тавилга эд хогшлийн зүйлсийн хувьд 2 сая төгрөгөөс дээш төгрөгийн зүйлсийг үндсэн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх;
 - 2) Дараа үеийн зарлагын хувьд өөрөөр хэлбэл их засварын зардал нь 30 сая төгрөгөөс дээш үед УСНББОУС 17-ын 24 дүгээр параграфын шаардлага хангасан тохиолдолд хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлнэ.
- 10.7 Хэдийгээр эдгээр бага үнэтэй капиталын зүйлийг үндсэн хөрөнгө гэж үзэхгүй, тиймээс элэгдүүлэхгүй боловч нэг удаа худалдаж аваад мартаж болох зүйлс бас биш юм. Эдгээр зүйлс, ялангуяа харагдахуйц /буюу тодорхойлж болохуйц/, зөөвөрлөх боломжтой зүйлсийг цаашид үргэлжлүүлэн ашиглахад бэлэн байгаа эсэх, хулгайлагдах эсхүлл алдагдахаас сэргийлсэн хяналтын системтэй байдаг эсэхийг байгууллагууд харгалзаж үзэх ёстой.
- 10.8 УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө" стандартын 18 дахь параграфт энэ стандарт нь хүлээн зөвшөөрөлтөнд зориулсан хэмжилтийн нэгжийг, өөрөөр хэлбэл үндсэн хөрөнгийн зүйлсийг юу бүрдүүлэхийг зааж өгөөгүй тул байгууллагын тухайн тодорхой нөхцөл байдалд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хэрэглэхдээ шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно гэж заасан. Иймд дээрх стандартын заалтын дагуу үндсэн хөрөнгийн бүлэглэлд хамааруулан хөрөнгөө ангилах, хяналтын системийн талаарх асуудлыг байгууллагын бодлогодоо тодорхой заасан байна.
- 10.9

2. АНГИЛАЛ

- 10.10 Хүлээн зөвшөөрөх үедээ аж ахуйн нэгж нь хөрөнгийн ангилал болон түүнийг элэгдүүлэх бодлогоо тогтооно. Улсын секторын байгууллага нь нягтлан бодох

бүртгэлийн ялгаатай арга хандлага бүхий гурван бүлэгт хөрөнгийг бүлэглэн авч үзнэ.Үүнд

- 10.11 Бүлэг 1: томоохон, дангаараа материаллаг, илүү төрөлжсөн хөрөнгө, жишээлбэл, аж үйлдвэрийн тоног төхөөрөмж, тусгай зориулалтын барилга байгууламжийн томоохон бүрдэл хэсэг эсхүл Төр-Хувийн хэвшлийн Түншлэлээр дамжуулан олж авсан хөрөнгө бол тус бүрээр нь ялган тодорхойлж, зүйл тус бүрийн нөхцөл, ашиглагдах хугацааг харгалзан элэгдэлийн бодлогыг тодорхойлно. Жишээ нь: дэд бүтцийн хөрөнгө, төр-хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан олж авсан хөрөнгө, цахилгаан дамжуулах шугам, сүлжээ, усан сан гэх мэт
- 10.12 Бүлэг 2: ижил төстэй шинж чанарыг үл харгалзан, илүү том, илүү өртөгтэй хөрөнгийн ангилал (оффисын барилга, агааржуулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл)-д хөрөнгийн ашиглалтын стандарт хугацаа, элэгдлийн аргыг мөрдөхдөө тусдаа хөрөнгө бүрийн үнэ цэнэ буурах, ашиглалтын хугацаа дуусахаас өмнө гарз гарах, ашиглалтаас хасах үед тохируулга хийсэн дансны үнийн хамт бүхэлд нь мөрддөг. Жишээ нь: Барилга байгууламж, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл гэх мэт.
- 10.13 Бүлэг 3: Бага үнэтэй олон зүйлсээс бүрддэг хөрөнгийн ангилал (тавилга, оффисын тоног төхөөрөмж, МТ-ийн тоног төхөөрөмж гэх мэт) бөгөөд тухайн хөрөнгийн ангилал дахь хөрөнгүүдийн ашиглалтын дундаж хугацаанд үндэслэн ашиглалтын стандарт хугацааг тогтоодог. Элэгдэлд, зүйл тус бүрийн дараагийн ашиглалтын хугацаа, нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагагүй - ашиглалтын дундаж хугацаа нь хөрөнгийн ангиллын хувьд бүхэлдээ материаллаг хэмжээнд өөрчлөгдсөн гэдгийг илэрхийлэх нотолгоо бий болсон зөвхөн тийм тохиолдолд элэгдлийн бодлогоо өөрчилнө. Энэ загварыг заримдаа бүлгийн эсхүл нийлмэл элэгдэл гэж нэрлэдэг. Жишээ нь: Тавилга, эд хогшил, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгө гэх мэт
- 10.14 Үндсэн хөрөнгийг байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдал, ижил төстэй шинж чанараар нь бүлэглэж бүртгэнэ.
- 10.15 Улсын секторын байгууллагын хувьд биологийн хөрөнгийг ихэвчлэн үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшдэг. Жишээ нь цагдаагийн байгууллагад ашиглаж буй морь ба нохой, амралт зугаалгын зорилгоор эрхлэн ажиллуулдаг парк, цэцэрлэгт хүрээлэн дэх ургамал ба мод хамаарна. Ийм биологийн хөрөнгийг биологийн хувьсал эсхүл үр шим хүргэлтийн улмаас түүний чанар болон тоо хэмжээнд орсон өөрчлөлтийг хэмжих ба хянан үнэлэх зорилгоор байнга удирдан зохицуулдаггүй учраас тэдгээрийг хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор эзэмшдэггүй гэж дүгнэнэ. Ийм үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийг бүртгэхдээ энэ стандартыг мөрдөнө.



3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

10.16 Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө:

- 1) Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх;
- 2) Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхийг найдвартай хэмжиж чадах.

10.17 Энэхүү хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу байгууллага нь өөрийн бүх үндсэн хөрөнгийн өртөг зардлыг тэдгээрийн гарсан тэрхүү цаг хугацаанд үнэлнэ. Эдгээр өртөг зардал нь үндсэн хөрөнгийн зүйлсийг худалдан авах буюу барьж байгуулахад анх гарсан өртөг зардал болон хөрөнгөнд тодорхой хэсгийг нэмэх, заримыг сольж орлуулах буюу засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлуудаас бүрдэнэ.

Хүлээн зөвшөөрөлтийн үеийн хэмжилт

10.18 Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлийг түүний өртгөөр хэмжинэ.

10.19 Хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд түүний өртгийг тэрхүү олж эзэмшилтийн өдрөөрх бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

10.20 Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг нь дараах зүйлсээс бүрдэнэ:

- 1) худалдааны хөнгөлөлт ба үнийн бууралтыг хассаны дараах худалдан авалтын үнэ (импортын татвар ба буцаан үл олгогдох худалдан авалтын татварууд багтана);
- 2) удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд уг хөрөнгийг авчрахад шууд хамааралтай аливаа өртөг зардал;
- 3) үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын дүн.

10.21 Гадаад валютаар худалдан авсан хөрөнгийн өртгийг тодорхойлохдоо худалдан авалт хийгдсэн өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт хөрвүүлж, хөрөнгийн өртгийг тодорхойлно.

Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт

10.22 Үндсэн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийг дараагийн тайлант үеүүдэд дараах хоёр загварын аль нэгээр үнэлж санхүүгийн тайланд илэрхийлнэ.

10.23 Өртгийн загвар гэдэг нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, үндсэн хөрөнгийн зүйлийг өртгөөс түүний аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэж, тусгана.

10.24 Дахин үнэлгээний загвар -хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Энэ нь дахин үнэлгээний өдрөөрх хөрөнгийн бодит үнэ цэнээс дараа үеийн аливаа хуримтлагдсан элэгдэл ба дараа үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн юм.

10.25 Хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлэх бол тухайн хөрөнгийн харъяалагдаж буй үндсэн хөрөнгийн нийт ангийг дахин үнэлнэ.

- 10.26 Үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлсэн тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг уг дахин үнэлсэн дүн болгож тохируулна. Тухайн хөрөнгийг дахин үнэлгээний өдөр доор дурдсан аргын аль нэгээр өөрчлөн бүртгэнэ.
- 1) Тухайн хөрөнгийн дансны үнийн хувьд хийсэн дахин үнэлгээтэй нийцэх тийм байдлаар нийт дансны үнийг тохируулна.
 - 2) Хуримтлагдсан элэгдлийг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна. Хуримтлагдсан элэгдэлд хийсэн тохируулгын дүн нь хөрөнгийн дансны үнийн өсөлт эсхүл бууралтын нэг хэсэг болно.
- 10.27 Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгүүдийн ангийн дансны үнэ нэмэгдвэл тэрхүү нэмэгдэлтийг дахин үнэлгээний нэмэгдэлд шууд кредитлэнэ. Харин өмнө нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн тухайн хөрөнгүүдийн ангийн дахин үнэлгээний бууралтын буцааж буй хэмжээгээр тэрхүү нэмэгдэлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 10.28 Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгүүдийн ангийн дансны үнэ буурвал тэрхүү бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин тухайн нэг хөрөнгүүдийн ангитай холбоотой дахин үнэлгээний нэмэгдэл дансанд тусгагдсан аливаа кредит үлдэгдлийн хэмжээгээр тэрхүү бууралтыг дахин үнэлгээний нэмэгдэлд шууд дебитлэнэ.
- 10.29 Үндсэн хөрөнгийн нэг анги доторх бие даасан хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдэл ба бууралтыг тэрхүү анги дотор өөр хооронд нь харилцан суутган цэвэр дүнг гаргах боловч өөр ангиудын хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл эсхүл бууралттай харилцан суутган хааж, цэвэр дүнг гаргах ёсгүй.
- 10.30 Үндсэн хөрөнгөтэй холбоотойгоор цэвэр хөрөнгө/өмчид тусгагдсан дахин үнэлгээний нэмэгдэл хамаарах үндсэн хөрөнгийн анги доторх хөрөнгүүдийг актлах буюу данснаас хасах тухайн хөрөнгийг үл зөвшөөрөх үед тэрхүү дахин үнэлгээний нэмэгдлийг бүрэлд нь эсхүл түүний зарим хэсгийг хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлж болно.
- 10.31 Байгууллага уг хөрөнгийг ашиглахын хэрээр дахин үнэлгээний зарим хэсгийг шилжүүлэх ажиллагаа байж болно. Ийм тохиолдолд уг шилжүүлсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүн нь тухайн хөрөнгийн дахин үнэлсэн дансны үнээс тооцсон элэгдэл ба түүний анхны өртгөөс тооцсон элэгдлийн хоорондох зөрүү байдаг.
- 10.32 Үндсэн хөрөнгийг дахин үнэлэх буюу үндсэн хөрөнгийн ашиглах хугацаанд өөрчлөлт оруулах тохиолдолд тооцооны дэлгэрэнгүй баримт нь санхүүгийн хяналт шалгалтын шаардлагыг хангахуйц нарийн хөтлөгдсөн байх ёстой.
- 10.33 Үндсэн хөрөнгийн дараа үеийн зардал буюу засварын ажил
- 10.34 Хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу байгууллага нь үндсэн хөрөнгийн зүйлийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг түүний дансны үнэд хүлээн зөвшөөрөхгүй. Харин эдгээр зардлыг гарсан үед нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 10.35 Зарим үндсэн хөрөнгийн зүйлсийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаатайгаар сольж орлуулах шаардлагатай байдаг. Мөн цөөн давтагдах эсхүл дахин үл давтагдах орлуулалт хийх тийм үндсэн хөрөнгийн зүйлсийг мөн бэлтгэж болно. Энэ үед хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал тухайн өртөг зардал гарсан үед үндсэн хөрөнгийн дансны үнэд оруулан хүлээн зөвшөөрнө. Харин орлуулагдсан хасагдаж буй хэсгийн дансны үнийг үл зөвшөөрөлтийн нөхцлийн дагуу үл хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн элэгдэл

- 10.36 Үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ.
- 10.37 Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг хэрэв өөр нэг хөрөнгийн дансны үнэд тусган оруулаагүй л бол ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 10.38 Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна.
- 10.39 Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт байдлаар тайлагнана.
- 10.40 Ашиглалтанд тавьж олгоогүй, ашиглаж эхлээгүй, агуулахад байгаа хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй.
- 10.41 Хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ.
- 10.42 Хөрөнгийг үл зөвшөөрсөн үед хөрөнгийн элэгдлийг зогсооно. Иймээс хөрөнгийг бүрэн элэгдүүлээгүй л бүл түүнийг ашиглаагүй сул зогссон эсхүл идэвхитэй ашиглалтаас хассан ба данснаас хасах зорилгоор эзэмшиж байгаа тохиолдолд элэгдлийг зогсоохгүй.
- 10.43 Бүлэг 1, 2-рт багтах хөрөнгө, ялангуяа түүхэн өртгөөр нь үнэлсэн хөрөнгө нь элэгдлийн хугацааны эцэст дуусгавар болж ч магадгүй хэдий ч ашиглагдсан хэвээр байх боломжтой. Ийм нөхцөлд, хөрөнгийг нэрлэсэн үнэ (жишээлбэл, 1 төгрөг)-ээр нь дансанд харуулах ёстой. Эдгээр хөрөнгийн оршин байгаа байдал ба нөхцөлд хяналт тавин үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзнэ.
- 10.44 Бүлэг 3-ийн хөрөнгийн хувьд, энд багтсан бүх хөрөнгөд үндэслэн элэгдлийг тооцох бөгөөд хөрөнгө тус бүрийн нөхцөл, ашиглалтын хугацаа нь нягтлан бодох бүртгэлд нөлөөлөхгүй юм. Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгөнд цаашид элэгдэл тооцохгүй ба хөрөнгийг ашиглалтаас хастал анхны өртөг ба хуримтлагдсан элэгдлийг балансад илэрхийлнэ.

Хөрөнгийг зарж борлуулах, ашиглалтаас хасах болон шилжүүлэх

- 10.45 Бүлэг 1, 2-т багтдаг үндсэн хөрөнгийг зарж худалдах, ашиглалтаас хасах эсхүл шилжүүлэх үед гол анхаарах зүйл бол тухайн хөрөнгийг аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлд цаашид тусгахаа зогсоох явдал юм. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн дансны цэвэр үнэ нь тэг байх ёстой бөгөөд хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө гэсэн үг.
- 10.46 Хөрөнгийг зарж худалдах, ашиглалтаас хасах эсхүл шилжүүлэх үйл явцыг нягтлан бодох бүртгэлд хэрхэн тусгах нь тухайн хөрөнгийг шилжүүлэх эсхүл зарж борлуулснаар ямар нэг орлого олох эсэх, энэ дүнг шилжүүлэх эсхүл зарж борлуулах үеийн дансны цэвэр дүнтэй хэрхэн харьцуулахаас хамаарна. Шилжүүлэлт, данснаас хасалтын аливаа олз, гарзыг тухайн тайлант үеийн орлого эсхүл зардлаар хүлээн зөвшөөрөх ёстой.
- 10.47 Бүлэг 3-т багтдаг хөрөнгийн хувьд, шилжүүлэх эсхүл зарж худалдахдаа хүлээн авсан борлуулалтын үнийн дүнгээр тухайн дансны дебет талд (ашиглалтаас хассан хөрөнгийн өртөгтэй заавал ижил байх албагүй); тухайн хөрөнгийн түүхэн өртгөөр дансны кредит талд; харин энэ хоёрын зөрүүгээр уг Бүлгийн хуримтлагдсан элэгдлийн дебетэд бичилт хийнэ. Хөрөнгө зарж борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрөхийг нийлмэл элэгдэлд зөвшөөрдөггүй. Гэхдээ

тухайн хөрөнгө үнэ цэнээ алдаж байвал өртгийг нь бууруулж элэгдэл тооцож болно.

10.48 Ашиглалтын хугацаа гэдэг нь:

- 1) Байгууллагад уг хөрөнгө ашиглагдах боломжтой байхаар хүлээгдэж буй хугацаа; эсхүл
- 2) Байгууллага тухайн хөрөнгөөс олж авахаар хүлээгдэж буй бүтээгдэхүүн буюу түүнтэй ижил төсөөтэй нэгжүүдийн тоо хэмжээ.

10.49 Тухайн байгууллагын хувьд уг хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын нөхцлөөр хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлно. Хөрөнгийн ашиглалтын хугацааны тооцоолол нь ижил төсөөтэй хөрөнгүүдийн талаарх уг байгууллагын туршлагад үндэслэн шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлно.

10.50 Хөрөнгийн ашиглалтын явцад нэмж гарсан зардал нь капиталжуулан үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг нэмэгдүүлэх бол ашиглах хугацаанд өөрчлөлт оруулна. Энэ тохиолдолд үндсэн хөрөнгийн үлдсэн дүнг шинээр тооцсон ашиглалтын хугацаанд элэгдүүлэх ба УСНББОУС 3 “Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа”-ны дагуу бүртгэнэ.

10.51 Байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа нь хөрөнгийн ангилал бүрийн хувьд дараах хугацаатай байж болно.

д.д	Үндсэн хөрөнгийн ангилал	Элэгдүүлэх хугацаа /жилээр/
1	Барилга байгууламж	10-80
2	Үйлдвэрийн тоног төхөөрөмж	8-40
3	Авто машин тээврийн хэрэгсэл	10-15
4	Төмөр зам, тээврийн хэрэгсэл	8-100
5	Тавилга эд хогшил	5-10
6	Компьютер, түүний дагалдах хэрэгсэл	3-5
7		

10.52 Байгууллагын тооллогын комиссын гишүүд тооллого хийх хугацаандаа цаашид ашиглах хугацаа, үлдэх өртгийг УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-д заасны дагуу хянаж үзэх ашиглалтын хугацаанд өөрчлөлт орохоор байвал энэ тухай

- 1) Техникийн зөвлөл, өмч хамгаалах Байнгын зөвлөлд танилцуулж, холбогдох дүгнэлт, тушаал шийдвэрийг гаргуулах;
- 2) Инженер техникийн ажилтан Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хөрөнгийн техник ашиглалтын хувийн хэрэгт ашиглалтын хугацааны өөрчлөлтийг тусгах;
- 3) Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч хөрөнгийн ашиглалтын хугацаанд орсон өөрчлөлтийн дагуу цаашид ашиглах элэгдлийн тооцоог хийх;
- 4) Үнэ цэнийн буурсан талаарх мэдээллийнн эх сурвалж байгаа эсэх.

10.53

Элэгдэл байгуулах арга

10.54 Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах аргад нь шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн арга хамаарна. Байгууллага нь хөрөнгийн элэгдэл тооцох аргыг сонгохдоо ашиглахаар хүлээгдэж буй хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг харгалзана.

- 10.55 Шулуун шугамын аргаар жилийн элэгдлийн зардлыг тодорхойлохдоо үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хэмжээг ашиглалтын хугацаанд хуваана.
- 10.56 Хөрөнгийн хувьд хэрэглэх элэгдлийн аргыг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба тухайн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийг зарцуулан ашиглах хэв загварт мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бол тэрхүү өөрчлөгдсөн хэв загварыг тусгахын тулд элэгдлийн аргыг өөрчлөх хэрэгтэй. Ийм өөрчлөлтийг УСНББОУС 3-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт байдлаар бүртгэж тайлагнана.

4. ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

- 10.57 Үнэ цэнийн бууралт нь хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралтыг элэгдлээр дамжуулан системтэй хүлээн зөвшөөрөх дүнгээс илүү өндрөөр тухайн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж буюу дансны үйлчилгээний чадавхид учрах гарз гэнэ. Үнэ цэнийн бууралтын гарз болзошгүйг илтгэх шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл байгууллага нөхөгдөх дүнг тооцох ёстой.
- 10.58 Байгууллага нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Хэрэв ийм ямар нэг шинж тэмдэг илэрвэл байгууллага нь тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно. Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр нөхөгдөх үйлчилгээний дүнг тодорхойлно.
- 10.59 Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлох боломжгүй үед байгууллага нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг түүний нөхөглөх дүн байдлаар ашиглана.
- 10.60 Байгууллага нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэхдээ мэдээллийн гадаад болон дотоод эх сурвалжийг харгалзан үзнэ. үүнд:
- 1) Тухайн хөрөнгөөр үзүүлэх эрэлт үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлага нь зогссон буюу бараг зогссон;
 - 2) Уг байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд гарч тохиолдолдсон эсхүл ойрын хугацаанд гарч тохиолдохоор байх;
 - 3) Хөрөнгийн биет эвдрэл, гэмтлийн талаарх нотолгоо байх;
 - 4) Хөрөнгийн ашиглалтгүй сул зогсолт, бүтцийн өөрчлөлт хийх;
 - 5) Хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас эсхүл ашиглахад бэлэн болгохоос өмнө уг барилгын ажлыг зогсоох шийдвэр;
 - 6) Хөрөнгийн үйлчилгээний гүйцэтгэл, үр дүн нь хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц муу байх эсхүл муу болно гэдгийг илтгэсэн нотолгоо бий болсон байх.
- 10.61 Байгууллага нь тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийг орлуулан бий болгох одоогийн өртгийг тогтоосноор тэрхүү хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлдог. Хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийг орлуулан бий болгох одоогийн өртгийг элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага, түүнчлэн нөхөн сэргээлтийн өртгийн хандлага ба үйлчилгээний нэгжийн хандлагуудыг ашиглан тодорхойлно.
- 10.62 Хөрөнгийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс бага байх зөвхөн тийм тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл бууруулна. Ийм бууралт нь үнэ цэнийн бууралтын гарз юм.

- 10.63 Дахин үнэлээгүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна.
- 10.64 Үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлтийн дараа, уг хөрөнгийн үлдэх өртгийг хассан, түүний хянан засварласан дансны үнийг тухайн хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилахын тулд хөрөнгийн элэгдлийн зардлыг ирээдүйн тайлант үеүдэд тохируулна.
- 10.65 Үнэ цэнэ буурсан, гарз хүлээсэн эсхүл шилжүүлэн өгсөн үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд гуравдагч талаас авахаар авлага үүссэн үед нөхөн төлбөрийг ашиг, алдагдалд тусгана.

5. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 10.66 Үндсэн хөрөнгийн зүйлийн дансны үнийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө.
- 1) Данснаас хассан; эсхүл
 - 2) Хөрөнгийн ашиглалт буюу данснаас хасалтаар хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөжгүй болсон үед.
- 10.67 Үндсэн хөрөнгийн зүйлийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз буюу гарзыг тухайн зүйлийг үл хүлээн зөвшөөрсөн үед ашиг, алдагдалдаар хүлээн зөвшөөрнө.
- 10.68 Үндсэн хөрөнгийн зүйлийн үл зөвшөөрөлтөөс үүссэн олз буюу гарзыг хэрэв байгаа бол данснаас хасалтын цэвэр орлого ба тухайн хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр тодорхойлно.

6. ТОДРУУЛГА

- 10.69 Үндсэн хөрөнгийг балансад эргэлтийн бус хөрөнгийн хэсэгт, үндсэн хөрөнгийн үндсэн төрлүүдээр ангилж тайлагнана.
- 10.70 Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн анги бүрээр дараах зүйлсийг тодруулна.
- 1) Дансны нийт үнийг тодорхойлоход ашигласан хэмжилтийн суурь;
 - 2) Ашигласан элэгдэл тооцох арга;
 - 3) Ашиглалтын хугацаа буюу элэгдүүлэлтийн хувь;
 - 4) Тайлант үеийн эхэн ба эцэс дэхь дансны нийт үнэ ба хуримтлагдсан элэгдэл (үнэ цэнийн бууралтын хуримтлагдсан гарзыг нэгтгэсэн);
 - 5) Тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тохируулга;
 - 6) Өр төлбөрийн баталгааны улмаас барьцаанд байгаа үндсэн хөрөнгийн эрхийн хязгаарлалтын бодит байдал болон дүн;
 - 7) Барилгын ажлын явцад үндсэн хөрөнгийн дансны үнэнд хүлээн зөвшөөрсөн зарлагын дүн;
 - 8) Үндсэн хөрөнгийн худалдан авалтаас үүссэн гэрээний хэлцлийн дүн;
 - 9) Үнэ цэнэ буурсан, гарз гарсан эсхүл солилцоогоор өгсөн үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг гуравдагч талаас хүлээн авах болсон үед нөхөн төлбөрийн ашиг, алдагдлын хэсэгт тусгасан дүн;
 - 10) Дахин үнэлсэн дүнгээр илэрхийлсэн үндсэн хөрөнгийн хувьд дараах зүйлсийг;
 - 11) Түр сул зогсож байгаа үндсэн хөрөнгийн дансны үнэ;
 - 12) Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн боловч үргэлжлүүлэн ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн дансны нийт үнэ.

7. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

Үндсэн хөрөнгө худалдан авах ажил гүйлгээг бүртгэх журналын бичилтүүд:

1. Худалдан авсан үндсэн хөрөнгийг орлогод авах үед:

1.1 Үндсэн хөрөнгийн орлого болон холбогдох өглөгийг бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		дансны ангиллаар
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

1.2 Төлбөрийг төлөх үед(байгууллага):

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

1.3 Төлбөрийг төлөх үед(хувь хүн):

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	
ХХОАТ-ын өглөг - бусад	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Үндсэн хөрөнгийг хувь хүнээс худалдаж авбал Монгол Улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн дагуу хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийж, баталгаажуулна.

Хувь хүнээс үл хөдлөх хөрөнгө худалдан авсан тохиолдолд татварын хуульд заасан хувь хэмжээгээр хувь хүний орлогын албан татварын дундын суутгал хийж, дараа сарын 10-ны дотор төсөвт төлнө.

Хөрөнгийг ашиглалтанд хүлээн авахдаа улсын комисс болон бусад ажлын хэсгийн акт, техникийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн өртгөөр нь бүртгэнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Холбогдох хөрөнгийн данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2. Хандиваар хүлээн авсан хөрөнгийг орлогод авах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		дансны ангиллаар
Үнэ төлбөргүй орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2.1 Балансаас балансад шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг орлогод авах

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		дансны ангиллаар
Үнэ төлбөргүй орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3. Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдвэл:

а. Уг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг өмнө нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрч байгаагүй бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Өмнө нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн тухайн нэг хөрөнгийн үнэлгээний бууралтын буцааж буй хэмжээгээр тэрхүү нэмэгдэлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		Буцааж буй хэмжээгээр
Дахин үнэлгээний гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx	xxx.xx	

3.2 Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурвал

а. Уг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг өмнө нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрч байгаагүй бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx	xxx.xx	

б. Уг хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдэл дансанд тусгагдсан аливаа кредит үлдэгдлийн хэмжээгээр тэрхүү бууралтыг дахин үнэлгээний орлогод хүлээн зөвшөөрнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3.3 Дахин үнэлгээг тухайн хөрөнгийн нийт дансны үнийн хувьд тохируулах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дахин үнэлгээг тухайн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг хасаж тохируулах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дахин үнэлсэн үнэ ба дахин үнэлэхийн өмнөх үлдэгдэл өртгийн зөрүүгээр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3.3 Дахин үнэлсэн хөрөнгө нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, худалдагдсан, данснаас хассан үед дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч, “дахин үнэлгээний зөрүү”-г хуримтлагдсан ашигт хаана.

Алхам1: Тухайн хөрөнгийг данснаас хасна.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Алхам2: Тухайн хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдэлийг данснаас хасна.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хуримтлагдсан ашиг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3.4 Хөрөнгийг ашиглахын хирээр дахин үнэлгээний нэмэгдлийн зарим хэсгийг шилжүүлэх

Алхам1: Дахин үнэлсэн дүнгээс тооцсон элэгдлийг бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Элэгдлийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		Дахин үнэлсэн дүнгээс тооцсон
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Алхам2: Дахин үнэлсэн дансны үнээс тооцсон элэгдэл ба түүний анхны өртгөөс тооцсон элэгдлийн хоорондох зөрүүг хаана.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		Дахин үнэлсэн дүн болон анхны өртгийн элэгдлийн зардлын зөрүүгээр
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		

4. Үндсэн хөрөнгийн дараа үеийн зардал буюу засварын ажилтай холбоотой журналын бичилтүүд:

4.1 Урсгал засварын бүртгэл

а. Тухайн засварын ажлыг байгууллагын бараа, сэлбэг хэрэгслийг ашиглан гүйцэтгэж байгаа үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урьдчилж төлсөн зардал - Засварын ажил	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бараа материал, сэлбэг хэрэгсэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Тухайн засварын ажлыг байгууллагын ажилчид хийж гүйцэтгэж байгаа үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урьдчилж төлсөн зардал - Засварын ажил	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	
НДШ-н өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в. Тухайн засварын ажлыг гадны гүйцэтгэгч байгууллага хийж гүйцэтгэж байгаа үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урьдчилж төлсөн зардал - Засварын ажил	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Засварын ажил	..X-XX-XX-XXX		xxx.xx	

г. Гадны гүйцэтгэгч байгууллагын өглөгийг төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Засварын ажил	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

д. Хуримтлуулан бүртгэсэн зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урсгал засварын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урьдчилж төлсөн зардал - Засварын ажил	..X-XX-XX-XXX		xxx.xx	

е. Баталгаат хугацаа дуусч баталгаат хугацааны төлбөрийг шилжүүлэх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Баталгаат хугацааны өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx	xxx.xx	

5. Их засварын бүртгэл

Засвар, сайжруулалтын зардал нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байвал хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж, гарсан засварын зардлын дүнгээр капиталжуулна.

а. Их засварын ажлыг гадны гүйцэтгэгч байгууллага хийж гүйцэтгэж байгаа үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Их засвар	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Засварын ажил	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Гадны гүйцэтгэгч байгууллагаас засварын ажилтай холбоотой баталгаат хугацаа, нормчлолын сан болон бусад өглөгийн суутгах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Засварын ажил	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Баталгаат хугацааны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в. Гадны гүйцэтгэгч байгууллагын өглөгийг төлөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг - Засварын ажил	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

г. Баталгаат хугацаа дуусч баталгаат хугацааны төлбөрийг шилжүүлэх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Баталгаат хугацааны өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx	xxx.xx	

5.1 Хуримтлуулан бүртгэсэн зардлыг хөрөнгийн өртөг капиталжуулах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хөрөнгийн данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Их засвар	..X-XX-XX-XXX	xxx.xx	xxx.xx	

6. Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл

Хөрөнгийн элэгдлийг тооцсон хэмжээгээр зардал гэж хүлээн зөвшөөрч бүртгэх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Элэгдлийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx	xxx.xx	

7. Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Үнэ цэнийн бууралтын ажил гүйлгээг бүртгэх журналын бичилт нь:

а. Дахин үнэлгээ хийгдээгүй хөрөнгийн хувьд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үнэ цэнийн бууралтын гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		Нөхөгдөх дүн хүртэл бууруулна.
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx	xxx.xx	

б. Дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгийн хувьд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		Тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүн хүртэл
Үнэ цэнийн бууралтын гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		Дахин үнэлгээний дүнгээс хэтэрсэн хэмжээгээр
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx	xxx.xx	

8. Үндсэн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтийн ажил гүйлгээтэй холбоотой журналын бичилтүүд:

а. Үндсэн хөрөнгийг актлах үед:

Өртгөө бүрэн элэгдүүлсэн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Өртгөө бүрэн элэгдүүлээгүй үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		

Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	
----------------	---------------	--	--------	--

в. Үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах үед сэлбэг, материалыг орлогод авсан бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Сэлбэг хэрэгсэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үнэ төлбөргүй орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

9. Үндсэн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтийн ажил гүйлгээтэй холбоотой журналын бичилтүүд:

а. Үндсэн хөрөнгийг худалдах үед:

Үндсэн хөрөнгийг үлдэгдэл өртгөөс илүү үнээр борлуулбал үндсэн хөрөнгө борлуулсны олзыг хүлээн зөвшөөрнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	..X-XX-XX-XXX		xxx.xx	зөрүү дүнгээр

б. Үндсэн хөрөнгийг үлдэгдэл өртгөөс бага үнээр борлуулбал үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзыг хүлээн зөвшөөрнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	..X-XX-XX-XXX		xxx.xx	зөрүү дүнгээр
Үндсэн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 21 Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- УСНББОУС 31 Биет бус хөрөнгө
- УСНББОУС 26 Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

1. ХАМРАХ ХҮРЭЭ, ОНЦЛОГ, АНГИЛАЛ

- 11.1 Биет бус хөрөнгө гэдэг нь биет шинж чанаргүй, тодорхойлж болох мөнгөн бус зүйлсийн хөрөнгө юм.
- 11.2 Хөрөнгө нь дараах шалгуурын аль нэгийг хангаж байвал түүнийг тодорхойлж болох хөрөнгө гэж үзнэ:
- 1) Салган тусгаарлах, өөрөөр хэлбэл тухайн байгууллагаас тусгаарлах буюу салган хувааж болох ба уг байгууллага тийм санаа зорилготой эсэхээс үл хамааран холбогдох гэрээ, тодорхойлж болох хөрөнгө буюу өр төлбөрөөс бие даасан байдлаар эсхүл хамтад нь борлуулах, шилжүүлэх, лицензээр эзэмшүүлэх, түрээслэх, солилцох боломжтой байх;
 - 2) Гэрээний буюу бусад хуулийн эрхийг шилжүүлж болох буюу уг байгууллагаас эсхүл өөр бусад эрх, үүргээс салган тусгаарлаж болох эсэхээс үл хамааран заавал биелүүлэх хэлцлээс үүсдэг байх.
- 11.3 Биет бус хөрөнгийг байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдал, ижил төстэй шинж чанараар нь бүлэглэж бүртгэнэ. Байгууллагын биет бус хөрөнгийн ангилал нь дараах байдалтай байна.
- 1) Газар эзэмших эрх;
 - 2) Тусгай зөвшөөрөл;
 - 3) Програм хангамж;
 - 4) Бусад биет бус хөрөнгө.
- 11.4 Биет бус ба биет элементүүдийн аль алиныг агуулсан хөрөнгийг биет хөрөнгө эсхүл биет бус хөрөнгө гэж үзэх эсэхийг тодорхойлохдоо, байгууллага нь аль элемент илүү ач холбогдолтой байгааг үнэлэх үүднээс шүүн тунгаалт хийнэ.

2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

- 11.5 Биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхийн тулд тухайн зүйл нь дараах шаардлагыг хангаж байгаа гэдгийг нотлон харуулахыг байгууллагаас шаарддаг.
- 1) Биет бус хөрөнгийн тодорхойлолт;
 - 2) Хүлээн зөвшөөрөлтийн шалгуур.
- 11.6 Анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн өртөг зардал, түүнчлэн биет бус хөрөнгийн нэмэгдүүлэх, түүний зарим хэсгийг сольж орлуулах, хэвийн хадгалахын тулд дараагийн тайлант үед гаргасан өртөг зардлын хувьд энэхүү шаардлагыг мөрдөнө.
- 11.7 Биет бус хөрөнгийг зөвхөн дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө.

- 1) Тухайн хөрөнгөнд хамаарах хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь уг байгууллагад орох нилээд магадлалтай байх;
 - 2) Хөрөнгийн өртөг буюу бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах бол.
- 11.8 Биет бус хөрөнгийг эхлээд өртгөөр нь хүлээн зөвшөөрнө.
- 11.9 Биет бус хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд энэхүү олж эзэмших үеийн анхны өртгийг тухайн өдрөөрх түүний бодит үнэ цэнээр хэмжинэ.
- 11.10 Дотооддоо бий болгосон гүүдвилийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.
- 11.11 Дотооддоо бий болгосон судалгаанаас үүсэх биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй. Судалгааны зарлагыг түүний гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.
- 11.12 Байгууллага нь дараах бүх зүйлсийг батлан харуулж чадах зөвхөн тийм тохиолдолд хөгжүүлэлтээс бий болох биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.
- 1) түүнийг бүрэн дуусгах техникийн үндэслэлтэй байх;
 - 2) биет бус хөрөнгийг бүрэн дуусгах ба түүнийг ашиглах эсхүл борлуулах өөрийн санаа зорилготой байх;
 - 3) ашиглах эсхүл борлуулах өөрийн чадвар боломжтой байх;
 - 4) ирээдүйн магадлалт эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхийг хэрхэн бий болгох;
 - 5) техникийн, санхүүгийн болон бусад нөөцүүд бэлэн боломжтой байх;
 - 6) Хөгжүүлэлтийн явцад уг биет бус хөрөнгөнд хамаарах зарлагыг найдвартай хэмжих.

Зардлын хүлээн зөвшөөрөлт

- 11.13 Доор дурдсанаас бусад тохиолдолд биет бус зүйлсийн хувьд гарсан зарлагыг түүний гарсан үед зардал гэж хүлээн зөвшөөрнө.
- 1) Энэ нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах биет бус хөрөнгийн өртгийн нэг хэсгийг бүрдүүлэх;
 - 2) Тухайн зүйлийг нэгдлээр олж авсан бөгөөд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй байх.
- 11.14 Анх зардлаар хүлээн зөвшөөрсөн биет бус хөрөнгөтэй холбоотой зарлагыг дараагийн үеүдэд биет бус хөрөнгийн өртгийн хэсэг гэж хүлээн зөвшөөрөхгүй.

3. ДАРАА ҮЕИЙН ХЭМЖИЛТ

- 11.15 Байгууллага нь өртгийн загвар, дахин үнэлгээний загварын аль нэгийг нягтлан бодох бүртгэлийн бодлого болгон сонгохоор стандартад заасан байна. Улсын секторын байгууллагын хувьд энэхүү бодлого, журмын дагуу өртгийн загварын ашиглана.
- 11.16 Өртгийн загварын үед анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа биет бус хөрөнгийг өртгөөс түүний аливаа хуримтлагдсан хорогдуулга ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэж, тусгана.
- 11.17 Дахин үнэлгээний загварын үед анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа биет бус хөрөнгийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж тусгана. Энэ нь тухайн хөрөнгийн дахин үнэлгээний өдрөөрх бодит үнэ цэнээс дараа үеийн аливаа хуримтлагдсан хорогдуулга ба дараа үеийн аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг гарзыг хассан дүн байна.

- 11.18 Дахин үнэлгээг хийх давтамж нь уг дахин үнэлж буй биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаардаг. Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллагаар өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай.
- 11.19 Биет бус хөрөнгийг дахин үнэлсэн тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг уг дахин үнэлсэн дүн болгож тохируулна. Тухайн хөрөнгийг дахин үнэлгээний өдөр доор дурдсан аргын аль нэгээр өөрчлөн бүртгэнэ.
- 1) Тухайн хөрөнгийн дансны үнийн хувьд хийсэн дахин үнэлгээтэй нийцэх тийм байдлаар нийт дансны үнийг тохируулна;
 - 2) Хуримтлагдсан хорогдуулгыг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна хасна.
- 11.20 Хэрэв дахин үнэлгээний үр дүнд биет бус хөрөнгийн дансны үнэ нэмэгдвэл тэрхүү нэмэгдэлтийг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд шууд кредитлэнэ. Харин өмнө нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн тухайн нэг хөрөнгийн үнэлгээний бууралтын буцааж буй хэмжээгээр тэрхүү нэмэгдэлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 11.21 Хэрэв дахин үнэлгээний үр дүнд биет бус хөрөнгийн дансны үнэ буурвал тэрхүү бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 11.22 Харин тухайн нэг хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдэл дансанд тусгагдсан аливаа кредит үлдэгдлийн хэмжээгээр тэрхүү бууралтыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрнө. Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн уг бууралт нь дахин үнэлгээний нэмэгдэл нэрээр цэвэр хөрөнгө/өмчид хуримтлагдсан дүнг бууруулна.
- 11.23 Цэвэр хөрөнгө/өмчид тусгагдсан дахин үнэлгээний хуримтлагдсан нэмэгдлийг уг нэмэгдэл хэрэгжсэн үед хуримтлагдсан ашиг дансанд шууд шилжүүлж болно.
- 11.24 Ийм нэмэгдэл нь тухайн хөрөнгийг актлах буюу данснаас хасах үед бүхэлдээ хэрэгжиж болно.
- 11.25 Байгууллага нь уг хөрөнгийг ашиглахын хирээр дахин үнэлгээний нэмэгдлийн зарим хэсгийг шилжүүлж болох юм. Ийм тохиолдолд уг шилжүүлсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүн нь тухайн хөрөнгийн дахин үнэлсэн дансны үнээс тооцсон элэгдэл ба түүний анхны өртгөөс тооцсон элэгдлийн хоорондох зөрүү байдаг. Дахин үнэлгээний нэмэгдлээс хуримтлагдсан ашигт хийгдэх шилжүүлэлтийг ашиг, алдагдлаар дамжуулан тусгахгүй.

4. ХӨРӨНГИЙН ХОРОГДУУЛГА, АШИГЛАЛТЫН ХУГАЦАА

- 11.26 Байгууллага нь биет бус хөрөнгийг ашиглалтын хугацаа тодорхой эсхүл тодорхой бус эсэхийг, хэрэв ашиглалтын хугацаа тодорхой бол түүнийг бүрдүүлж буй хугацааны урт эсхүл бүтээгдэхүүний буюу адилтгах нэгжийн тоог үнэлнэ.
- 11.27 Бүх холбогдох хүчин зүйлсийн шинжилгээнд үндэслэн авч үзэхэд уг хөрөнгөөс тухайн аж ахуйн нэгжид цэвэр мөнгөн орлого бий болгохоор хүлээгдэж буй хугацааны хувьд урьдчилан харж болох хязгаар байхгүй тохиолдолд аж ахуйн нэгж нь биет бус хөрөнгийг тодорхой бус ашиглалтын хугацаатай гэж үзнэ.
- 11.28 Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системтэйгээр хуваарилна. Хорогдуулалтыг хөрөнгийг ашиглах боломжтой болсон хугацаанаас хойш тооцно. Уг хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн өдрөөс эхлэн түүний хорогдуулгыг зогсооно.

- 11.29 Тодорхойгүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Байгууллага тодорхойгүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нөхөгдөх дүнг түүний дансны үнэтэй харьцуулах замаар үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг хянаж үзнэ. Хэрэв уг хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа нь өмнөх тооцооллоос өөр байвал хорогдуулгын хугацааг зохих ёсоор өөрчилнө.
- 11.30 Байгууллагын эзэмшилд байгаа биет бус хөрөнгийг дараах хугацаагаар хорогдуулна.
- | | | |
|-----|----------------------------|----------------------------------|
| Д.д | Биет бус хөрөнгийн ангилал | Хорогдол тооцох хугацаа /жилээр/ |
| 1 | Программ хангамж | 3 ба X |
| 2 | Лиценз | 10 ба X |
- 11.31 Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн үлдэх өртгийг стандартад зааснаас бусад тохиолдолд тэг гэж үзнэ.
- 11.32 Биет бус хөрөнгийн хорогдол байгуулах үндсэн арга нь шулуун шугамын арга байна. Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системтэйгээр хуваарилахын тулд хорогдуулгын янз бүрийн аргуудыг ашиглаж болно.
- 11.33 Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулгын хугацаа ба хорогдуулгын аргыг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзнэ. Хэрэв уг хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа нь өмнөх тооцооллоос өөр байвал хорогдуулгын хугацааг зохих ёсоор өөрчилнө. Ийм өөрчлөлтийг тооцооллын өөрчлөлт байдлаар тайлагнана.
- 11.34 Хорогдуулгыг ихэвчлэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 11.35 Биет бус хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь УСНББОУС 21 эсхүл УСНББОУС 26-гийн аль тохиромтойг мөрдөнө.

5. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 11.36 Биет бус хөрөнгийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө.
- 1) Данснаас хасахад;
 - 2) Хөрөнгийн ашиглалт буюу данснаас хасалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж олохооргүй болсон үед.
- 11.37 Биет бус хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз буюу гарзыг хэрэв байгаа бол данснаас хасалтын цэвэр орлого ба тухайн хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр тодорхойлно. Олз, гарзыг тухайн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрсөн үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

6. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 11.38 Байгууллага нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө ба бусад биет бус хөрөнгө гэдгээр ангилж, биет бус хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна.
- 1) Ашиглалтын хугацаа нь тодорхой эсхүл тодорхойгүй эсэх болон, хэрэв тодорхой ашиглалтын хугацаатай бол ашиглалтын хугацаа эсхүл хорогдуулалтын хувь;
 - 2) Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгөнд ашигласан хорогдуулалтын аргууд;

- 3) Дансны нийт үнэ ба тайлант хугацааны эхэн ба эцэс дэхь хуримтлагдсан хорогдуулга;
- 4) Биет бус хөрөнгийн хорогдуулгыг тусгасан, санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйл;
- 5) Тайлант хугацааны эхэн ба эцэст хийгдсэн дансны үнийн тохируулга (үнэ цэнийн бууралтын гарз, данснаас хасалт, тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн хорогдуулалтын дүн гэх мэт).

11.39 Биет бус хөрөнгийг тодорхойгүй ашиглалтын хугацаатай гэж үнэлсэн бол тухайн хөрөнгийн дансны үнэ болон тодорхойгүй ашиглалтын хугацаатай гэж тодорхойлосныг дэмжих шалтгаан зэргийг тодруулна.

7. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Биет бус хөрөнгийг бий болгох, худалдан авах.

Биет бус хөрөнгийг худалдан авсан буюу бий болгосон өртгөөр нь бүртгэх ба өртөгт ажил гүйцэтгэгчид төлсөн худалдан авсан үнэ, эсхүл түүнийг бий болгохтой холбогдсон бүх зардал орно.

а. Биет бус хөрөнгийн орлого болон холбогдох өглөгийг бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Биет бус хөрөнгө	..x-xx-xx-xxx	xxx.xx		дансны ангиллаар
Өглөгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		

2. Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний ажил гүйлгээ

2.1 Дахин үнэлгээний үр дүнд биет бус хөрөнгийн дансны үнэ нэмэгдвэл

а. Уг биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг өмнө нь хүлээн зөвшөөрч байгаагүй бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Биет бус хөрөнгө	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Дахин үнэлгээний нэмэгдэл	..x-xx-xx-xxx		xxx.xx	

б. Дахин үнэлгээг тухайн биет бус хөрөнгийн нийт дансны үнийн хувьд тохируулах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Биет бус хөрөнгө	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Хуримтлагдсан хорогдуулга	..x-xx-xx-xxx		xxx.xx	
Дахин үнэлгээний нэмэгдэл	..x-xx-xx-xxx		xxx.xx	

в. Өмнө нь дахин үнэлгээний гарзаар хүлээн зөвшөөрсөн тухайн нэг биет бус хөрөнгийн үнэлгээний нэмэгдлийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Биет бус хөрөнгө	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Дахин үнэлгээний олз	..x-xx-xx-xxx		xxx.xx	Буцааж буй хэмжээгээр

2.2 Дахин үнэлгээний үр дүнд биет бус хөрөнгийн дансны үнэ буурвал

а. Уг биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг өмнө нь хүлээн зөвшөөрч байгаагүй бол.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Биет бус хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Уг биет бус хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдэл дансанд тусгагдсан аливаа кредит үлдэгдлийн хэмжээгээр тэрхүү бууралтыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний гарз	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Биет бус хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в. Дахин үнэлгээг тухайн биет бус хөрөнгийн хорогдуулгыг хасаж тохируулах

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан хорогдуулга	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Биет бус хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Дахин үнэлсэн үнэ ба дахин үнэлэхийн өмнөх үлдэгдэл өртгийн зөрүүгээр;

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Биет бус хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2.3 Дахин үнэлсэн биет бус хөрөнгө нь анхны өртгөө бүрэн нөхсөн, борлуулсан, данснаас хассан үед дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч, “дахин үнэлгээний зөрүү”-г хуримтлагдсан ашигт хаана.

Алхам1: Тухайн биет бус хөрөнгийг данснаас хасна.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан хорогдуулга	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Биет бус хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Алхам2: Тухайн биет бус хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийг данснаас хасна.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний нэмэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хуримтлагдсан ашиг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3. Биет бус хөрөнгийн анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн зардал.

а. Биет бус хөрөнгөтэй холбогдож гарсан зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үйл ажиллагааны зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. Биет бус хөрөнгийн хорогдуулалт.

а. Бусад биет бус хөрөнгийн хорогдлыг тооцсон хэмжээгээр зардал гэж хүлээн зөвшөөрч бүртгэх

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хорогдуулгын зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Хуримтлагдсан хорогдуулга	..x-xx-xx-xxx		xxx.xx	

5. Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

а. Дахин үнэлгээ хийгдээгүй биет бус хөрөнгийн хувьд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үнэ цэнийн бууралтын гарз	..x-xx-xx-xxx	xxx.xx		Нөхөгдөх дүн хүртэл бууруулна.
Биет бус хөрөнгө	..x-xx-xx-xxx		xxx.xx	

б. Дахин үнэлгээ хийгдсэн биет бус хөрөнгийн хувьд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дахин үнэлгээний нэмэгдэл	..x-xx-xx-xxx	xxx.xx		Тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүн хүртэл
Үнэ цэнийн бууралтын гарз	..x-xx-xx-xxx	xxx.xx		Дахин үнэлгээний дүнгээс хэтэрсэн хэмжээгээр
Биет бус хөрөнгө	..x-xx-xx-xxx		xxx.xx	

6. Биет бус хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтийн ажил гүйлгээтэй холбоотой журналын бичилтүүд:

Биет бус хөрөнгийг актлах үед:

Бүрэн хорогдсон биет бус хөрөнгийг акталж данснаас хассан бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан хорогдол	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Биет бус хөрөнгө	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Бүрэн хорогдоогүй биет бус хөрөнгийг акталж данснаас хассан бол:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан хорогдол	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Биет бус хөрөнгө	..x-xx-xx-xxx		xxx.xx	

12. ӨР ТӨЛБӨР, БОЛЗОШГҮЙ, ӨР ТӨЛБӨР, НӨӨЦ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- Бусад УСНББОУС

1. ХАМРАХ ХҮРЭЭ

- 12.1 Өр төлбөр гэдэг нь байгууллагын өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн уг байгууллагын одоогийн үүрэг бөгөөд түүнийг барагдуулсанаар эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөц тухайн байгууллагаас гарахаар хүлээгдэж байдаг.
- 12.2 Өр төлбөр, болзошгүй зүйлс, үүрэг хариуцлагыг доорх байдлаар ялгаж ойлгоно.
- 12.3 Болзошгүй өр төлбөр нь:
- 1) өнгөрсөн үйл явдлын үр дүнд гарах боломжтой үүрэг хариуцлага бөгөөд түүний орших байдал нь байгууллагын бүрэн хяналтанд ороогүй бөгөөд зөвхөн ирээдүйд нэг буюу хэд хэдэн үйл явдлын тохиолдол, эс тохиолдлоор батлагдах;
 - 2) эсхүл өнгөрсөн үйл явдлын үр дүнд бий болдог одоогийн үүрэг хариуцлага боловч дараах шалтгаанаар хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа;
 - 3) уг үүрэг хариуцлагыг барагдуулахын тулд эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийг гадагш шилжүүлэх шаардлагатай гэдэг нь магадлалгүй;
 - 4) төлөх төлбөрийн дүнг найдвартай хэмжих боломжгүй.
- 12.4 Үүрэг хариуцлага нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд бий болдог ирээдүйн өр төлбөр бөгөөд түүний орших байдал нь зөвхөн байгууллагын хяналтанд байгаа ирээдүйн нэг буюу хэд хэдэн үйл явдлын тохиолдлоор батлагдах юм: Үүний барагдуулалтын үр дүнд эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөц буурна.
- 12.5 Өр төлбөрийн хувьд дараах хэмжилтийн сууриудыг тодорхойлно.
- 1) Түүхэн өртөг
 - 2) Гүйцэтгэлийн өртөг
 - 3) Зах зээлийн үнэ цэнэ
 - 4) Чөлөөлөгдсөн өртөг
 - 5) Үүрэг хариуцсаны үнэ

12.6

1. АНГИЛАЛ

- 12.7 Өр төлбөрийг богино ба урт хугацаат гэж ангилж, тайлагнана.
- 12.8 Байгууллага нь өр төлбөрийг өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааруулан ангилан бүртгэж болно.
- 12.9 Богино хугацаат өр төлбөрийг тэдгээрийн мөн чанар буюу төлөгдөх хугацааны дарааллаар доорхи дэд ангиллаар ангилна. Үүнд:
- 1) Татвар, хураамжийн өр төлбөр;

- 2) Цалин, НДШ-ийн өр төлбөр;
 - 3) Богино хугацаат зээл өр төлбөр;
 - 4) Байгууллагад төлөх өр төлбөр;
 - 5) Хувь хүмүүст төлөх өр төлбөр;
 - 6) Урьдчилж орсон орлого;
 - 7) Бусад өр төлбөр.
- 12.10 Урт хугацаат өр төлбөр нь доорхи ангилалтай байна.
- 1) Урт хугацаат зээлийн өр төлбөр;
 - 2) Урт хугацаат бондын өр төлбөр;
 - 3) Урт хугацаат нөөц, өр төлбөр;
 - 4) Бусад урт хугацаат өр төлбөр.
- 12.11 Дансны өглөг нь бараа, үйлчилгээ худалдан авах, үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор бэлтгэн нийлүүлэгчидтэй үүссэн тооцоог бүртгэхэд хэрэглэгдэнэ. Гадаад, дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс гадна хувь хүмүүс, өөрийн ажиллагчидтай холбогдсон тооцоог тусад нь харуулах, мэдээллийн хэрэгцээг харгалзан өр төлбөрийн дансыг ангилна.
- 12.12 Бүх төрлийн татварын өглөгийг татвар, хураамжийн төрлөөр нь бүртгэх боломжтой байдлаар дансыг ангилна.

2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

- 12.13 Өр төлбөрийг найдвартай хэмжиж болохуйц бөгөөд бэлтгэн нийлүүлэгчийн хүчин төгөлдөр нэхэмжлэх, зээлийн гэрээ, төлбөрийн хуваарь, татвар, шимтгэлийн тайлан зэрэг хүчин төгөлдөр анхан шатны баримтанд үндэслэн ажил гүйлгээ хэрэгжсэн өдрөөр буюу аккрузал сууриар хүлээн зөвшөөрнө.
- 12.14 Өр төлбөрийг төлөх мөнгөний нэрлэсэн үнээр анх бүртгэлд тусгана. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөгийг тухайн өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэнэ.
- 12.15 Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш өр төлбөрийг цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж, тайлагнана. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөрт ханшийн тэгшитгэл хийж ханшийн зөрүүгээс үүссэн олз, гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.
- 12.16 Өөрөөр хэлбэл өр төлбөрийг нэхэмжлэх буюу гэрээнд заагдсан үнийн дүнгээс аливаа хөнгөлөлт, хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр бүртгэлд тусгана.
- 12.17 Урьдчилж төлөгдсөн орлого-байгууллагаас худалдан авагчид бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлээгүй боловч тэднээс хөрөнгө оруулалтын бус зориулалтаар байгууллагад төлсөн мөнгө бөгөөд ирээдүйд орлогоор хүлээн зөвшөөрөгдөх урьдчилж орсон төлбөр хэлбэртэй байна.
- 12.18 Энэ нь мөнгийг хүлээн авсан боловч тайлант хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлээгүй учраас орлого гэж бүртгэх боломжгүй, өөрөөр хэлбэл ирээдүйд ажил үйлчилгээ ба бараа борлуулалтыг шаардах өр төлбөр юм.
- 12.19 Бусад богино хугацаат өр төлбөр. Дээрхи ангилалд ороогүй, 1 жилийн хугацаанд төлөгдөх бусад богино хугацаат өр төлбөрийг энэ ангиллын дансаар бүртгэнэ.
- 12.20 Урт хугацаат зээлийн өр төлбөр-банк санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл, түүнд тооцсон хүүгийн өр төлбөрийг энэ ангиллаар бүртгэнэ.
- 12.21 Урт хугацаат бондын өр төлбөр-байгууллага урт хугацаат бонд, өрийн бичиг гаргаж, нийтэд худалдсанаар үүссэн өр төлбөрийг энэ ангиллын дансаар

бүртгэнэ. Урт хугацаат бонд буюу өрийн бичгийг дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээр бүртгэдэг. Нэрлэсэн үнэ ба дискаунтчилсан үнэ цэнийн хоорондын зөрүүгээр Урт хугацаат өрийн бичгийн хасагдуулга дансанд бүртгэнэ.

3. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 12.22 Өр төлбөрийг зүйл буюу бүлэг зүйлсийн мөн чанараар нь ангилж, өр төлбөрийг барагдуулах дарааллаар нь санхүүгийн байдлын тайланд толилуулна.
- 12.23 Өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжихэд баримталсан бүртгэлийн бодлогыг тодруулна.
- 12.24 Тайлант хугацааны эцэс дэх өр төлбөрийн үлдэгдлийг дансдын бүлгээр өмнөх тайлант хугацааны үлдэгдэлтэй харьцуулсан байдлаар харуулна.
- 12.25 Болзошгүй өр төлбөрийн бүлэг бүрээр тодруулга хийх ба түүнд тэдгээрийн мөн чанарын тухай товч танилцуулга, боломжтой бол, санхүүгийн үр ашгийн тооцоо, холбогдох тодорхойгүй байдлын үзүүлэлт болон байж болох ямар нэгэн нөхөн төлбөр зэрэг мэдээллийг тусгана.
- 12.26 Богино хугацаат өр төлбөрийг санхүүгийн тайланд балансын эх үүсвэр талд эхний зүйл, урт хугацаат өр төлбөрийг мөн талд хоёр дахь зүйл болгон тайлагнана. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөрийг Монголбанкнаас зарласан хаалтын албан ханшаар төгрөгт шилжүүлж, санхүүгийн тайланд тусгана.
- 12.27 Өр төлбөрийг хугацаа, төрөл, зээлдүүлэгчээр тодруулга хийж харуулна. Хүүтэй буюу хүүгүй зээлийг тусад нь тайлагнах ба хүүний түвшин, төлөгдөх хугацаа зэргийг тодруулгад тусгана. Өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, үнэлэхэд баримталсан бүртгэлийн бодлогыг тодруулна.

4. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Дансны өглөгийг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бараа, материал, Зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

а. Өглөгийг төлөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2. Цалин, НДШ, ХХОАТ-ын өглөг

а. Нийт олгохоор тооцсон цалингийн дүнгээр дараах бичилт хийнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Нийт олгохоор тооцсон цалингаас ажилтны төлөх нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ыг суутгаж, дараах бичилт хийнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
НДШ өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	
ХХОАТ-ын өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в. Мөн ажил олгогчоос төлөх НДШ-н өглөгийн дүнгээр дараах бичилтийг хийнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
НДШ-н зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
	..X-XX-XX-XXX			
Хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
НДШ-ийн өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

г. Мөн цалингаас Шүүхийн шийдвэр болон бусад журмаар суутгал хийвэл цалингийн өглөг дансыг дебитлэнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Өр төлбөрийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

д. Бүх төрлийн суутгалыг хийсний дараа гарт олгох цалинг төлөх үед дараах бичилт хийнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Цалингийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3. Бусад татварын өглөг

а. Мөнгөөр төлөх хүртэл хуримтлуулж бүртгэсэн татвар, хураамжийг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үйл ажиллагааны зардал /татвар, хураамжийн ангиллаар/	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Татвар, хураамжийн өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Татвар, хураамжийг мөнгөөр төлөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Татвар, хураамжийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Харилцах данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. Урьдчилж төлөгдсөн орлого

а. Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ урьдчилж төлөгдөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урьдчилж төлөгдсөн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж, орлогыг хүлээн зөвшөөрөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
------------	------------	-------	--------	---------

Урьдчилж төлөгдсөн орлого	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Үйл ажиллагааны орлого	..x-xx-xx-xxx		xxx.xx	
эсхүл Үйл ажиллагааны бус орлого	..x-xx-xx-xxx		xxx.xx	

5. Бусад богино хугацаат өр төлбөр

а. Бусад богино хугацаат өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зардлын холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Бусад богино хугацаат өр төлбөр	..x-xx-xx-xxx		xxx.xx	

б. Өр төлбөрийг мөнгөөр төлөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бусад богино хугацаат өр төлбөр	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxx.xx	

13. САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

Холбогдох Улсын секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- УСНББОУС 30 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга

1. АНГИЛАЛ

- 13.1 Санхүүгийн хэрэглүүр гэдэг нь нэг аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн хөрөнгө болон нөгөө аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн өр төлбөр эсхүл өмчийн хэрэглүүр хоёрыг аль алиныг үүсгэх гэрээ юм.
- 13.2 Энэ нь өөр байгууллагад мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах, эсхүл санхүүгийн хөрөнгө эсхүл санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагад тааламжгүй байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох, эсхүл тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох.
- 13.3 Мөнгөн зүйлсийн санхүүгийн хэрэглүүр гэдэг нь тогтмол буюу тодорхой хэмжээний мөнгийг хүлээн авах эсхүл төлөх санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр юм.
- 13.4 Санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг аль алиныг агуулах өргөн утгатай бөгөөд анхдагч ба үүсмэл хэрэглүүр гэж хоёр ангилагддаг.
- 13.5 Анхдагч санхүүгийн хэрэглүүрт мөнгө болон авлага, өр төлбөр, өмчийн үнэт цаас хамаарна. Харин үүсмэл санхүүгийн хэрэглүүрт опцион, фьючерс, форвардс, хүүний түвшний своп, валютын своп зэрэг хамаарна.
- 13.6 Харин бараа, үйлчилгээ нийлүүлэх урьдчилж орсон орлого, баталгаат өглөг нь санхүүгийн өр төлбөрт хамаарахгүй.

Ангилал

- 1) Санхүүгийн хэрэглүүрийн дөрвөн ангиллын тодорхойлолт;
- 2) Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр;
- 3) Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
- 4) Зээл ба авлага;
- 5) Борлуулах боломжтой хөрөнгө / үүсмэл бус санхүүгийн хөрөнгө/.

13.7

2. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 13.8 Байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон зөвхөн тийм тохиолдолд уг байгууллага нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа хүлээн зөвшөөрнө.
- 13.9 Гэхдээ ирээдүйн төлөвлөсөн ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй. Тухайлбал, бараа, үйлчилгээг худалдан авах буюу борлуулах тохиолдолд ажил гүйлгээ буюу үйл явдал тохиолдсон үед хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

- 13.10 Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь өгсөн буюу хүлээн авсан зүйлсийн бодит үнэ цэнэ буюу өртгөөр хэмжинэ. Бүх санхүүгийн хөрөнгө буюу өр төлбөрийг хэмжихдээ түүнийг олж бэлтгэхтэй холбоотой бүх зардлыг оруулна.
- 13.11 Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бүх санхүүгийн өр төлбөрийг тэдгээрийн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.
- 13.12 Богино хугацааны арилжааны зорилготой, тогтмол дуусгавар хугацаатай эсхүл уг байгууллагын өөрийн үүсгэсэн зээл, авлагыг бодит үнэ цэнээр хэмжсэнээс үүсэх олз буюу гарзыг тайлант хугацааны цэвэр ашиг, алдагдлын тооцоололд оруулна. Харин дээрх гурваас бусад санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжсэнээс үүссэн олз буюу гарзыг өмчийн өөрчлөлтийн тайланд тусгана.
- 13.13 Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь түүний бодит үнэ цэнээр хэмжинэ, харин ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр байх тохиолдолд тэдгээрийн олж эзэмшилт буюу гаргалтанд шууд хамаарах ажил гүйлгээний зардлыг тэрхүү дүн дээр нэмэх эсхүл хасах байдлаар хэмжинэ.

3. ДАРААГИЙН ТАЙЛАНТ ҮЕИЙН ХЭМЖИЛТ

- 13.14 Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь доор дурдсанаас бусад, бүх санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.
- 1) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр;
 - 2) Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангадаггүй тохиолдолд эсхүл цаашдын оролцооны хандлагыг хэрэглэх үед үүсдэг санхүүгийн өр төлбөр;
 - 3) Санхүүгийн баталгааны гэрээ;
 - 4) Зах зээлийн хүүний түвшнээс бага хүүтэйгээр зээл олгох баталгаа.
- 13.15 Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бүх санхүүгийн өр төлбөрийг тэдгээрийн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.
- 13.16 Богино хугацааны арилжааны зорилготой, тогтмол дуусгавар хугацаатай эсхүл уг байгууллагын өөрийн үүсгэсэн зээл, авлагыг бодит үнэ цэнээр хэмжсэнээс үүсэх олз буюу гарзыг тайлант хугацааны цэвэр ашиг, алдагдлын тооцоололд оруулна.

4. ҮЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 13.17 Байгууллага нь зөвхөн дараах тохиодолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.
- 1) тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан буюу хүчингүй болсон; эсхүл
 - 2) тухайн санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан.
- 13.18 Байгууллага нь санхүүгийн хөрөнгөнд тавих хяналтаа шилжүүлж, өөр санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөртэй болсон тохиолдолд уг шинэ хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч, дансны үнэ ба бодит үнэ цэнийн зөрүүгээр олз, гарзыг хүлээн зөвшөөрнө.

- 13.19 Байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг зөвхөн дуусгавар болгосон үед, өөрөөр хэлбэл гэрээнд тусгайлан заасан үүргийг биелүүлсэн эсхүл чөлөөлсөн, цуцалсан, хугацаа дууссан үед өөрийн санхүүгийн байдлын тайлангаас хасна.
- 13.20 Барагдуулсан буюу бусад талд шилжүүлсэн санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн төлбөрийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Зээлдүүлэгч нь үүргээс чөлөөлсөн эсхүл арилжааны бус ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар уг үүргийг гуравдагч тал хариуцсан тохиолдолд байгууллага нь УСНББОУС 23-ыг дагаж мөрдөнө.

5. ТОЛИЛУУГА, ТОДРУУЛГА

- 13.21 Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн талаар дараах тодруулгыг хийнэ. Үүнд;
- 1) дүн, хугацаа, ирээдүйн мөнгөн гүйлгээнд нөлөөлж болох гол нөхцлүүд;
 - 2) хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, хүлээн зөвшөөрөх шалгуур ба хэмжилтийн суурь;
 - 3) дуусгавар болох хугацаа;
 - 4) хүүний түвшин;
 - 5) хөрвүүлэх нөхцөл;
 - 6) ирээдүйн төлбөрийн хуваарь;
 - 7) барьцаа;
 - 8) гадаад валютаар илэрхийлэгдсэн тохиолдолд тухайн валют, ханш;
 - 9) үнэ цэнийн бууралт, хасагдуулга;
 - 10) санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн эрсдэл, эрсдлийн талаар баримталж буй бодлого;
 - 11) бодит үнэ цэнээр бүртгэсэн тохиолдолд түүнийг тооцоолохдоо хэрэглэсэн арга, төсөөлөл;
 - 12) хүлээн зөвшөөрсөн олз буюу гарз.

13.22

7. САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний мэдээллийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, зээлийн ашиглалт гарснаар авлагад дараах байдлаар бүртгэнэ.

а) Олон улсын байгууллага, түнш орноос гадаад зээл авсан:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2. Хэрэв дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлийн дагуу уг зээлийг гадаад дахь зээлдүүлэгчийн харилцах данснаас дотоодын эцсийн зээлдэгчид эсхүл тэдний бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчид шууд төлбөр хийж, харин Засгийн газраар дамжуулан зээлдүүлсэн нөхцөлийг гэрээгээр хүлээсэн бол гадаадаас авч ашигласан зээлийн хэмжээгээр түүнийг нотолсон анхан шатны баримтыг үндэслэн дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад зээлдүүлсэн гэж хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зээлийн авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

а. Банк буюу бусад байгууллагаас богино хугацаат зээл авсан тохиолдолд дараах бичилт хийнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Богино хугацаат зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Зээлийг буцаан төлөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Богино хугацаат зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в. Зээлийн хүүний өглөгийг хуримтлуулан бүртгэх үед зээлийн зориулалтаас хамааран зардлын эсхүл холбогдох хөрөнгийн дансанд дараах байдлаар тусгана:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зээлийн хүүгийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
эсхүл/хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Зээлийн хүүний өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Зээлийн хүүний өглөгийг бүртгэх холбогдох дансад нь зээлийн зориулалт, ашиглалтаас хамаарна. Тухайлбал, зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар авсан бол үйлдвэрлэлийн өртөг, зардалд оруулж, дуусаагүй үйлдвэрлэл дансаар бүртгэх буюу дэлгэрэнгүй орлогын тайланд тусад нь ангиллаар бүртгэнэ.

Харин зээлийг үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, дуусаагүй барилга зэрэг эргэлтийн бус хөрөнгийг барьж байгуулах, бүтээн бий болгох зорилгоор авсан бол хүүний зардлыг капиталжуулах бөгөөд холбогдох данс тэдгээр балансын дансууд байна.

Зээлийн хүүг төлөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зээлийн хүүний өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Өмнө хуримтлуулж бүртгээгүй хүүгийн өглөгийг төлөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Зээлийн хүүгийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
эсхүл Дуусаагүй үйлдвэрлэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
эсхүл Хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

3. Урт хугацаат зээлийн өр төлбөр

а. Банк, санхүүгийн байгууллагаас урт хугацаат зээл авахад:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урт хугацаат зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Урт хугацаат зээлийг богино хугацаат өр төлбөрт шилжүүлэн бүртгэх ба дараах бичилт хийнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урт хугацаат зээлийн төлбөр	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урт хугацаат зээлийн богино хугацаанд ногдох хэсэг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в. Зээлийг буцаан төлөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урт хугацаат зээлийн богино хугацаанд ногдох хэсэг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		xxx.xx	

4. Урт хугацаат бондын өр төлбөр

а. Урт хугацаат өрийн бичгийг худалдаж, мөнгө орж ирэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урт хугацаат бондын өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

Урт хугацаат бонд буюу өрийн бичгийг дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээр бүртгэдэг. Нэрлэсэн үнэ ба дискаунтчилсан үнэ цэнийн хоорондын зөрүүгээр Урт хугацаат өрийн бичгийн хасагдуулга дансанд бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урт хугацаат бондын үнэлгээний хасагдуулга	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урт хугацаат бондын өр төлбөр	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Урт хугацаат бондын богино хугацаат өр төлбөрт шилжүүлэн бүртгэх ба дараах бичилт хийнэ:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урт хугацаат бондын өр төлбөр	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урт хугацаат бондын богино хугацаанд төлөгдөх хэсэг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в. Бондын хугацаа дуусч мөнгийг буцаан төлөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урт хугацаат бондын богино хугацаанд төлөгдөх хэсэг	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxx.xx	

14. ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэгсэл: Толилуулга
- УСНББОУС 29 Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

1. ХАМРАХ ХҮРЭЭ

- 14.1 Цэвэр хөрөнгө/өмч буюу капитал нь байгууллагын нийт хөрөнгийн дүнгээс бүх өр төлбөрийн дүнг хассаны дараа үлдэх хувь оролцоо болно.
- 14.2 Өмчлөлийн хувь оролцоо нь тухайн байгууллагыг үүсгэн байгуулах үеийн нөөцийн анхны хувь оруулалт эсхүл нөөцийн дараагийн тайлант үеийн хувь оруулалт, байгууллагын бүтцийн өөрчлөлтийн үеийн хувь оруулалт хэлбэртэй байж болно.
- 14.3 Өмчлөлийн хуваарилалт нь хөрөнгө оруулалтын өгөөж, хөрөнгө оруулалтын бүрэн буюу хэсэгчилсэн буцаалт, эсхүл тухайн байгууллагыг татан буулгах буюу бүтцийн өөрчлөлт хийх тохиолдолд аливаа үлдэх нөөцийн буцаалт хэлбэртэй байж болно.

2. АНГИЛАЛ

- 14.4 Байгууллагын цэвэр хөрөнгө/өмч нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:
- 1) Хувь нийлүүлсэн капитал /Засгийн газрын оруулсан капитал/
 - 2) Бусад нөөц сан /Дахин үнэлгээний нэмэгдэл/
 - 3) Хөрвүүлэлтийн нөөц
 - 4) Хуримлагдсан ашиг алдагдал
 - 5) Хяналтын бус хувь оролцоо

14.5

3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

- 14.6 Эздийн оруулсан хувь оролцоо ба тэдэнд олгосон хуваарилалт нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх хоёр байгууллагын хоорондох шилжүүлгийг агуулсан байдаг. Эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эздээс өөрийн хяналтанд буй байгууллагуудад оруулсан хувь оролцоо нь цэвэр хөрөнгө/өмчийн эрх хэлбэрээр тухайн байгууллага дахь түүний үлдэх хувь оролцоог илт нэмэгдүүлэх зөвхөн тийм тохиолдолд уг хувь оролцоог цэвэр хөрөнгө/өмчийн шууд тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө.
- 14.7 Бусад УСНББОУС нь дахин үнэлгээний нэмэгдэл ба бууралт, гадаад валютын тодорхой ханшийн зөрүү гэх мэт зүйлсийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт байдлаар шууд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.
- 14.8 Дахин үнэлгээний нэмэгдэл. Энэ хэсэгт хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнд үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнийн өсөлтийг хуримтлуулан бүртгэнэ.

- 14.9 Дахин үнэлгээгээр хөрөнгийн үлдэгдэл өртөг буурсан бол дахин үнэлгээний бууралтыг өмчид бүртгэхгүй, тайлант үеийн алдагдал болгон орлого үр дүнгийн тайланд харуулна.
- 14.10 Өмнө үнэлсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр үлдэгдэл өртөг буурсан бол дахин үнэлгээний бууралтыг өмнө бүртгэсэн дахин үнэлгээний нэмэгдэл (хэрэв байгаа бол)-ээс хорогдуулна.
- 14.11 Дахин үнэлэгдсэн хөрөнгийг данснаас хасах, устгах, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үед дахин үнэлгээний нэмэгдсэн хэмжээ бодитой болсон гэж үзэж дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.
- 14.12 Хөрөнгийг данснаас хасах үед тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн хуримтлагдсан дүнг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.
- 14.13 Валютын ханшийн хөрвүүлэлтийн нөөц - байгууллагын гадаад үйл ажиллагааг хөрвүүлэх болон аж ахуйн нэгжийн бүртгэлийн валют толилуулгын валютаас ялгаатай байх үед санхүүгийн тайланг толилуулгын валют руу хөрвүүлэх үед үүсэх ханшийн зөрүүний хуримтлагдсан дүнг гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц дансанд бүртгэнэ.
- 14.14 Хуримтлагдсан ашиг гэдэг нь үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал юм. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэж, алдагдлын хэмжээгээр буурна .
- 14.15 УСНББОУС 3-ын нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааг буцаах горимоор хийх тохируулга ба буцаах горимоор хийх дахин тайлагналыг хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд тусгана.
- 14.16 Хуримтлагдсан ашиг данс нь тайлант үеийн цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэх ба хуваарилсан ногдол ашиг ба сангууд, тайлант үеийн алдагдлын хэмжээгээр буурна.
- 14.17 Тайлант үеийн цэвэр ашиг
- 14.18 УСНББОУС-д өөрөөр зөвшөөрч шаардаагүй бол тайлант үед хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын бүх зүйлсийг тайлант үеийн цэвэр ашиг, алдагдалд хамруулна.
- 14.19 УСНББОУС 3-ын тооцооллын өөрчлөлт нь тайлант үед нөлөөтэй бол тайлант үеийн цэвэр ашиг, алдагдалд нөлөөллийг тусгана . Хэрэв тооцооллын өөрчлөлт нь ирээдүй үед нөлөөлөлгүй бол тайлант үеийн ашиг алдагдалд тусгахгүй.
- 14.20 Бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн нөлөөг орлого үр дүнгийн тайланд өмнөх тооцоололд хэрэглэсэн ангиллын дагуу тайлагнана.
- 14.21 Өмнөх нэг эсхүл хэд хэдэн үеийн санхүүгийн тайланд гарсан алдааг тайлант үед илрүүлж болно. Алдаа нь математик тооцоолол, бүртгэлийн бодлогын хэрэглээний алдаа, баримт мэдээг буруу ойлгох, залилах, хяналтгүйгээс бий болно. Алдааны залруулга нь тайлант үеийн цэвэр ашиг, алдагдалд нөлөөлнө.
- 14.22 Өмнөх үетэй холбоотой суурь алдааны залруулгын дүнг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулах замаар тайлагнана.
- 14.23 Санхүүгийн тайланг тодорхой үеүдээр жишихийн тулд тайлангийн үе бүрт мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлого ижил байх ёстой.
- 14.24 Дахин үнэлгээний нэмэгдлийг дахин үнэлсэн хөрөнгийн дахин үнэлсний дараах үлдэгдэл өртөг, үнэлэхийн өмнөх үлдэгдэл өртгийн зөрүүгээр бүртгэнэ.
- 14.25 Тусгай зориулалтын сангуудыг түүнийг байгуулсан дүнгээр нь бүртгэнэ.

4. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 14.26 Байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд дараах зүйлсийг харуулснаар уг тайланг толилуулна.
- 1) Тайлант үеийн ашиг, алдагдал;
 - 2) Бусад стандартаар шаардсанчлан, цэвэр хөрөнгө/өмчийн шууд хүлээн зөвшөөрсөн тухайн тайлант үеийн орлого, зардлын зүйл тус бүр болон тэдгээрийн нийт дүн;
 - 3) Хяналт тавигч байгууллага болон хяналтын бус хувь оролцоонд хамаарах нийт дүнгүүдийг тус тусад нь харуулах;
 - 4) Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хувьд УСНББОУС 3-ын дагуу хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн үр нөлөө ба алдааны засварлалт.
- 14.27 Байгууллага нь мөн дараах зүйлсийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд эсхүл тодруулгад толилуулна.
- 14.28 Эзэд болохын тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн ажил гүйлгээний дүн, үүнд эздэд олгосон хуваарилалтуудыг тусад нь харуулна.
- 14.29 Тайлант үеийн эхэн ба эцэс дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын үлдэгдэл, тухайн тайлант үеийн турш дахь хуримтлагдсан ашиг, алдагдлын өөрчлөлт, ба Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тусдаа толилуулдаг тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн дансны үнийн тайлант үеийн эхний болон эцсийн тохируулга, өөрчлөлт нэг бүрийг тусад нь толилуулна.

5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. Эздийн оруулсан хувь оролцоог нэмэгдүүлэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Засгийн газрын оруулсан капитал - Төрийн өмч	..x-xx-xx-xxx		xxx.xx	

- а. Эздэд олгосон хуваарилалт нь:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Засгийн газрын оруулсан капитал - Төрийн өмч	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxx.xx	

2. Дахин үнэлгээний зөрүү

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлэхээс өмнөх үнээс давсан дахин үнэлсний дараах зөрүүг өмчийн энэ хэсэгт бүртгэнэ. Дахин үнэлгээний зөрүүгийн бүртгэлийг энэ зааврын Үндсэн хөрөнгийн бүлэгт заасны дагуу гүйцэтгэнэ.

3. Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь өмнөх үеийн ба тайлант үеийн ашгаас бүрдэнэ. Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг нь байгуулагдснаас хойшхи нэмэгдсэн капитал юм. Тайлант үед

хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын бүх зүйлсийг тайлант үеийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлоход хамруулна.

Хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлэх эсхүл бууруулах дараах нийтлэг зүйлс байна.

А. Хуримтлагдсан ашгийн дебитэд:

- Тайлангийн үеийн цэвэр алдагдал
- Өмнөх үеийн залруулга ба НББ-ийн бүртгэлийн бодлогын өөрчлөлт
- Ногдол ашиг хуваарилалт

Б. Хуримтлагдсан ашгийн кредитэд:

- Тайлангийн үеийн цэвэр ашиг
- Өмнөх үеийн залруулга, НББ-ийн бодлогын өөрчлөлт
- Дахин үнэлгээний бүрэн хэрэгжилт
- Дахин зохион байгуулалтын үр дүн, тохируулах бичилтүүд

а. Орлогын бүх дансдын өссөн дүнгээр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Орлогын бүх дансд	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Тайлант үеийн ашиг	..x-xx-xx-xxx		xxx.xx	
эсхүл Тайлант үеийн алдагдал	..x-xx-xx-xxx		xxx.xx	

б. Зардлын бүх дансдын өссөн дүнгээр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Тайлант үеийн ашиг	..x-xx-xx-xxx	xxx.xx		
эсхүл Тайлант үеийн алдагдал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Зардлын бүх дансд	..x-xx-xx-xxx		xxx.xx	

в. Байгууллага нийт дүнгээрээ ашигтай бол дараа оны эхний өдөр тайлант үеийн ашгийг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг буюу алдагдалд нэгтгэж:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Тайлант үеийн ашиг	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, (алдагдал)	..x-xx-xx-xxx		xxx.xx	

г. Байгууллага нийт дүнгээрээ алдагдалтай бол дараа оны эхний өдөр тайлант үеийн алдагдлыг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг буюу алдагдалд нэгтгэж:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, (алдагдал)	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Тайлант үеийн алдагдал	..x-xx-xx-xxx		xxx.xx	

д. Өмнөх үеийн үр дүнд нөлөөлөх суурь алдаа ба бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд залруулахад, хэрэв эдгээрийн нөлөөлөл нь хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлж байвал:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хөрөнгө, өр төлбөрийн холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		

эсхүл Тайлант үеийн орлого ба зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Өмнөх хуримтлагдсан ашиг/алдагдал	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Нөлөөлөл нь хуримтлагдсан ашгийг бууруулж байвал:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Өмнөх үеийн хур ашиг/алдагдал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Хөрөнгө, өр төлбөрийн холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxx.xx	
эсхүл Тайлант үеийн орлого ба зардал	..x-xx-xx-xxx		xxx.xx	

Жилийн цэвэр ашгаас нөөцийн сан, нийгмийн хөгжлийн сан, хөгжлийн сан болон бусад тусгай зориулалтын сангуудад хөрөнгө хуваарилахаар шийдвэрлэсэн бол хуваарилах хөрөнгийн дүнгээр:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Тусгай зориулалтын сангууд	..x-xx-xx-xxx		xxx.xx	

5. Тусгай зориулалтын сан

Сангаас санхүүжүүлэх зориулалтаар гарсан зардлыг сангаас зохих зардлын зүйл ангиар бүртгэж, орлого үр дүнгийн тайланд тусгана. Тухайлбал: Нийгмийн хөгжлийн сангаас шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, хандив тусламж олгоход дараах дансны бичилтийг хийнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Нийгмийн хөгжлийн сан	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxx.xx	

15. ТҮРЭЭС

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 13 Түрээс
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга
- УСНББОУС 28 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

1. ТҮРЭЭСИЙН АНГИЛАЛ

- 15.1 Түрээсийн ангилал нь уг түрээслэсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой эрсдэл ба урамшуулал нь түрээслүүлэгчид эсхүл түрээслэгчид хамаарах хэмжээнд үндэслэдэг.
- 15.2 Санхүүгийн түрээс суурь хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэг түрээс юм.
- 15.3 Үйл ажиллагааны түрээс суурь хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэггүй түрээс юм.
- 15.4 Түрээслүүлэгч ба түрээслэгчийн хоорондох ажил гүйлгээ нь тэдгээрийн хооронд хийгдсэн түрээсийн гэрээнд үндэслэнэ. Санхүүгийн түрээс эсхүл үйл ажиллагааны түрээс болох эсэх нь тухайн гэрээний хэлбэрээс бус, харин ажил гүйлгээний мөн чанараас хамаардаг.
- 15.5 Түрээс үүссэн өдөр түрээсийн гэрээний өдөр ба талууд уг түрээсийн үндсэн хугацаа, нөхцлийн хувьд хариуцлага хүлээсэн өдрийн аль эхэнд болох өдөр байна.
- 15.6 Түрээслэгч нь богино хугацаат түрээс ба суурь хөрөнгө нь бага үнэ цэнэтэй байх түрээс гэсэн чөлөөлөлтийг ашиглаагүй л бол ашиглах эрхтэй хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.
- 15.7 Түрээслүүлэгч нь өөрийн түрээс нэг бүрийг үйл ажиллагааны түрээс эсхүл санхүүгийн түрээс гэж ангилна.

2. ТҮРЭЭСЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТҮРЭЭС

САНХҮҮГИЙН ТҮРЭЭС:

- 15.8 Түрээсийн хугацааны эхлэлийн өдөр түрээслэгч нь санхүүгийн түрээсээр олж эзэмшсэн хөрөнгийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө гэж, холбогдох түрээсийн өглөгийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- 15.9 Хөрөнгө, өр төлбөрийг уг уг түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ эсхүл тухайн түрээс үүссэн өдрөөр тодорхойлсон, түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багатай тэнцүү дүнгээр хүлээн зөвшөөрдөг.
- 15.10 Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн дүн дээр нэмэгдэх тухайн түрээслэгчийн аливаа анхны шууд зардлаас бусад, хөрөнгө, түүнчлэн ирээдүйн түрээсийн

төлбөрүүдийг төлөх өр төлбөрийг тухайн түрээс үүссэн өдрөөр санхүүгийн тайланд нэг ижил дүнгээр хүлээн зөвшөөрнө.

- 15.11 Санхүүгийн түрээс нь элэгдэх хөрөнгийн хувьд тайлант үе тус бүрд элэгдлийн зардал, түүнчлэн санхүүгийн зардал бүртгэнэ. Түрээслэсэн хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид системтэй сууриар тайлант үе нэг бүрд хуваарилна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭС

- 15.12 Системтэй өөр суурь нь хэрэглэгчийн өгөөжийн цаг хугацааны хэв загварыг төлөөлөн илэрхийлэхээс бусад тохиолдолд үйл ажиллагааны түрээсийн дагуу төлөх түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын сууриар зардал гэж хүлээн зөвшөөрнө.

3. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТҮРЭЭС

САНХҮҮГИЙН ТҮРЭЭС:

- 15.13 Түрээслүүлэгч нь санхүүгийн түрээсийн дагуу авах түрээсийн авлагыг санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Түрээслүүлэгч нь тухайн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцүү дүнгээр ийм хөрөнгийг авлага гэж толилуулна.
- 15.14 Санхүүгийн түрээсийн хувьд түрээслүүлэгч нь хууль ёсны өмчлөлтэй холбоотой бараг бүр эрсдэл ба урамшууллыг шилжүүлдэг. Иймээс түрээсийн төлбөрийн авлагыг өөрийн хөрөнгө оруулалт ба үйлчилгээний төлөө түүнд нөхөн олгох буюу урамшуулал болгон өгөх үндсэн дүнгийн болон санхүүгийн орлогын урьдчилсан төлбөр гэж үзнэ.
- 15.15 Санхүүгийн орлогын хүлээн зөвшөөрөлт нь уг түрээслүүлэгчийн санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтаас олох өгөөжийн тогтмол үечилсэн хувь хэмжээг тусгах тийм хэв загварт үндэслэнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭС

- 15.16 Түрээслүүлэгч нь үйл ажиллагааны түрээст хамаарах хөрөнгийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа тухайн хөрөнгийн шинж төрлийн дагуу толилуулна.
- 15.17 Системтэй өөр суурь нь тухайн түрээслэсэн хөрөнгөөс олох өгөөжийн буурах цаг хугацааны хэв маягийг илүү сайн төлөөлөн илэрхийлэхээс бусад тохиолдолд үйл ажиллагааны түрээсээс олох түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын сууриар орлого гэж хүлээн зөвшөөрнө.
- 15.18 Үйл ажиллагааны түрээсийн хэлцэл хийх ба эрхлэн явуулахдаа түрээслүүлэгчийн гаргасан анхны шууд зардлыг тухайн түрээслэсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмж, тэрхүү түрээсийн хугацааны туршид түрээсийн орлоготой ижил сууриар зардал гэж хүлээн зөвшөөрнө.
- 15.19 Түрээслэсэн элэгдэх хөрөнгийн элэгдлийн бодлого нь түрээслүүлэгчийн адилтгах хөрөнгийн элэгдлийн ердийн бодлоготой нийцсэн байх бөгөөд элэгдлийг УСНББОУС 17 ба УСНББОУС 31-ийн аль тохиромжтой стандартын дагуу тооцоолно.

4. БОРЛУУЛАХ БА БУЦААН ТҮРЭЭСЛЭХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

- 15.20 Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ нь санхүүгийн түрээс бий болгох үр дүнтэй бол борлуулагч-түрээслэгч нь дансны үнээс давсан борлуулалтын орлогын аливаа хэтэрсэн дүнг орлого гэж нэн даруй хүлээн зөвшөөрөхгүй. Харин үүнийг хойшлуулж, түрээсийн хугацаанд хорогдуулна.
- 15.21 Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ нь үйл ажилллагааны түрээс бий болгох үр дүнтэй бөгөөд тухайн ажил гүйлгээг бодит үнэ цэнээр хийдэг гэдэг нь тодорхой ойлгомжтой бол аливаа олз буюу гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрнө.
- 15.22 Үйл ажилллагааны түрээсийн хувьд борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний өдрийн бодит үнэ цэнэ нь тухайн хөрөнгийн дансны үнээс бага бол уг дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүтэй байх гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрнө.

5. ТОЛИЛУУЛГА БА ТОДРУУЛГА

- 15.23 Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг бусад хөрөнгө, өр төлбөрөөс тусад нь толилуулна.
- 15.24 Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд түрээслэгч нь түрээсийн өр төлбөрийн хүүний зардлыг тухайн ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардлаас тусад нь толилуулна. Түрээсийн өр төлбөрийн хүүний зардал нь санхүүгийн зардлын бүрэлдэхүүн хэсэг юм.
- 15.25 Үйл ажилллагааны түрээсээр түрээслүүлэх суурь хөрөнгийг түрээслүүлэгч нь тухайн суурь хөрөнгийн шинж төрлийн дагуу өөрийн санхүүгийн байдлын тайландаа толилуулна.

6. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

1. ТҮРЭЭСЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТҮРЭЭС

1.1 Санхүүгийн түрээс

а. Түрээсийн хугацааны эхлэлийн өдөр бодит үнэ цэнэ эсхүл, түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар хүлээн зөвшөөрөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ашиглах эрхтэй хөрөнгө	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Түрээсийн өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	

б. Түрээслэгчийн түрээсийн өглөгийн барагдуулах үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Түрээсийн өглөг	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Хөрөнгийн татварын зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..x-xx-xx-xxx		xxx.xx	

в. Жил бүрийн элэгдлийн зардлыг бүртгэх дансны бичилт:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал	..x-xx-xx-xxx	xxx.xx		
Ашиглах эрхтэй хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	..x-xx-xx-xxx		xxx.xx	

г. Түрээсийн өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хүүгийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хүүгийн өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	

д. Түрээсийн өр төлбөрийг шилжүүлэх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Түрээсийн өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хүүний өглөг	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хөрөнгийн татварын зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

е. Түрээслэсэн тоног төхөөрөмжийг түрээслүүлэгчид буцааж өгөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Ашиглах эрхтэй хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

1.2 үйл ажиллагааны түрээсийн үед

а. Жил бүрийн эхэнд түрээсийн төлбөрийг бүртгэх дансны бичилт:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урьдчилж төлсөн түрээсийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Жил бүрийн эцэст:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Түрээсийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Урьдчилж төлсөн түрээсийн зардал	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТҮРЭЭС

2.1 Үйл ажиллагааны түрээс

а. Түрээсийн орлогыг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бусад авлага	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Түрээсийн орлого	..X-XX-XX-XXX		xxx.xx	

б. Түрээсийн авлага мөнгөөр төлөгдөхөд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Бусад авлага	..X-XX-XX-XXX		xxx.xx	

в. Түрээсийн хөрөнгийн элэгдлийн зардлыг бүртгэхэд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Элэгдлийн зардал	..X-XX-XX-XXX	xxx.xx		
Хуримтлагдсан элэгдэл	..X-XX-XX-XXX		xxx.xx	

2.2 Санхүүгийн түрээс

а. Анхдагч хэмжилтийн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Түрээсийн авлага	..х-хх-хх-ххх	xxx.xx		
Хуримтлагдсан элэгдэл	..х-хх-хх-ххх		xxx.xx	
Суурь машин	..х-хх-хх-ххх	xxx.xx		
Түрээсийн олз	..х-хх-хх-ххх		xxx.xx	

б. Түрээсийн төлбөр төлөгдөх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..х-хх-хх-ххх	xxx.xx		
Түрээсийн авлага	..х-хх-хх-ххх		xxx.xx	

в. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт хийх үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хүүгийн авлага	..х-хх-хх-ххх	xxx.xx		
Хүүгийн орлого	..х-хх-хх-ххх		xxx.xx	

в. Жилийн эцэст хийх бичилт:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгө	..х-хх-хх-ххх	xxx.xx		
Түрээсийн авлага	..х-хх-хх-ххх		xxx.xx	
Хүүгийн авлага	..х-хх-хх-ххх		xxx.xx	
Хүүгийн орлого	..х-хх-хх-ххх		xxx.xx	

16. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН, ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ, АЛДАА

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт болон алдаа

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

- 16.1 Аль нэг УСНББОУС -ыг ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдалд тусгайлан мөрддөг тохиолдолд тэдгээрт мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого буюу бодлогуудыг уг УСНББОУС -ын дагуу тодорхойлно.
- 16.2 Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдалд тусгайлан мөрдөх УСНББОУС байхгүй тохиолдолд удирдлага нь дараах шинж нөхцөл бүхий мэдээллийг бий болгоход хүргэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулж, мөрдөхдөө өөрийн шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлийг ашиглана.
- 16.3 Байгууллага шүүн тунгаалт хийхдээ дараах дарааллаар илэрхийлсэн эх сурвалжуудыг мөрдөх боломжтой байдлыг авч үзнэ. Үүнд:
- 1) Ижил төсөөтэй ба холбоотой асуудлуудын талаарх УСНББОУС-ын шаардлагууд;
 - 2) Улсын Секторын байгууллагуудын нийтлэг зорилготой Санхүүгийн тайлагналын Онолын Үзэл баримтлал-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн шалгуур.
- 16.4 УСНББОУС болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид ажил гүйлгээ, үйл явдлыг бүртгэхэд өөр бүртгэлийн бодлого хэрэглэх нь зохистой гэж тусгайлан шаардсанаас бусад тохиолдолд байгууллага нь ижил төрлийн ажил гүйлгээ, үйл явдлыг бүртгэхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тууштай сонгож мөрдөнө
- 16.5 Санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэгдэхүйц байдлыг хангахын тулд бүртгэлийн бодлогыг тууштай хэрэглэх нь зүйтэй.
- 16.6 Байгууллага нь зөвхөн дараах тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилнө. Үүнд:
- 1) Өөрчлөлтийг УСНББОУС-аар шаардсан; эсхүл
 - 2) Өөрчлөлт нь тухайн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд ажил гүйлгээ, бусад үйл явдал болон нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөний талаар үнэн зөв илэрхийлэх ба илүү хамааралтай мэдээллээр хангах үр дүнг санхүүгийн тайланд бий болгох.
- 16.7 Доорх тохиолдолд нь НБББ-н өөрчлөлт биш юм
- 1) Өмнө нь гарч тохиолдож байсан ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлаас мөн чанарын хувьд ялгаатай тийм ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлын хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогын мөрдөлт;

- 2) Өмнө нь гарч тохиолдож байгаагүй, эсхүл гарч тохиолдсон боловч материаллаг бус байсан тийм ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлын хувьд нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг мөрдөлт.
- 16.8 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаах горимоор мөрдсөн бол тухайн байгууллага нь толилуулсан хамгийн эхний өмнөх тайлант үеийн цэвэр хөрөнгө/өмчийн тэдгээр нөлөөлөгдсөн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн эхний үлдэгдлүүд ба түүнээс хойшхи өмнөх тайлант үе бүрд толилуулсан бусад зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг угаасаа мөрдөж байсан бол ямар байх байсан тийм байдлаар тохируулна. Ийм тохируулгыг ихэвчлэн хуримтлагдсан ашиг, алдагдалд хийдэг.
- 16.9 Буцаан мөрдөлт нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг угаасаа мөрдөж байсан бол ямар байх байсан тийм байдлаар ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдалд тэрхүү бодлогыг даган мөрдөхийг хэлнэ.
- 16.10 Нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн нь тайлант болон өмнөх үеүүдэд нөлөө үзүүлэхээр байвал аж ахуйн нэгж байгууллага нь дараах зүйлсийг тодруулна . Үүнд :
- 1) Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх болсон шалтгаан;
 - 2) Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн мөн чанар;
 - 3) Тайлант болон өмнөх үеүүдэд толилуулсан санхүүгийн тайлангуудад хийсэн тохируулгын нөлөөг санхүүгийн тайлангийн зүйл тус бүрээр;
 - 4) Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөг тооцох боломжгүй бол бодлогын өөрчлөлтийг хэрхэн, хэзээнээс эхлэн мөрдсөн тухай тайлбар.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ

- 16.11 Үзүүлэх үйлчилгээ, худалдаа буюу бусад үйл ажиллагааг эрхлэн явуулахад тулгардаг тодорхойгүй байдлыг улмаас санхүүгийн тайлан дахь олон зүйлсийг нарийн оновчтой хэмжиж чадахгүй боловч зөвхөн ойролцоогоор тооцоолж чаддаг. Тооцоолол нь хамгийн сүүлийн үеийн байдлаар бэлэн байгаа, найдвартай мэдээлэлд үндэслэн шүүн тунгаалт хийж мэргэжлийн шийдлээ ашиглан тодорхойлохыг агуулдаг. Дараах зүйлс тооцооллын өөрчлөлтийг шаардаж болно. Тухайлбал:
- 1) Найдваргүй авлага;
 - 2) Бараа материалын хуучралт;
 - 3) Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнэ;
 - 4) Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа эсхүл ирээдүйд хүлээгдэж буй эдийн засгийн өгөөж;
 - 5) Баталгааны үүрэг хариуцлага.
- 16.12 Тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг дараах байдлаар ашиг, алдагдалд тусгаж, гүйцээх горимоор хүлээн зөвшөөрнө.
- 1) Хэрэв өөрчлөлт нь зөвхөн тэр тайлант үедээ нөлөө үзүүлдэг бол өөрчлөлт гарсан уг тайлант үед нь; эсхүл
 - 2) Хэрэв өөрчлөлт нь гарсан тэр тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдийн аль алинд нөлөө үзүүлдэг бол өөрчлөлт гарсан уг тайлант үе болон ирээдүйн тайлант үеүүдэд.
- 16.13 Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт нь хөрөнгө, өр төлбөрт өөрчлөлт ороход хүргэдэг буюу цэвэр хөрөнгө/өмчийн зүйлд хамааралтай байх тэр хэмжээгээр холбогдох хөрөнгө, өр төлбөр буюу цэвэр

хөрөнгө/өмчийн дансны үнийг тохируулах замаар уг өөрчлөлт гарсан тайлант үед түүнийг хүлээн зөвшөөрнө.

- 16.14 Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг гүйцээх горимоор хүлээн зөвшөөрөх гэдэг нь тооцооллын өөрчлөлт гарсан өдрөөс эхлэн уг өөрчлөлтийг ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдалд мөрдөхийг хэлнэ.
- 16.15 Тухайн тайлант үед хамаарах уг өөрчлөлтийн үр нөлөөг тайлант үеийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн тайлант үеүдэд үр нөлөө хэрэв байгаа бол түүнийг тэдгээр ирээдүйн тайлант үеүдэд орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.
- 16.16 Байгууллага нь тухайн тайлант үед нөлөө үзүүлэх буюу ирээдүйн тайлант үеүдэд нөлөө үзүүлэхээр хүлээгдэж буй нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн шинж төрөл, ба дүнг тодруулна.
- 16.17 Хэрэв бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн нөлөөг тооцож чадахааргүй буюу дүнг тоогоор илэрхийлэх боломжгүй бол энэ тухай нөхцөл байдлыг тодруулна.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АЛДАА

- 16.18 Алдаа нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга ба тодруулгаас үүдэн гарч болно.
- 16.19 Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг.
- 16.20 Зарим материаллаг алдаа нь дараа үед илэрдэг бөгөөд эдгээр өмнөх тайлант үеийн алдааг илрүүлсэн тайлант үеийн санхүүгийн тайлангийн зэрэгцүүлсэн мэдээллээр толилуулж залруулна.
- 16.21 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”. Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.
- 16.22 Дараах тохиолдолд алдаа үүсч болно. Үүнд:
- 1) Математик тооцооллын алдаа;
 - 2) Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буруу хэрэглэснээс бий болох алдаа;
 - 3) Буруу ойлгогдсон зүйлс буюу санамсарг үй алдаа;
 - 4) Залилан.
- 16.23 Байгууллага нь өмнөх тайлант үеийн материаллаг алдааг илрүүлсний дараах ба гаргахыг зөвшөөрсөн эхний иж бүрэн санхүүгийн тайланд уг алдааг доорх байдлаар буцаах горимоор засварлана.
- 1) Алдаа гарсан уг өмнөх тайлант үеүдэд толилуулсан зэрэгцүүлэгдэх дүнг дахин тайлагнах,
 - 2) Хэрэв алдаа нь толилуусан хамгийн эхний өмнөх тайлант үеэс урд өмнө гарч тохиолдсон бол тухайн толилуулсан хамгийн эхний өмнөх тайлант үеийн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдлийг дахин тайлагнана.
- 16.24 Өмнөх тайлант үеийн алдааны засварлалтыг уг алдааг илрүүлсэн тайлант үеийн ашиг, алдагдалд оруулахгүй.

- 16.25 Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн алдаа гарсан тайлант үед өмнөх тайлант үеийн алдаа түүний залруулгын талаарх дараах зүйлсийг тодруулна. Үүнд:
- 1) Алдаа гарах болсон шалтгаан, алдааны мөн чанар;
 - 2) Тайлант үе бүрт толилуулсан алдаа ба залруулгын дүнг нөлөө үзүүлсэн санхүүгийн тайлангийн зүйл тус бүрээр;
 - 3) алдааг тухайн тайлант үед нь залруулж дахин тайлагнах практик боломжгүй байвал тухайн нөхцөл байдалд хүргэсэн нөхцөл байдал болон хэрхэн , хэзээнээс эхлэн залруулсан тухай тайлбар.

17. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 4 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө

1. ХАМРАХ ХҮРЭЭ

- 17.1 Гадаад валютын бүртгэлийн бодлого нь гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ ба гүйлгээ дэх үйл ажиллагааг санхүүгийн тайланд хэрхэн тусгах болон санхүүгийн тайлан толилуулгын валют нь хэрхэн хөрвүүлэхийг тодорхойлоход оршино. Өөрөөр хэлбэл валютын ямар ханш хэрэглэх, валютын ханшийн өөрчлөлт, үр нөлөөг санхүүгийн тайланд хэрхэн тусгах явдал юм.
- 17.2 **Толилуулгын валют** гэдэг нь тухайн санхүүгийн тайланг толилуулдаг валют юм. байгууллагын толилуулгын валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт *төгрөг, мөнгө* байна.
- 17.3 **Бүртгэлийн валют** гэдэг нь тухайн аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулдаг, эдийн засгийн анхдагч орчны валют юм.
- 17.4 **Гадаад валют** гэдэг нь аж ахуйн нэгжийн бүртгэлийн валютаас өөр валют юм.
- 17.5 **Валютын ханш** гэдэг нь хоёр валютын хоорондох солилцооны харьцаа юм.
- 17.6 **Ханшийн зөрүү** гэдэг нь тодорхой тооны нэг валютыг нөгөө валютад өөр өөр ханшаар хөрвүүлснээс үүссэн зөрүү юм.
- 17.7 **Хаалтын ханш** гэдэг нь тайлант үеийн эцэс дэх спот ханш юм. Монголбанк нь 2010 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн “ТУХАЙН ӨДРИЙН ХААЛТЫН ХАНШ”-ийг зарлаж байгаа бөгөөд энэ ханшийг Монголбанкнаас зарласан дараа өдрийн ханш гэж тооцно. Өөрөөр хэлбэл уг ханшийг Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6 дахь заалтад заасан Монголбанкны албан ханш гэж ойлгоно.
- 17.8 **Спот ханш** гэдэг нь тэр даруй хийгдэх солилцоонд хамаарах валютын ханш юм.

2. АНГИЛАЛ

- 17.9 Байгууллага нь ажил гүйлгээг гадаад валютаар хийх эсхүл гадаадад үйл ажиллагаа явуулах гэсэн хоёр арга замаар гадаад үйл ажиллагааг эрхэлж болно.
- 17.10 Гадаад үйл ажиллагаа гэдэг нь тайлагнагч байгууллагын улс орон буюу валютаас өөр улс орон буюу валютанд үндэслэн үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг уг тайлагнагч байгууллагын хяналтанд буй байгууллага, хараат компани, хамтын хэлэлцээр эсхүл салбар юм.

3. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР БА ХЭМЖИЛТ

- 17.11 Гадаад валютаарх ажил гүйлгээ нь гадаад валютаар хийгдсэн эсхүл гадаад валютаар төлбөр тооцоог барагдуулахыг шаарддаг ажил гүйлгээ бөгөөд байгууллагын доорх ажил гүйлгээ хамаарна.
- 1) гадаад валютаар үнэ нь илэрхийлэгдсэн бараа, үйлчилгээг худалдах, эсхүл худалдан авах;
 - 2) өглөг авлагын дүн нь гадаад валютаар илэрхийлэгдэх тохиолдолд мөнгөн санг зээлдэн авах эсхүл зээл олгох;
 - 3) Гадаад валютаар илэрхийлэгдэх бөгөөд дээр дурдсанаас өөр бусад байдлаар хөрөнгийг олж эзэмших буюу данснаас хасах, өр төлбөр үүсгэх буюу барагдуулах.
- 17.12 Байгууллага нь гадаад валютаар гарсан ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох спот ханшаар уг гадаад валютын дүнг үржүүлж, бүртгэлийн валютаар бүртгэнэ.
- 17.13 Дараагийн тайлант үе бүрийн эцэс дэх тайлагнал:
- 1) Гадаад валютаарх мөнгөн зүйлсийг хаалтын ханшаар хөрвүүлэх,
 - 2) Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлэх,
 - 3) Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжсэн мөнгөн бус зүйлсийг уг бодит үнэ цэнийг хэмжсэн өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлнэ.
- 17.14 Ханшийн зөрүүгийн хүлээн зөвшөөрөлт- мөнгөн зүйлсийн барагдуулалтаас, эсхүл мөнгөн зүйлсийг тухайн тайлант үеийн туршид буюу өмнөх санхүүгийн тайланд анх хүлээн зөвшөөрөхдөө хөрвүүлсэн ханшнаас өөр ханшаар хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүг тэдгээрийн гарсан уг тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 17.15 Мөнгөн бус зүйлсийн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрдөг тохиолдолд тэрхүү олз, гарзын ханшийн өөрчлөлттэй холбоотой аливаа бүрэлдэхүүн хэсгийг мөн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрнө. Харин эсрэгээр мөнгөн бус зүйлсийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг тохиолдолд тэрхүү олз, гарзын ханшийн өөрчлөлттэй холбоотой аливаа бүрэлдэхүүн хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- Бүртгэлийн валютын өөрчлөлт
- 17.16 Байгууллагын бүртгэлийн валют өөрчлөгдсөн тохиолдолд уг байгууллага нь шинэ бүртгэлийн валютын хувьд хэрэглэх хөрвүүлэлтийн горимоо тухайн өөрчлөлтийн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө.

4. БҮРТГЭЛИЙН ВАЛЮТААС ӨӨР ВАЛЮТЫГ ТОЛИЛУУЛГАД АШИГЛАХ

Толилуулгын валютад хөрвүүлэх

- 17.17 Байгууллагын толилуулгын валют нь бүртгэлийн валютаас өөр бол тухайн байгууллага нь өөрийн санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлаа толилуулгын валютанд хөрвүүлнэ. Жишээ нь гадаад суугаа элчин сайдын яамд, олон улсын байгууллага гэх мэт
- 17.18 Дараах горимуудыг ашиглан санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг уг бүртгэлийн валютаас өөр байх толилуулгын валютанд хөрвүүлнэ.
- 17.19 Толилуулсан санхүүгийн байдлын тайлан тус бүрийн хувьд хөрөнгө ба өр төлбөрийг тухайн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх хаалтын ханшаар хөрвүүлнэ.
- 17.20 Санхүүгийн үр дүнгийн тайлан тус бүрийн хувьд орлого, зардлыг тухайн ажил гүйлгээ гарсан өдрүүдийн ханшаар хөрвүүлнэ.
- 17.21 Үр дүн болох бүх ханшийн зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.
- 17.22 Мөнгөн гүйлгээг, өөрөөр хэлбэл түүний мөнгөн гүйлгээний тайланд тусган оруулсан гадаад үйл ажиллагааны мөнгөн орлого ба мөнгөн төлбөрийг хөрвүүлэх үед уг тайлагнагч байгууллага нь УСНББОУС 2-д заасан горимыг мөрдөнө.
- 17.23 Гадаад үйл ажиллагааны тодорхойлолтыг хангадаг, хяналтад буй байгууллагын мөнгөн гүйлгээг тухайн мөнгөн гүйлгээ гарсан өдрийн толилуулгын валют ба гадаад валютын хоорондох ханшаар хөрвүүлэхийг УСНББОУС 2-оор шаардсан байдаг.
- 17.24 Практик шалтгааны улмаас орлого, зардлын зүйлсийг хөрвүүлэхдээ тухайн ажил гүйлгээ гарсан өдрүүдийн валютын ханштай ойролцоо ханшийг, тухайлбал, тайлант үеийн дундаж ханшийг ихэвчлэн ашигладаг. Гэвч ханш ихээхэн хэлбэлзэлтэй байвал тухайн тайлант үеийн дундаж ханшийг ашиглах нь тохиромжгүй байдаг.
- 17.25 Байгууллага нь дараах зүйлсийг тодруулгад тодруулна.
- 1) УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хэрэглүүрээс үүссэн ханшийн зөрүүгээс бусад, ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүүгийн дүн
 - 2) Цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт ангилсан ханшийн цэвэр зөрүү болон уг ханшийн зөрүүгийн тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх дүнгүүдийн хоорондох тохируулгын тайлан,
 - 3) Толилуулгын валют нь бүртгэлийн валютаас өөр байх тохиолдолд энэ тухай, түүнчлэн уг бүртгэлийн валют болон толилуулгад өөр валют ашигласан шалтгааны тодруулгын хамт илэрхийлнэ.
- 17.26

5. АЖИЛ ГҮЙЛГЭЭГ БҮРТГЭХ ЖУРНАЛЫН БИЧИЛТҮҮД:

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээг гарсан өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэлд тусгана.

1. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн бүртгэл

а. “Мөнгөн хөрөнгийн бүртгэл” бүлгээс харна уу.

2. Гадаад валютаар дансны авлага үүссэн үед:

а. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн үед гадаад валютаар авлаг үүссэн тохиолдолд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны авлага	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Тухайн үеийн МБ албан ханшаар
Холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Тухайн үеийн МБ албан ханшаар

б. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа үед-гадаад валютаар илэрхийлэгдсэн дансны авлагын үлдэгдлийг тайлант үеийн бүртгэлийн Монголбанкны албан ханшаар (хаалтын ханш) төгрөгт шилжүүлэн валютын бодит бус ханшийн зөрүүг тооцож бүртгэнэ.

- *Ханшийн зөрүүгийн бодит бус олз үүссэн үед:*

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны авлага	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Тухайн үе болон тайлант үеийн албан ханшийн зөрүү
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз	..x-xx-xx-xxx		xxxx.xx	

- *Ханшийн зөрүүгийн бодит бус гарз үүссэн үед:*

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус гарз	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Тухайн үе болон тайлант үеийн МБ албан ханшийн зөрүү
Дансны авлага	..x-xx-xx-xxx		xxxx.xx	

Авлага барагдуулсан өдрийн валютын албан ханш нь авлага үүссэн өдрийн албан ханшнаас зөрүүтэй бол хэлбэлзсэн хэмжээгээр ханшийн зөрүүний бодит олз, гарз үүснэ.

- *Төлбөр хийгдэх үед ханшийн зөрүүгийн бодит олз үүссэн үед:*

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны авлага	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Авлага барагдсан дүн * тайлант үеийн тэгшитгэсэн МБ хаалтын ханш
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Авлага барагдуулсан дүн * авлага барагдуулсан өдрийн МБ-ны албан ханшаар
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит олз	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Авлага барагдуулсан дүн * (анх үүссэн үеийн МБ спот ханш - төлбөр төлөх үеийн МБ спот ханш)

Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз/гарз	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Дебет болон кредитын зөрүү дүнгээр
--	---------------	--	---------	------------------------------------

- Төлбөр хийгдэх үед ханшийн зөрүүгийн бодит гарз үүссэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны авлга	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Авлага барагдсан дүн * тайлант үеийн тэгшитгэсэн МБ хаалтын ханш
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит гарз	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Авлага барадуулсан дүн * (анх үүссэн үеийн МБ спот ханш - төлбөр төлөх үеийн МБ спот ханш)
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Авлага барагдуулсан дүн * авлага барагдуулсан өдрийн МБ-ны албан ханшаар
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз/гарз	..x-xx-xx-xxx			Дебет болон кредитын зөрүү дүнгээр

3. Гадаад валютаар хөрөнгө худалдан авч дансны өглөг үүссэн үед:

А. Анхдагч хүлээн зөвшөөрөлт:

- Урьдчилгаа төлбөр төлсөн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Урьдчилж төлсөн тооцоо	..x-xx-xx-xxx	xxx.xx		Урьдчилгаа төлсөн өдрийн монгол банкны албан ханш * шилжүүлсэн валют
Мөнгөн хөрөнгө /валют/	..x-xx-xx-xxx		xxx.xx	

- Хөрөнгийг хүлээн авч дансны өглөг үүсэх үед:

Хөрөнгийг хүлээн авах үед тухайн өдрийн монголбанкны албан ханшаар хөрөнгийн худалдан авалтын үнийн дүнг тодорхойлон бүртгэх хэдий ч урьдчилгаа төлбөрт төлсөн төлбөрийн дүнг харгалзан үзэж нийт үнийн дүнг тодорхойлно.

Харин бэлтгэн нийлүүлэгчид өгөх дансны өглөгийг хөрөнгийн валютаар илэрхийлэгдсэн нийт үнийн дүнгээс урьдчилгаанд төлсөн валютыг хасч, үлдэгдэл валютын дүнг хөрөнгө хүлээн авах үеийн монголбанкны албан ханшаар үржүүлж бүртгэнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Үндсэн хөрөнгө-холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		Худалдан авсан өртгөөр
Бараа материал-холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxx.xx		Худалдан авсан өртгөөр
Дансны өглөг	..x-xx-xx-xxx		xxx.xx	Хүлээн авсан хөрөнгөд ногдох үлдэгдэл төлбөр * тухайн өдрийн МБ албан ханш

Урьдчилж төлсөн тооцоо	..X-XX-XX-XXX		xxx.xx	Анх үүссэн дүнгээр
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Тээврийн зардал
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Бусад
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Гаалийн бүрдүүлэлт
Дансны өглөг	..X-XX-XX-XXX		xxx.xx	Гаалийн татвар

Б. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа үед:

- Гадаад валютаар илэрхийлэгдсэн дансны өглөг /Хүлээн авсан хөрөнгөд ногдох үлдэгдэл төлбөр * тухайн өдрийн МБ албан ханш/-ийн үлдэгдлийг тайлант үеийн Монголбанкны албан ханшаар(хаалтын ханш) төгрөгт шилжүүлэн бүртгэж, валютын бодит бус ханшийн зөрүүг тооцно.

Хэрэв дараа дараагийн тайлант үеүдэд хаалтын ханш хэлбэлзэж байвал тухай бүрт нь ханшийн тэгшитгэлийг хийж бодит бус олз, гарзыг бүртгэнэ.

Өөрөөр хэлбэл гадаад валютаар илэрхийлэгдсэн дансны өглөгийн үлдэгдэл нь тайлант үеийн Монголбанкны албан ханшаар илэрхийлэгдэж бүртгэгдэнэ.

Ханшийн зөрүүгийн бодит бус олз үүссэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг	..X-XX-XX-XXX	xxxx.xx		Тайлант үеүүдийн МБ хаалтын ханшуудын зөрүүгээр
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз	..X-XX-XX-XXX		xxxx.xx	

Ханшийн зөрүүгийн бодит бус гарз үүссэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус гарз	..X-XX-XX-XXX	xxxx.xx		Тайлант үеүүдийн МБ хаалтын ханшуудын зөрүүгээр
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг	..X-XX-XX-XXX		xxxx.xx	

- Төлбөр төлөх өдрийн валютын албан ханш нь өглөг анх үүссэн өдрийн албан ханшнаас зөрүүтэй бол хэлбэлзсэн хэмжээгээр ханшийн зөрүүний бодит олз, гарз үүснэ.

Төлбөр хийгдэх үед ханшийн зөрүүгийн бодит олз үүссэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны өглөг	..X-XX-XX-XXX	xxxx.xx		Төлбөр төлсөн дүн * тайлант үеийн тэгшитгэсэн МБ хаалтын ханш
Мөнгөн хөрөнгө /валют/	..X-XX-XX-XXX		xxxx.xx	Төлсөн дүн * Төлбөр төлөх өдрийн МБ-ны албан ханшаар
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит олз	..X-XX-XX-XXX		xxxx.xx	Төлбөр төлсөн валют * (анх үүссэн үеийн МБ хаалтын ханш - төлбөр төлөх үеийн ханш)

Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз/гарз	..x-xx-xx-xxx			Дебет болон кредитын зөрүү дүнгээр
--	---------------	--	--	------------------------------------

Төлбөр хийгдэх үед ханшийн зөрүүгийн бодит гарз үүссэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Дансны өглөг	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Төлбөр төлсөн дүн * тайлант үеийн тэгшитгэсэн МБ хаалтын ханш
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит гарз	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Төлбөр төлсөн валют * (анх үүссэн үеийн МБ спот ханш - төлбөр төлөх үеийн МБ спот ханш)
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Төлсөн дүн * Төлбөр төлөх өдрийн МБ-ны албан ханшаар
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз/гарз	..x-xx-xx-xxx			Дебет болон кредитын зөрүү дүнгээр

4. Гадаад валютаар зээлийн өр төлбөр үүссэн үед:

А. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн үед:

Богино болон урт хугацаат зээлийн санхүүжилтийг бусдаас авсан тохиолдолд:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Тухайн үеийн албан ханшаар
Богино хугацаат зээлийн өр төлбөр	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Тухайн үеийн албан ханшаар
Урт хугацаат зээлийн өр төлбөр	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Тухайн үеийн албан ханшаар

Богино болон урт хугацаат зээл төлөлтийн графикийн дагуу зээлийн хүүг сар бүр хуримтлуулан бүртгэх бөгөөд дараах бичилтийг хийнэ.

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Холбогдох хөрөнгийн данс	..x-xx-xx-xxx	xxxx.xx		
Хүүний зардал	..x-xx-xx-xxx	xxxx.xx		
Хүүний өглөг	..x-xx-xx-xxx		xxxx.xx	Тухайн үеийн МБ албан ханшаар

Б. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа үед:

Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл болон зээлийн хүүгийн дансдын үлдэгдлүүдийг тайлант үеийн бүртгэлийн Монголбанкны албан ханшаар (хаалтын ханш) төгрөгт шилжүүлэн валютын бодит бус ханшийн зөрүүг тооцож бүртгэнэ.

- Ханшийн зөрүүгийн бодит бус олз үүссэн үед:

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Хүүний өглөг	..x-xx-xx-xxx	xxxx.xx		Тухайн үе болон тайлант үеийн албан ханшийн зөрүү
Богино хугацаат зээлийн өр төлбөр	..x-xx-xx-xxx	xxxx.xx		
Урт хугацаат зээлийн өр төлбөр	..x-xx-xx-xxx	xxxx.xx		

Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз	..X-XX-XX-XXX		XXXX.XX	
---	---------------	--	---------	--

- *Ханшийн зөрүүгийн бодит бус гарз үүссэн үед:*

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус гарз	..X-XX-XX-XXX	XXXX.XX		Тухайн үе болон тайлант үеийн МБ албан ханшийн зөрүү
Хүүний өглөг	..X-XX-XX-XXX		XXXX.XX	
Богино хугацаат зээлийн өглөг	..X-XX-XX-XXX		XXXX.XX	
Урт хугацаат зээлийн өглөг	..X-XX-XX-XXX		XXXX.XX	

Төлбөр төлсөн өдрийн валютын албан ханш нь өглөг үүссэн өдрийн албан ханшнаас зөрүүтэй бол хэлбэлзсэн хэмжээгээр ханшийн зөрүүний бодит олз, гарз үүснэ.

- *Төлбөр хийгдэх үед ханшийн зөрүүгийн бодит олз үүссэн үед:*

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Богино хугацаат зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX	XXXX.XX		Төлбөр төлсөн дүн * тайлант үеийн тэгшитгэсэн МБ хаалтын ханш
Урт хугацаат зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX	XXXX.XX		Тухайн үеийн албан ханшаар
Хүүний өглөг	..X-XX-XX-XXX	XXXX.XX		Тухайн үеийн албан ханшаар
Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	..X-XX-XX-XXX		XXXX.XX	Төлсөн дүн * Төлбөр төлөх өдрийн МБ-ны албан ханшаар
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит олз	..X-XX-XX-XXX		XXXX.XX	Төлбөр төлсөн валют * (анх үүссэн үеийн МБ спот ханш - төлбөр төлөх үеийн МБ спот ханш)
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз/гарз	..X-XX-XX-XXX			Дебет болон кредитын зөрүү дүнгээр

- *Төлбөр хийгдэх үед ханшийн зөрүүгийн бодит гарз үүссэн үед:*

Дансны нэр	Дансны код	Дебит	Кредит	Тайлбар
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөг	..X-XX-XX-XXX	XXXX.XX		Төлбөр төлсөн дүн * тайлант үеийн тэгшитгэсэн МБ хаалтын ханш
Богино хугацаат зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX	XXXX.XX		Тухайн үеийн албан ханшаар
Урт хугацаат зээлийн өр төлбөр	..X-XX-XX-XXX	XXXX.XX		Тухайн үеийн албан ханшаар
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит гарз	..X-XX-XX-XXX	XXXX.XX		Төлбөр төлсөн валют * (анх үүссэн үеийн МБ спот ханш - төлбөр төлөх үеийн МБ спот ханш)

Мөнгөн хөрөнгийн холбогдох данс	10/11х-хх-хх-ххх		хххх.хх	Төлсөн дүн * Төлбөр төлөх өдрийн МБ-ны албан ханшаар
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус олз/гарз	..х-хх-хх-ххх			Дебет болон кредитын зөрүү дүнгээр

18. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ

Холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт:

- УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- УСНББОУС 32 Үйлчилгээний концессын хэлцэл
- УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө
- УСНББОУС 31 Биет бус хөрөнгө

1. КОНЦЕССЫН ХӨРӨНГИЙН АНГИЛАЛ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 18.1 Үйлчилгээний концессын хөрөнгийн жишээнд авто зам, гүүр, туннель, эмнэлэг, нисэх онгоцны буудал, ус түгээх байгууламж, эрчим хүчний хангамжийн болон харилцаа холбооны сүлжээ, цэргийн болон бусад үйл ажиллагаанд зориулсан байгууламж, төрийн үйлчилгээг үзүүлэхийн тулд захиргааны зорилгоор ашиглах бусад эргэлтийн бус биет ба биет бус хөрөнгө хамаарна.
- 18.2 Үйлчилгээний концессын хэлцэл нь янз бүрийн санхүүгийн баталгаа /үйлчилгээний концессын хөрөнгийн барьж байгуулалт, хөгжүүлэлт, худалдан авалт, сайжруулалтын ажлыг санхүүжүүлэхийн тулд эзэмшигчийн гаргасан өртэй холбоотой зээлийн баталгаа, барьцаа буюу алдагдал нөхөх баталгаа/ эсхүл гүйцэтгэлийн баталгааг агуулсан байж болно.

2. КОНЦЕССЫН ХӨРӨНГИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

- 18.3 Дараах тохиолдолд эрх бүхий этгээд нь эзэмшигчийн нийлүүлсэн хөрөнгө ба өөрийн одоо байгаа хөрөнгийн сайжруулалтыг үйлчилгээний концессын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.
- 18.4 Эзэмшигч тухайн хөрөнгөөр ямар үйлчилгээг, хэнд ямар үнээр үзүүлэхийг эрх бүхий этгээд нь хянадаг буюу зохицуулдаг,
- 18.5 Эрх бүхий этгээд нь үр шимийг хүртэх эрх болон тухайн хэлцлийн хугацааны эцэст уг хөрөнгөнд үлдэх аливаа мэдэгдэхүйц хувь оролцоог өмчлөлөөр дамжуулан буюу өөр бусад арга замаар хянадаг.
- 18.6 Хэрэв барьж байгуулсан эсхүл хөгжүүлсэн хөрөнгө нь дээрх нөхцлүүдийг хангаж байвал эрх бүхий этгээд нь уг хөрөнгийг стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ. Үйлчилгээний концессын хөрөнгийг хэзээ хүлээн зөвшөөрөх шалгуурыг УСНББОУС 17 ба УСНББОУС 31-ийн аль тохиромжтой стандартаар тогтооно. Дээрх стандартаар зөвхөн дараах тохиолдолд хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

- 1) Тухайн зүйлтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь уг байгууллагад орох нилээд магадлалтай байх;
 - 2) Тухайн зүйлийн өртөг буюу бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах.
- 18.7 Дээрх нөхцөл хангагдаж байвал үйлчилгээний концессын хэлцэлд ашигладаг хөрөнгийн хувьд түүний ашиглалтын хугацааны туршид мөрдөнө.
- 18.8 Эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгө нь хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байвал уг эрх бүхий этгээд нь тэрхүү одоо байгаа хөрөнгийг үйлчилгээний концессын хөрөнгө гэж дахин ангилна. Дахин ангилсан үйлчилгээний концессын хөрөнгийг УСНББОУС 17, УСНББОУС 31-ын аль тохиромжтой стандартын дагуу тайлагнана.

3. КОНЦЕССЫН ХӨРӨНГИЙГ ХЭМЖИХ БА ҮНЭЛЭХ

- 18.9 Үйлчилгээний концессын хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжинэ.
